

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
10 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 79
1. <i>Улсын Их Хурлын асуулгын цаг</i>	25 – 78
2. <i>Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай /үргэлжилнэ/</i>	78 – 79

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 31-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 78 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Баатархүү, Б.Бат-Эрдэнэ, Б.Заяабал, Х.Тэмүүжин;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Г.Дамдинням, С.Зулпхар, М.Нарантуяа-Нара, Ж.Энхбаяр, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Б.Батцэцэг, Б.Баярбаатар, Х.Болормаа, Х.Булгантуяа, Л.Гантөмөр, Л.Мөнхбаатар, Г.Очирбат, Б.Тулга, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Н.Алтанхуяг, Х.Баттулга, Л.Оюун-Эрдэнэ, А.Ундраа;

Хоцорсон: М.Бадамсүрэн – 19 минут, Б.Батбаатар – 09 минут, Н.Батсүмбэрэл – 11 минут, Б.Бейсен – 06 минут, Э.Болормаа – 01 минут, Д.Бум-Очир – 04 минут, Ж.Галбадрах – 2 цаг 42 минут, Д.Ганбат – 05 минут, Ц.Даваасүрэн – 38 минут, Т.Доржханд – 1 цаг 15 минут, Б.Дэлгэрсайхан – 25 минут, Д.Жаргалсайхан – 03 минут, Г.Лувсанжамц – 04 минут, М.Мандхай – 04 минут, З.Мэндсайхан – 17 минут, Б.Найдалаа – 03 минут, Н.Наранбаатар – 04 минут, Ч.Номин – 01 минут, Н.Номтойбаяр – 09 минут, С.Одонтуяа – 01 цаг 05 минут, О.Саранчулуун – 14 минут, Ч.Ундрэм – 08 минут, Н.Учрал – 07 минут, Б.Хэрлэн – 27 минут, Б.Чойжилсүрэн – 05 минут, Б.Энхбаяр – 02 минут, Р.Эрдэнэбүрэн – 48 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.3-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 7 гишүүнээс 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг татан авч байгаа албан бичиг ирүүлснийг танилцуулж, хуулийн төслүүдийг авсанд тооцов.

Хэлэлцэх асуудлын тов, дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Ж.Ганбат, Х.Баасанжаргал, А.Ариунзаяа, Ж.Батсуурь, Ж.Баярмаа, Ж.Батжаргал, С.Бямбацогт нар үг хэлэв.

Нэг.Улсын Их Хурлын асуулгын цаг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг нар байлцав.

Тусгайлан бэлтгэсэн индрээс Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар нар цуварсан асуулт, хариултаар мэтгэлцэв.

Мөн тусгайлан бэлтгэсэн индрээс Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө бичгээр ирүүлсэн гишүүд болох Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Ц.Мөнхтуяа, Д.Энхтуяа, Ж.Баясгалан, О.Алтангэрэл, Г.Хосбаяр, Д.Жаргалсайхан, Улсын Их Хурал дахь олонхын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Эрдэнэбат, Б.Уянга, Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Г.Уянгахишиг, Б.Найдалаа нарын тавьсан асуултад тусгайлан бэлтгэсэн индрээс Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 16 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай /үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Пүрэвдорж: 1.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 98

Бүгд: 101

3.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 100

Бүгд: 101

1.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 2.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 98

Бүгд: 101

3.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр

зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 98
Бүгд: 101
3.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 16 цаг 56 минутад хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 57 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 101 гишүүн ирж, 80.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
14 цаг 00 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Өнөөдрийн нийт ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн ирж, 56.3 хувиар 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 10 сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 4 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт нь, Улсын Их Хурлын асуулгын цаг.

Хоёрт нь, Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудал.

Гуравдугаарт нь, Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал.

Дөрөвдүгээрт нь, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг үргэлжлүүлэн хэлэлцэх тухай асуудал байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөлд хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Хоёрт нь, “Монгол Улсыг 2026-2030 он онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд тус тус хуваарилсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатад санаачилсан хуулийн төслөө татан авч болно гэж, 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль ч шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нарын гишүүдээс 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Хүсэлт хүргүүлэх тухай” Улсын Их Хурал 03/12415 дугаартай албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяа Танаа,

“Хүсэлт хүргүүлэх тухай”

Улсын Их Хурлын гишүүд бид Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Дээрх хуулийн төслийг дахин нягталж хууль хоорондын нийцлийг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт заасны дагуу татан авах саналтай байна.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Ц.Идэрбат, У.Отгонбаяр, Л.Соронзонболд гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 7 гишүүнээс 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг татан авсанд тооцлоо. /алх цохив/

Хэлэлцэх асуудалтай холбоотой. Яагаад гэвэл энэ хүнд бүрэн эрх байгаа. Хэлэлцэх асуудал өнгөрсөн долоо хоногийн тав дахь өдөр хэлэлцэх асуудлын тов гарсан. Гэвч хэлэлцэх асуудлаас зарим нэгэн зүйл хасагдаж, зарим асуудалд өчигдөр орой үдэш болсон хойно нэмж орж ирсэн байгаа.

Тийм учраас хэлэлцэх асуудалтай холбогдуулан 17.00 цагаас өмнө Их Хурлын гишүүд бүлгийн даргаар дамжуулж үг хэлэх зөвшөөрлөө авах ёстой.

Энэ асуудал нь 17.00 цагаас хойшоо хэлэлцэх асуудлын дараалалд эхний 3 асуудал орсон учраас Их Хурлын гишүүд чөлөөтэйгөөр хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотой асуулт асууж, үг хэлэх эрхтэй.

Очирбатын Амгаланбаатар гишүүн үг хэлье. С.Бямбацогт гишүүн.

О.Амгаланбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Би та хэдэд Монгол Улсын Үндсэн хуулиас хэд хэдэн зүйлийг уншиж өгье.

Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж байна.

Ингээд бид бүхнээр дамжуулсан.

Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Хүний эрх, эрх чөлөө гэдэг дээр 14 дүгээр зүйл дээр “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил эрхтэй гэсэн үг.

Дахиад Арван долдугаар зүйл дээр Монгол Улсын иргэн шударга, хүнлэг, ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ гэж байна.

Энэ дээр 1-д “Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж сахин биелүүлэх...” гээд байж байна.

Тэгээд Хорин гуравдугаар зүйл дээр “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гээд байж байна.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарсан. Манайхан.

Хорин есдүгээр зүйл дээр Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална. 2-т нь. 3-т нь Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно.

Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ гэж байгаа юм.

Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гараад Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа гэж байгаа юм. Улсын Их Хурлын дэд дарга гэж байхгүй шүү. Та хэд бүгд үзээрэй. Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг шийдвэр гарсан.

Тэгэхээр өнөөдөр Улсын Их Хурал Үндсэн хуулиа зөрчиж, өргөсөн тангаргаасаа няцсан Х.Булгантуяа гэдэг хүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах асуудлыг хэлэлцэхгүй бол Монгол Улсад хуулийн өмнө бүгд адил тэгш эрхтэй байх ёстой бол өнөөдрийн энэ Үндсэн хуулиа бүгдээрээ зөрнө.

Бид ард түмний өмнө юу хэлэх вэ? Ард түмэн өнөөдөр хууль нэг нь ч хэрэгжүүлэхгүй гэвэл та нар юу хэлэх вэ? Монголын ард түмэн биднийг өнөөдөр яагаад энэ төрдөө итгэх итгэлгүй болсон юм бэ гэх дээр яг өнөөдөр энэ Үндсэн хууль зөрчиж байгаа, би эмэгтэй хүн гэдгээрээ магадгүй давуу байдал олж байгаа, олохыг оролдож байгаа энэ этгээдүүдээс болж, өнөөдөр зарим Их Хурлын гишүүн эмэгтэй хүн болохоор нь битгий болиоч дээ чи гэж хэлж байх жишээний. Ийм байж болохгүй.

Тийм учраас өнөөдөр энэ Х.Булгантуяаг эгүүлэн татах асуудлыг хэлэлцэж өгөөч ээ. Энд оруулж өгөөч ээ гэсэн саналыг оруулж байна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би нэг зүйлийг бас тодруулж хэлэх нь зүйтэй байх.

Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг албан тушаалтантай холбоотой асуудлыг дэгийн тухай хуулийн 85 дугаар зүйлээр шийдвэрлэдэг. Энэ шийдвэрийн дагуу цэцийн дүгнэлтийг долоо хоногийн дотор хэлэлцэнэ гэж заасан байгаа.

Тэгээд долоо хоног гэдэг. 22-нд цэцийн шийдвэр гарсан. Аль хэдийн хугацаа нь 31 болон. Өнөөдөр чинь 8 дахь өдрөө болсон.

Тэгэхээр нэг зүйлийг тодруулж хэлэхэд өнөөдрийг хүртэл Их Хурлын даргын үүргийг би огт гүйцэтгэхгүй байгаа. Би зүгээр хуралдаан даргалагчийн үүрэг гүйцэтгэж байгаа.

Даргын дэргэдэх зөвлөлөөр цэцийн шийдвэрийн асуудлыг цаг хугацаандаа оруулах тухай асуудлыг өнөөдрийн даргын үүрэг гүйцэтгэж байгаа Х.Булгантуяа болон өнөөдрийн Их Хурлын тухай хууль дээр бүр албан ёсоор заагдсан Их Хурлын дэгийн зөвлөх ажилтай Б.Баасандорж нар энэ асуудлыг оруулж цаг хугацаандаа хэлэлцэх байсан. Гэвч харамсалтай нь нэг өдрөөр өнгөрсөн явж байгаа.

Тэгэхээр өнөөдөр яг энэ асуудлаар Дэд даргыг огцруулах тухай асуудал, Дэд даргыг сонгох тухай асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудалд орсон байгаа.

Энэ дээр та яг энэ намын бүлгээс нь Дэд даргаас огцруулах тухай санал нь орж ирсэн байж байгаа. Энд та өөрөө яг тэр цэцийн дүгнэлтийн дагуу өөрөө зарчмын зөрүүтэй санал гаргаад асуудалд Байнгын хороон дээр шийдвэрлүүлэх боломжтой гэдгээ хэлье.

Өөр асуулт асууж. Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат үг хэлье.

Д.Ганбат: Сая О.Амгаланбаатар гишүүн хуулийг үг үсгээр нь хэллээ. Уншиж танилцууллаа. Цэг, таслалгүй. Хэн нэгэн Х.Булгантуяадаа ч юм уу, С.Одонтуяадаа байгаа юм биш ээ.

Энэ чинь хууль дээдлэх, хууль сахиулах байна шүү дээ. Ийм асуудлыг бид эндээс шийдэж ярихгүй л юм бол цаашаа энэ чинь бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай гэж Үндсэн хуульд заасан байгаа. Үндсэн хууль маань ард түмэнтэй байгуулсан гэрээ шүү дээ. Үндсэн хууль дээгүүр хэн ч гишгэж болохгүй.

Тэгээд юу ч болоогүй юм шиг 7 хонолоо, 8 хонолоо. Та ч гэсэн хуралдаан даргалж л байгаа бол гүйцээ. Ажлаа хийх хэрэгтэй. Тэр Улсын Их Хурлын дарга гэдэг чинь ямар нэгэн онцгой эрх эдлээд байх юм байхгүй. Энэ 126-гийн нэг нь хурал удирдаад л явж байгаа. Ийм л юм байгаа.

Тэгэхээр хуулиа сахиулаад, хэлэлцдэг юмыг нь хэлэлцээд ингээд явахгүй бол энэ Монгол Улсад чинь хуулийг хэн биелүүлэх юм бэ? Бид л биелүүлэхгүй юм бол өөр хэн биелүүлэх юм? Тэр тусмаа Үндсэн хуулийг. Үүнээс цааш юу ч байхгүй шүү дээ.

Тэгээд хэн нэгэнтэй тал тохой татаад. Одоо бид ард түмэндээ очиж юу ярих юм. Ард түмэн үүнийг хараад юу бодоод сууж байгаа юм. Аан. Тэр ямар хамаатай юм. Тэрийг би яаж мэддэг юм. Эсвэл танай Монгол Ардын нам тарах л болж дээ.

Тийм юм байхгүй шүү. Хуулиа биелүүлье ээ, хуулиа сахъя аа. Тэгэхгүй бүх юм чинь хуулийн дээгүүр гишгэдэг хэн бэ. Хууль дээдлэх ёстой шүү дээ. Би юм ярьж байна. Чи дуугүй бол оо.

Төрийн байгуулалтын байнгын хороо гэдэг нь баахан залилангийн хөндий болсон л байсан биз дээ. Тэрийг чинь тэгээд Үндсэн хуулиар тогтоогоо биз дээ. Шүүх тогтооно гээд байсан. Тогтоосон юм биш үү. Өөр юу хэрэгтэй юм.

Үгүй ээ, энд одоо тэгээд яах юм. Бие биедээ сайн хүн болоод байх юм уу. Ард түмнийхээ өмнө бидний авсан амлалт хаана байна. Ийм юм байхгүй ээ. Үүний чинь төлөө л бид сууж байна шүү дээ.

Тэгээд яаж байгаа юм. Хууль сахиулъя гэсэн хүн ганц хоёрхон хүн цагаан хэрээ шиг бусад нь хэдэн хар хэрээ. Хэн хуулийн төлөө, хэн өргөсөн тангарагтаа үнэнч байгаа юм. Тэрийгээ ярихаар гадуурхагддаг. Ийм байж болох юм уу.

Үгүй ээ, бид талбай дээр гаръя л даа. Бид тэгвэл ард түмэнтэйгээ олуулаа шүү дээ. Хулгай луйвартайгаа.

Сайн санаалж хэлсэн юм уу, муу санаалж хэлсэн юм уу Үндсэн хуулийг чинь зөрчиж байна шүү дээ гээд хэлж л байсан шүү дээ. Шөнөжингөө алх бариад л нүдээд байсан биз дээ. Янз янзын юм яриад. Хурлаа ч нээгээгүй байж байж микрофоноор индэр дээр суусан.

Тийм эрхийг хэн олгосон юм. Тэрийг чинь цэц тогтоолоо шүү дээ. Өөр юу хэрэгтэй юм бэ. Тэгээд.

Тэгээд Үндсэн хуулийг зөрчсөн гээд гаргасан байна. Үндсэн хуулийг хэн зөрчсөн юм. Үндсэн хууль өөрөө зөрчигддөг юм уу. Тэрийг зөрчсөн эзэн нь байгаа шүү дээ. Юунд нь тэгээд долгиноод байдаг юм. Юунд нь одоо тэгээд.

Бид яах юм.

- ▶ Тэгээд хууль чинь хаана байгаа юм.
- ▶ Тэр шударга ёс чинь хаана байгаа юм.
- ▶ Тэр ардчилал чинь хаана байгаа юм.
- ▶ Парламент хаана байгаа юм.

Ингэж дүр эсгэхгүй ээ. Та хэд хулгай, луйвараа хоорондоо тохирдог байж болно. Ард түмэн та нартай тохирохгүй шүү. Үгүй ээ, нэг сандал ширээ, албан тушаалаа хуваагаад авчхаарай, тэр хулгайгаа наймаалцхаараа тэгээд болдог юм уу.

Энд чинь үг хэлдэг, ярьдаг, тэрийг чинь... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Д.Ганбат гишүүн нэгмөсөн авчих. 1 минутаа авчих.

Д.Ганбат: Баярлалаа. Хуралдаан даргалж байгаа хүн бол яг хуралдаанаа даргалсан шиг л даргалж байна.

Тэгээд хэдүүлээ яаяа, хэн чанга дуугарсан нь юм уу, хэн олуулаа бүлэрхсэн ч юм уу, тэгээд нэг албан тушаалдаа гарах, эрх мэдлээр 10 жил байхаараа тэрний нэг хэлтэрхий болоод даргадаа хүн сайн болбол Монгол Улсын Үндсэн хууль дээгүүр алхаж болно. Бид хэд нийлээд юуг ч зөрчиж болно. Бараг тосгоноороо нийлж байгаад санал хураагаад гараа өргөхөөрөө бараг зөв болно энэ тэр гэж бодоод байгаа юм уу.

Үндсэн хуулиас дээшээ гарахгүй ээ. Үндсэн хуулийн цаана юу ч байхгүй. Үндсэн хуулиа биелүүлэхгүй бол бид энэ ширээний ард ингэж суугаад хэрэггүй ээ. Хэрэв Үндсэн хуулийн эцсийн шийдвэр биелэгдэхгүй л юм бол энэ Засгийн газар чинь ч байхгүй, энэ Улсын Их Хурал чинь ч байхгүй. Хэн нэгэн гишүүндээ байгаа юм биш. Хэн нэгэн Их Хурлын дарга асандаа байгаа юм биш.

Тэгээд хэн нэгэн үүнийг хэлэхгүй бол... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: О.Амгаланбаатар гишүүн түрүүн 1 минутыг нь би анзаарсангүй. 1 минут нэмж хэлье.

О.Амгаланбаатар: Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж гэж тангаргаа өргөсөн.

Гэтэл энэ дээдлэн сахих ёстой Үндсэн хуулиа зөрчлөө. Хөөе. Энэ хүн болох боловсрол эзэмшээгүй залуучууд аа. Та нар хүн болох боловсрол эзэмшээгүй.

Эцэг эхийнхээ буянаар гадаад, дотоодод нэг сургууль төгсөөд, нэг хэлтэй болсныгоо мэдлэг гэж бодож байгаа бол андуурч байна.

Хүн юм ярьж байна. Та нар сонсож сур. Та нар том дуутайгаараа, та нар нүүрсний мөнгөөр хахаж цацсандаа орилж байх ёстой юм уу.

Хөөе. Та нар сая хэд хоног Үндсэн хууль зөрчиж байхад яав. Энэ танхимд суучхаад Монголын ард түмний өмнө Үндсэн хуулиа зөрчихгүй гэсэн гишүүдийг элдэвлэж, яаж бузарлаж байв. Өнөөдөр та нарын Үндсэн хууль... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Монгол Ардын намынхнаас үг хэлэх хүн байвал чөлөөтэй өгнө шүү.

Х.Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Бүгдээрээ Үндсэн хууль уншиж байх шиг байна.

Үндсэн хуулийн 66 дугаар зүйл дээр Үндсэн хуулийн цэц 4 асуудлыг хянан шийдвэрлэдэг. Түүний 2 асуудлыг нь Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэсэн.

Өөрөөр хэлбэл тогтоолыг Үндсэн хууль зөрчсөн гэсэн. Гишүүнийг Үндсэн хууль зөрчсөн гэсэн. Түүнээс гадна огцруулах үндэслэлтэй байгаа эсэхийг дахиад тусдаа шийддэг. Цэц. Энэ асуудлыг цэц шийдээгүй.

Огцруулах үндэслэлтэй гэдэг дүгнэлт гаргаагүй.

Тэгэхээр энэ асуудлыг бид энэ танхимд ярих ёсгүй. Нэгэнт Үндсэн хууль зөрчсөнтэй холбоотой үр дагаврын асуудлыг бид өнөөдөр энд ярих ёстой. Үр дагаврыг манайх бүлгээрээ гаргаад ярилцаад шийдвэрлэсэн энэ асуудлаа бид оруулж ирж байна. Нэгдүгээрт.

66 дугаар зүйлийн 2.4 дээр Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүний эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх гээд тусдаа цэц үүнийг шийддэг асуудал байгаа.

Цэц үүнийг чинь шийдээгүй. Цэц 3 дугаар зүйлээр нь дүгнэлт гаргасан. Нэгдүгээрт, үүнийг хэлэх ёстой байх.

Хоёрдугаарт, хэрвээ Үндсэн хууль зөрчсөн гэж байгаа бол 71 гишүүн бас энэ томьёоллоор санал өгсөн. 71-үүлээ Үндсэн хууль зөрчсөн.

Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа бол тэр санал хураалтад албан ёсоор оролцохгүй болохоо мэдэгдэж гарах үүрэгтэй байгаа. Энэ танхим дотор байгаа нэг ч гишүүн тэгээгүй шүү дээ. Бүгдээрээ зүгээр цахимаар л Үндсэн хууль зөрчиж байна гэж хэлснээс бүгдээрээ дэгийн тухай хуулийнхаа дагуу тэрийгээ албан ёсоор мэдэгдээд, ирцээсээ гарсан нэг ч гишүүн байхгүй шүү дээ.

Тэгээд худлаа гадаа гараад бүгдээрээ попорсон л биз дээ.

Тэгэхээр өнөөдөр манай бүлэг бүлгээрээ гаргасан шийдвэрээ дэмжиж байна. Би зөрчсөн гэж. Ойлгосон уу. 66.2.4 дээр тусдаа асуудал байгаа.

Тэгэхээр Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэж байгаа болбол та нар бүгдээрээ тэгвэл дэгийн тухай хуулийнхаа дагуу тэр өдөр гарахгүй яасан юм. Хэн ч гараагүй шүү дээ. Бүгдээрээ дэмжиж кноп зурсан. Бүгдээрээ кнопоо дарж дэмжсэн. 71-үүлээ зөрчсөн.

Дээрээс нь Улсын дээд шүүхийн шийдвэрийг биелүүлж байгаа хүн танай нам дотор байгаа юм уу. Бүлгийнхээ шийдвэрийг биелүүлж байгаа гишүүд танай нам дотор байгаа юм уу. Ийм сөрөг хүчин байдаг юм уу? Аан.

Хэрвээ сөрөг хүчин өнөөдөр сөрөг хүчин шиг байсан бол өнөөдөр парламент ийм байдалд орохгүй байх байсан. Та нар сөрөг хүчин биш. Та нар зүгээр эрх ашгийн нэгдэл, хуйвалдаан.

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут авах уу?

Тэгэхээр ер нь Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг. Өөрөөр хэлбэл дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлээр 95 дугаар тогтоолыг хэлэлцэх ёстой.

Х.Баасанжаргал гишүүн ээ. 84-өөр цэцийн дүгнэлтийг, 95 дугаар тогтоолыг хэлэлцэх ёстой.

Дээрээс нь дэгийн тухай хуулийн 85-аар албан тушаалтанд хариуцлага тооцох тухай асуудлыг бас хэлэлцэх ёстой.

Тэгээд энэ хоёр хоёулаа хойшлогдоод явж байгаа. Х.Баасанжаргал гишүүн ээ, та хамгийн түрүүн тэр 95 дугаар тогтоолыг хэлэлцэх тухай асуудлыг шаардах ёстой байхгүй юу. Тэр чинь цаг хугацаа нь хэтрээд л явж байна.

Тэгэхээр өнөөдөр даргын зөвлөл дээр чинь хэт олонх нь эсэргүүцдэг хүмүүс нь суугаад байна. Тэр даргын зөвлөлийг ахалж байгаа тэр дарга нь өөрөө асуудлуудыг оруулахгүй. Өнөөдөр Ж.Батжаргал гишүүн энд бүлгийнхээ асуудлыг оруулж ирэнгүүт нь би энэ дэд даргын огцруулах тухай асуудал Байнгын хороон дээр хэлэлцэх асуудлын хуваарьт ороогүй гээд хэлэнгүүт 30 минутын дараа томъёолоод Байнгын хороогоо хуралдуулна гэж байна.

Өөрөөр хэлбэл танай намынхан асуудлыг хүчээр шийддэг ийм хүмүүс байгаад байна.

Тэгээд энэ дэгийнхээ хуулийн дагуу юмаа явуулмаар байна. Тэгээд өөрсдийнхөө асуудал болохоор тэр даргын зөвлөл дээр маш хурдан санал хураалт явуулаад дэмжинэ, дэмжинэ гэдэг тийм онлайн маягаар хийгээд л асуудлаа шийдээд. Тэгээд энэ Их Хурлын чуулганы үйл ажиллагааг ямар ч гишүүдэд ойлгомжгүй, хэлэлцэх асуудлын дараалалд байхгүй зүйлийг урьд шөнө шийддэг. Дахиад өнөөдөр чуулганы хуралдаан нээгдэхээс 15 минутын өмнө асуудлаа оруулж ирээд Байнгын хороог хуралдуулна гэдэг ийм зүйлийг ярьдаг. Энэ чинь дураараа юм гэж бас байхгүй мэд ээ.

Тийм учраас өнөөдрийн асуудлыг би ямар ч байсан эхний ээлжинд энэ ирсэн бичгийг танилцуулна.

Өнгөрсөн долоо хоногт бас ямар ч тамгагүй 37 гишүүний гарын үсэгтэй Ж.Батжаргал гишүүнийг намын бүлгийн даргаар сонгох бичиг ирсэн. Үүнийг нь би эв нэгдлээ хангаад ир ээ. Нэг талдаа болоод ир ээ гэдэг энэ зүйлийг хэлээд буцаасан байгаа.

Нэг зүйлийг хэлэхэд бүтэн нэг жилийн туршид биднийг өнгөрсөн парламентын үед хоёр талд нь явуулж, бүлгийн даргагүй иймэрхүү нөхцөл байдал руу аваачиж байсан.

Тэгээд хамгийн сүүлд нь юу байдаг юм. Бараг сар гаруйн дараа О.Цогтгэрэл даргыг бид дотроосоо сонгоод болоод бүгд зөвшөөрөөд явсны дараа сар гаруйн дараа за Б.Пүрэвдорж оо, чи яг энэ О.Цогтгэрэлийг дэмжиж байна уу. Гараа өргө чи гэж байгаад намайг гарыг минь өргүүлж байгаад Г.Занданшатар дарга тэгээд алх цохиж байсан шүү дээ.

Тэгэхээр иймэрхүү байдлаар хэтэрхий их асуудалтай бидэнд хандаж байсан энэ зүйл чинь маш их эмзэг байсан.

Тийм учраас одоо өнөөдөр нэгэнт Та бүхэн бүгдээрээ 100 хувийн санал хураалтаар бүлгийнхээ даргын асуудлыг шийдээд ирсэн учраас би бүлгийн даргыг сонгосон тухай Монгол Ардын намын бүлгийн албан бичгийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж танаа,

Энэ уг нь өнөөдрийн даргын үүрэг гүйцэтгэж байгаа хүн чинь Х.Булгантуяа байгаа шүү. Х.Булгантуяа дээрээ хаяглах ёстой байсан.

2025 оны 10 сарын 30-н 164 тоот “Бүлгийн даргыг сонгосон тухай” Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн Б/24 дүгээр тогтоол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн даргаар сонгосон болохыг үүгээр мэдэгдье.

Хүндэтгэсэн бүлгийн дэд дарга А.Ариунзаяа гэсэн байна.

Бүлгийн даргаар сонгогдсон Ж.Батжаргал гишүүнд баяр хүргэе. /алга ташив/ Суудалдаа сууна уу.

Энэ хугацаанд бас заавал энэ бүлгийн даргыг уншсангүй. Өөрөөр хэлбэл бүлгийнхээ бүх гишүүдийн саналыг авч байж би бүлгийн даргын ажлыг хийнэ ээ гэдэг санаачилгыг гаргаж, Монгол төрийн тулхтай сайхан зан чанар гаргасан танд Ардчилсан намын гишүүдийнхээ өмнөөс бас баяр хүргэе. /алга ташив/

Бусад асуудал нь Байнгын хороо болон хуралдааны дараагаар шийдэгдэх учраас бусад огцруулах болон томилох тухай асуудал танилцуулагдахгүй.

Улсын Их Хурлын хуульд бичигдсэн дэгийн зөвлөх гэдэг хүн энэ асуудлыг надад бичиж ирж танилцуулсан.

Хуулийг А.Ариунзаяа гишүүн ээ, дураараа тайлбарлах тухай асуудал ерөөсөө байхгүй. Энэ өөрөөр хэлбэл Х.Булгантуяа гишүүнийг Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Байнгын хороо заавал хуралдах ёстой.

Хоёрдугаарт нь, тэр даргын үүргийг гүйцэтгэх асуудал дахиад бас Байнгын хороогоор шийдэгдэх ёстой. Ийм хоёр, гурван асуудал байгаа.

Тэгээд тэр хүнийг чинь чөлөөлсний дараа Ж.Бат-Эрдэнэ гишүүнийг томилох тухай асуудал яригдана. Чөлөөлөгдөөгүй байж байхад томилох тухай асуудал яригдахгүй.

Бид хэлэлцэх асуудлаа яриад дууссан.

Аюушын Ариунзаяа гишүүн үг хэлье.

А.Ариунзаяа: Б.Пүрэвдорж дарга аа.

Өчигдөр даргын дэргэдэх зөвлөл дээр Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх, Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлэх бүлгийн шийдвэртэй холбоотойгоор Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу бүлгээс санал гаргаад хэлэлцэх асуудлын тов дараалалд оруулаад явсан байгаа.

Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй тусдаа асуудлыг албан тушаалын гишүүний асуудлыг та хэд маань тусдаа яриад байх шиг байна. Намын бүлгийн эрх, үүргээр хэнийг дэвшүүлж, хэнд хариуцлага тооцуулж, яах вэ гэдэг эрх үүргийнхээ дагуу даргын дэргэдэх зөвлөл дээр саналаа гаргаад, өчигдөр хамтын шийдвэр гарч уг нь тов дараалалд ороод явсан асуудал байгаа. Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль дээр бүлгийн саналаар Улсын Их Хуралд танилцуулаад нээлттэй санал хураалт явагдах заалтууд байгаа.

Тэгэхээр Та хоёр асуудлыг хооронд нь хольж хутгахгүйгээр уг нь тов дараалалд орсон байгаа асуудлыг хэлэлцүүлээд явчихвал их талархах байна.

Түүнээс биш чуулганы индэр дээрээс А.Ариунзаяа чи хууль тайлбарлахгүй ээ гэж ярих нь өөрөө зохисгүй байгаа болов уу. Би процессыг ярьж байна. Хоёр асуудлыг хооронд нь холиод хэрэггүй. Өчигдөр манай намын бүлгийн ээлжит бус хурал болсон. Удирдах зөвлөлөөс маань ч гэсэн тодорхой чиглэл ирсэн. Бид хамтын шийдвэрийг гаргасан. Процессын дагуу даргын дэргэдэх зөвлөл дээр саналаа тавьсан. Хамтын шийдвэр гарч тов дараалалд оруулсан байгаа.

Тэгэхээр та үүнийг үгүйсгээд хэлэлцэхгүй ээ гэж хойшлуулах нь өөрөө бас Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийг зөрчиж байгаа болов уу гэсэн ийм бодолтой байна. Та жинхэнэ зөвлөгөө авах ёстой газраасаа аваад энэ асуудлыг шийдвэрлэж өгнө үү.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Байнгын хороогоор оруулахгүй саналтай байгаа юм байна.

Тэгэхээр өнөөдөр 13:35-д Ц.Сандаг-Очир гишүүн Байнгын хорооны дарга яг энэ Төрийн байгуулалтын хороо хуралдаж үүрэг хариуцлага өгөх тухай, өөрөөр хэлбэл дэд даргад үүрэг хариуцлага өгөх тухай болон цэцийн дэд даргыг огцруулах сонгохтой холбоотой асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэх тухай санал оруулж ирсэн.

Тэгэхээр таны яг тэр заалтын дагуу явах юм бол энэ Байнгын хороо хуралдахгүйгээр дараа нь Х.Булгантуяаг тусад нь хариуцлага тооцох тухай асуудал яригдана.

Хэрвээ Ц.Сандаг-Очир гишүүний үүгээр явах юм бол тэр Монгол Ардын намын бүлэг Үндсэн хууль зөрчсөн, манай Х.Булгантуяа дарга Үндсэн хууль зөрчсөн. Тэгэхдээ огцруулаад болно гэдэг ийм саналыг оруулж ирсэн байгаа. Дэд даргаас нь огцруулаад болно.

Тэгэхээр энэ бол нэлээн тийм хүндрээд яв магадлалтай л байна л даа.

Тэгээд ер нь танай намын, бүлгийн, дээрээс нь олон олон тэр хууль сайн мэддэг хүмүүсийн юугаар л энэ арай нэг жоохон нааштай байх юмыг л оруулж ирсэн юм уу даа л гэж би хараад байгаа юм. О.Амгаланбаатар гишүүний ярьж байгаа шиг биш. Арай гайгүй болох тухай.

Тэгэхээр та бол улам хүндрүүлэх гээд байна л даа.

Аюушийн Ариунзаяа гишүүн нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: Б.Пүрэвдорж дарга аа, өнөөдөр Ц.Сандаг-Очир гишүүний даргын дэргэдэх зөвлөл дээр оруулсан санал нь Улсын Их Хурлын даргын үүргийг гүйцэтгүүлэх, олонхын бүлгийн дэд даргад үүргийг нь гүйцэтгүүлэх ийм санал.

Тэгэхээр Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах, шинээр нэр дэвшүүлэх асуудалтай хольж Та болохгүй. Тэр бол тусдаа. Наана нь өмнө нь явах процесс учраас та үүн дээр нь бүлгийн шийдвэрийг хүндэтгэж Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийг мөрдөнө үү гэж хүсэж байна.

Би О.Амгаланбаатартай мэтгэлцээгүй.

Б.Пүрэвдорж: Би танд хууль дахиад тайлбарлаад өгье.

Өөрөөр хэлбэл цэцийн дүгнэлтийг долоо хоногийн дотор хэлэлцэж тухайн албан тушаалтанд хариуцлага тооцох тухай асуудал байгаа. Энэ асуудлыг хэлэлцэж тэр цэцийн дүгнэлтийн дагуу Х.Булгантуяад хариуцлага тооцох тухай асуудал яригдаж байгаа юм.

Тийм учраас үүнийгээ эхэлж хэлэлцэх ёстой. Бусдаар Их Хурлын бүлгийн шийдвэрийн дагуу, улс төрийн намын шийдвэрийн дагуу тэр цэцийн дүгнэлтийг хэлэлцэх тухай, хойшлуулах тухай асуудал ерөөсөө байхгүй.

Тэгээд хэлэлцэх асуудал. Ж.Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

А.Ариунзаяа гишүүн ээ, Х.Баасанжаргал гишүүн ээ, та хэд минь яасан ч дураараа юм бэ дээ.

Танай бүлэгт чинь өнөөдөр нөгөө С.Жавхлангийн “Яасан дураараа юм бэ” гэдэг дууг захиалаад өгмөөр санагдаж байх чинь. Харин.

Юу яриад байдаг юм бэ дээ. Сүүлийн нэг, хоёр сар Их Хурлаар тоглоод дууслаа. Тэгээд үүнийгээ зогсоо л доо.

Төрийн байгуулалтын байнгын хороонд хуралдаж байсан. 18.00 цагт болилоо гээд л больж байсан. Маргааш нь эхэлсэн.

Тэгээд даргын дэргэдэх зөвлөл хуралдахгүй гэж байсан. Хуралдсан. 15-хан минутад хуралдаад л нөгөө зогсчихсон Төрийн байгуулалтын байнгын хороо нь шууд үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд л. 50, 60-аараа гарын үсэг зураад л огцруулъя гэж байснаа Төрийн байгуулалтын байнгын хороон дээр очоод л огцруулахгүй гээд л. Тэгээд л дэмжээгүй саналаа дэмжүүлье гээд.

Ингээд бүтэн тал сар жүжиг тоглочоод, тэгээд одоо ингээд үйл ажиллагааг нь жигдрүүлээд өгье, цааш нь аваад явъя гээд тэгэнгүүт энд тэндээс нь барьж идэх гээд байдаг нь ямар учиртай юм.

Х.Баасанжаргал гишүүн чинь өөрөө хэлээд байна шүү дээ. Үндсэн хуулийн тодорхой заалтын нэгдүгээр нь тогтоол.

Хоёрт нь, Х.Булгантуяаг Үндсэн хууль зөрчсөн юм гэдгийг нотолсон юм.

Гурав, дөрөв дэхийг нь л хэлэлцэх юм гээд.

Үгүй ээ, тэгээд нотолсон л юм бол бидний өргөсөн тангараг дээр чинь Үндсэн хуулийн өмнө тавьсан дээр би Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиж, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, иргэнийхээ эрх чөлөөг дээдлэн хамгаалж, Монгол Улсын хөгжил, цэцэглэлтийн төлөө чин үндсээр зүтгэнэ. Хэрвээ би тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ ээ л гэсэн байна шүү дээ.

Тэгээд Х.Баасанжаргал чинь өөрөө хэлээд байна шүү дээ. Нэгд нь тогтоол зөрчигдсөнийг Үндсэн хууль тогтоосон.

Хоёрт нь, Х.Булгантуяа хууль зөрчсөнийг Үндсэн хууль тогтоосон гээд.

Тогтоосон бол би хуулийн хариуцлага хүлээнэ ээ, гишүүнээсээ татгалзана аа гээд бүгдээрээ бид чинь цуварч зогсож байгаад энд тангараг өргөсөн юм байгаа биз дээ.

Тэгээд дув дураараа нэг юм болонгуут ерөөсөө л дураараа. Өнөөдөр хэлэлцэнэ, ерөөсөө Төрийн байгуулалтын байнгын хороогоор орохгүйгээр хэлэлцэнэ. Эсвэл оруулдгаар хэлэлцэнэ. Ийм байдлаар явбал энэ нөхцөл байдал чинь эрэмбэлэгдэхгүй.

Бидэнд жилийн жилд төсвийг хоёр, гурван сар маш нухацтай хэлэлцдэг байсан. Энэ намар төсвөө хэлэлцсэн тохиолдол бидэнд бий юу? Тэгээд одоо 10 гаруйхан хоног үлдээд байж байна.

Тэгээд ийм нөхцөл байдал үүсэнгүүт одоо бүр буруу буруу бусдын буруу. Сөрөг хүчин яасан гэнэ вэ. Х.Баасанжаргал гишүүн ээ. Та нарыг алиагаа алдаад байхад чинь бид орж ирж харин эв дүйг чинь олуулж байгаа шүү дээ. Унасан дээр нь дэвсэлбэл дэвслэх л байсан шүү дээ. Яалгах гээд байгаа юм. Бид нараар.

Тийм болохоор ингэж дураараа байж болохгүй. Одоо өнөөдрөөс авхуулаад энэ Их Хурлаа горимд нь оруул. Засгийнхаа ажлыг хийлгэ. Төсвөө баталъя. Тэр цалин мөнгөө ямар эх үүсвэрээс өгөх гэж байгаа юм. Ямар эх үүсвэрээс танах гэж байгаа юм. Энэ нөхцөл байдлаа ярья л даа.

Тэгэхгүй хэчнээн өдөр, хэчнээн сараар маргасан маргаанаа энд ирж зогсоож болдоггүй юм уу.

Тэгээд А.Ариунзаяа гишүүнээс гуйж байна. Юм болгоныг л дураараа. Өөрөө тайлбарлана. Хуулиа уншихгүй. Үндсэн хуулиа дэвшилнэ. Тэгээд Үндсэн хуулийг духан дээрээ наачхаад ард түмэнд гангарна какарна. Өөрсдийнхнийгөө ч хайрлахгүй. Өөрийгөө ч хайрлахгүй. Сөрөг намаа ч хайрлахгүй. Монголын ард түмнийг ч хайрлахгүй. Яачихсан улс юм, та нар чинь. Одоо боливол яасан юм, та нар.

Тэгээд юм хэлэнгүүт яр яр гээд урдаг нохой шиг та нар. Та нарыг ч гэсэн үг хэлэхэд чинь хашхичаад байвал яах юм. Хэлүүлэхгүй байвал яах юм. Бишгүйдээ та нар 2016-аас 2020 он... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Жудагийн Баярмаа гишүүн үг хэлнэ.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Зөндөө л хэллээ л дээ.

Тэгээд би энд зүгээр хуулийг нь уншиж өгье л гэж бодлоо.

Ер нь манай Х.Булгантуяа дэд дарга маш өндөр боловсролтой, маш уг нь туршлагатай. Хоёр дахь удаагаа сонгогдсон ийм мундаг бидний хүндэтгэх ёстой улс төрч мөн.

Тэгээд харамсалтай нь Ардын нам маань хоёр хуваагдчихаад нэг хэсэг нь шахсаар байгаад Үндсэн хуулийг зөрчүүлсэн. Шахсаар байгаад. Нөгөө хэсэг нь битгий зөрчөөч ээ гээд зүгээр амаа цацтал энд гараад л хэлээд байх шиг байсан.

Тэгээд шөнөжингөө элдвээр дуудаад, эсвэл гарч хэвлэлийн бага хурал хийгээд нөгөө ирээгүй хүмүүсийг өчнөөн цоллосон шүү дээ. Мессеж ирсэн шүү дээ. Ална шүү “пэ” минь, ирж хуралдаа орооч ээ. Шөнөжингөө ирсэн шүү. Бараг дүүжилнэ шүү гэсэн мессеж шөнөжин ирсэн.

Өөрөөр хэлбэл Үндсэн хууль зөрчүүлэхийг дарамталсан. Одоо надад энэ мессеж нь байгаа. Тийм. Тагнуулд өгмөөр юм байна лээ. 80-тай утаснаас дүүжилнэ шүү. Очиж наад хоёрыгоо огцруул гээд. Ингэж их дарамт дунд бид ирсэн шүү.

Тэгээд яагаад биднийг юу яагаад байгааг ойлгохгүй байна.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр. Шийдвэр маш тодорхой гарсан байгаа шүү дээ. Дүгнэлт гэх юм уу.

Х.Булгантуяа гэж байгаад бүр ингээд 1, 2 гээд заасан байна шүү дээ.

Нэгд нь, Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нь Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг даргалахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн тийм тийм юм, нөгөө бидний амаа цуцтал ярьсан 43.1. Үүнийг зөрчсөн нь тогтоогдсон гээд ингээд бичиж.

Тэгэнгүүт дахиад нөгөө Үндсэн хууль дээр чинь юу гээд бичсэн байна вэ гэхээр одоо энэ Х.Булгантуяаг яах вэ гэдэг асуудал яригдаад байна л даа.

Тэгэхээр юу гээд бичсэн байна вэ гэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9.3-аар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гишүүнийг тангаргаасаа няцаж, Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргавал Улсын Их Хурал хүлээн зөвшөөрч, түүнийг нь эгүүлэн татах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ гээд.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяаг цэц тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн гээд дүгнэж үү. Дүгнэсэн байна шүү дээ. Би сая уншлаа. Дүгнэлээ л бол Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ гээд 9.3-аар заасан байна.

Тэгэхээр одоо Улсын Их Хурлын бүрэн мэдэлд байгаа. Эгүүлэн татах эсэхээ бид шийднэ. Татахгүй ч байж болно шүү дээ. Хамгийн гол нь.

Нэгд, хамгийн гол нь хуулиа дагаад хэлэлцэх ёстой. Үлдээх эсэхээ дахиад бид шийдэх ёстой. Түүнээс биш манай бүлэг шийдсэн юм гээд.

Тэгээд танай бүлэг Үндсэн хуулийн дээр гараад шийдвэр гаргаад бид хэрэгжүүлэх ёстой юм бол энд Их Хурал байх хэрэгтэй юм уу? Танай бүлэг ер нь цаашдаа аваад явах ёстой юм биш үү. Бараг энэ Их хурлаа. Эсвэл 71-үүлээ Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа юм бол тэр 71 гишүүнээ Үндсэн хуулийн цэцэд өгөх хэрэгтэй.

Тэгээд хэрвээ үнэхээрийн зөрчил нь тогтоогдвол 71-үүлээ таръя. Үндсэн хууль зөрчиж энд суугаад байх хэрэг байхгүй шүү дээ.

Дараагийн нэг асуудал. Үгүй ээ, би бас нэг юм гайхаад байх юм. Одоо ингээд эвлээд нэгдээд байгаа юм уу. Тэгэнгүүтээ тэгээд энэ бүх Үндсэн хуулийн зөрчил чинь ингээд хамаагүй болчхож байгаа юм уу?

Өчигдөр Та бүхэн шийдвэр гаргаад ингээд нэг нь бүлгийн дарга, нэг нь Их Хурлын дэд дарга болж байгаа юм байна.

- ▶ Тэгэх юм бол танай бүлгийн шийдвэр цаашид бүх зүйлийг шийдээд явах юм уу?
- ▶ Тэгвэл цөөнх байх хэрэгтэй юм уу?

гэдэг асуултыг би бүр зориуд дахиж асуумаар байна.

Тэгэхээр Х.Баасанжаргал гишүүн бол түрүүн тусад нь буюу Үндсэн хууль зөрчсөн эсэх дээр Х.Булгантуяа дээр шийдвэр гаргах ёстой гэж хэлсэн бол “Үгүй”.

9.3-аар нэгэнт Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдох юм бол эгүүлэн татах эсэхийг шийднэ ээ гээд заасан байгаа. Тэгэхээр та өөрөө хуульч хүн. Энэ хуулиа бас үзэх хэрэгтэй.

Б.Пүрэвдорж: Шинээр томилогдсон бүлгийн дарга Жигжидийн Батжаргал үг хэлнэ.

Ж.Батжаргал: Их Хурлын гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хууль тогтоох парламентын засаглал хууль дээдэлж ажиллах ёстой. Бид. Тэгэхдээ ярьж байгаа юмнуудаа бас жоохон зааг ялгаатай ярьцгаах ёстой. Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол ард түмний мандат. Үүнийг сонгууль зохион

байгуулж явуулдаг байгууллага сонгуулийнхаа дүнг Их Хуралд танилцуулаад тэнд бүрэн эрх хүлээн зөвшөөрөгддөг.

Их Хурлын дэд дарга гэдэг бол Улсын Их Хуралд бүлэгтэй улс төрийн хүчнүүд өөрсдөө саналаа гаргаж Их Хуралдаа оруулж ирж дэд даргаа томилуулдаг, сонгуулдаг.

Тийм учраас Монгол Ардын намын бүлэг Улсын Их Хурлын гишүүн, бүлгийн гишүүн Х.Булгантуяаг ажлын туршлага, чадамжийг нь үнэлж улс төрийн дэмжлэг үзүүлж Улсын Их Хурлын дэд даргаар сонгуулсан юм.

Үндсэн хуулийн цэц зөрчил гаргасан байна гэж дүгнэлээ.

Тийм учраас намын бүлэг өөрийнхөө дэмжлэг үзүүлсэн албан тушаалаас нь огцруулж байгаа юм. Энэ асуудал Улсын Их Хурал дээр Байнгын хороогоор ордоггүй. Шууд намын бүлгийн санал чуулган дээр танилцагдаад, Их Хурлын гишүүд саналаа өгөөд энэ асуудал шийдэгддэг.

Нэгэнт Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг буюу олонх өөрийнхөө дэд даргыг огцруулсан бол хуульд заагдсаныхаа дагуу бид Их Хурлын дэд даргаа томилуулах нэр дэвшүүлэлтээ хийсэн. Үүнийгээ мөн Улсын Их Хуралдаа өргөн мэдүүлсэн, уламжилсан.

Тийм учраас Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлсэн хүний талаар бас энд ярилцаж санал хураалт явуулж сонгох учиртай.

Наад яриад байгаа цэцийн дүгнэлттэй холбоотой асуудлыг энэ Их Хурлын өөрийнх нь бүрэн эрхийн асуудал. Энд асуудлаа ярих ёстой. Түүнээс намын бүлэг санал оруулах боломжгүй. Манай намын бүлэгт тийм эрх байхгүй. Бид тухайн хүнд үзүүлсэн улс төрийнхөө дэмжлэг, өөрийнхөө бүлгийн квот дээр байгаа Их Хурлын дэд даргынхаа асуудлыг л ярьж байгаа үйл явц гэж ингэж зориуд хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Би нэг зүйлийг хэлье л дээ. Одоо ингээд та нарын хүсээд байгаа зүйл бол дэд даргаа огцруулаад, дэд даргаа томилоод. Тэгээд томилонгуутаа энэ дээр би уншаад танилцуулах юм бол томилонгуут нөгөө Х.Булгантуяагийн тэр нөгөө даргын үүрэг гүйцэтгэх тэр эрх чинь над дээр хүрч ирэх гээд байгаа байхгүй юу даа.

Тийм учраас үүнийг чинь бүгдийг нь нэг мөсөн шийдээд өгье гэж байна шүү дээ.

Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэцийн дагуу Х.Булгантуяа даргыг огцруулах тухай асуудлыг хэлэлцье. Тэр дээрээ тэр цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал зөвшөөрөхгүй бол аливаа нэгэн шийдвэр гарахгүй шүү дээ. Тэр

Х.Булгантуяагаа та нар аваад үлдэнэ үү, тэр Их Хурлын Байнгын хороо болон чуулганы санал хураалтаар шийдэгдэнэ.

Тэгэхээр одоо ингээд би үүнийг эхлээд танайхан чинь, Ц.Сандаг-Очир дарга болохоор зөв явуулъя гээд байна шүү дээ.

Өөрөөр хэлбэл цэцийн юуны дагуу Их Хурлын даргаа огцруулах тухай асуудал. Тэгээд нөгөө бүрэн эрхийг юу шинээр бүлгийн юу Их Хурлын дэд даргаа сонгох тухай асуудал. Тэгээд бүрэн эрхийг шилжүүлэх тухай асуудлыг ингээд гурвууланг нь шийдээд явъя гэж байна шүү дээ. Үүний чинь дагуу хийчихье гэх дээр заавал уншиж танилцуул гээд ингээд байх юм.

О.Амгаланбаатар аа, чи дураараа ярихгүй. Өөрөөр хэлбэл энэ чинь асуулт чинь 5 минут. Чамд харин нэгийг өгсөн. Одоо дахиж ярихгүй. Дахин битгий яриад.

Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Бид нэг жоохон дэггүй л яваад байна л даа. 2020 оноос өмнө.

Б.Пүрэвдорж: Уучлаарай. Дэггүй явж байгаа үндсэн шалтгаан нь бол өчигдөр шөнө гурван асуудлыг танай бүлгийнхэн чинь оруулж ирээд шөнө дунд хэлсэн.

С.Бямбацогт: Хуралдаан даргалагчаа би үгээ хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгээд дээрээс нь энэ хүссэн хүмүүс чинь 5 цагаас. Би чамд шинээр үг өгнө.

С.Бямбацогт: Хуралдаан даргалагчаа шинээр өгчхөөрэй.

Б.Пүрэвдорж: Тийм. 5 цагаас өмнө эд нар чинь нөгөө нэг дэгтэй, юу хэлэлцэх асуудалтай холбоотой үгээ хэлэх гэсэн чинь тэр хэлэлцэх асуудал нь байхгүй байж байхад л гэнэтхэн 3 асуудал ороод ирэхээр энэ хүмүүс чинь чөлөөтэй үг хэлэх эрх нь нээгдэж байгаа.

Өөрсдөө ингээд бас нэг ийм даргын зөвлөл дээр нэг жоохон цаг нартай, хугацаатай, тэр цэцийн дүгнэлтийг долоо хоногийн дотор хэлэлцэх ёстой. Тэр зүйлээ шийдвэрлээд явсан бол ийм асуудал гарахгүй байхгүй юу даа.

Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Даргын зөвлөлд би байдаггүй болохоор юу болсныг сайн мэдэхгүй.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаан 10.00 цагаас эхэлдэг. Хэлэлцэх асуудлаа танилцуулдаг. 2020 оноос өмнө хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлж байна гээд үндсэндээ чуулган эхлэх гээд бүтэн 2 цаг яг өнөөдрийнх шиг юм болдог байсан юм. Ийм процесс. Тэгээд л баахан шоудаж байгаад л хоёр талдаа баахан хэрэлдэж байгаад л яг асуудлаа хэлэлцээд эхлэхээр хэн ч байхгүй болдог.

Үүнийг 2020 оны Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулаад Их Хурлын гишүүд чуулганы хуралдаан дээр хэлэлцэх асуудалтай холбоотой санал байх юм бол урд өдрийн 17 цаг 30 минутаас өмнө саналаа бичгээр өгнө гэж зохицуулсан.

Үүнийг бид 2025 онд дахиад Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн даргаараа дамжуулж зөвхөн бүлгийн дарга нь үг хэлнэ гэж улам хязгаарласан. Ингэж уг нь бас энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг дэгтэй, журамтай, бас нэг хуулиа дээдэлдэг, попордог биш болгох гэж ийм өөрчлөлт хийсэн юм.

Гэтэл үндсэндээ өнөөдөр 2020 оны өмнөх рүүгээ буцаад орсон.

Тэгээд л хэлэлцэх асуудалтай холбоотой дуртай нь үгээ хэлдэг ийм болчихоод байна.

Хэлэлцэх асуудлын 3, 4 дээр Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх томилох асуудал байж байгаа. Тэр асуудлыг хэлэлцэх үед л энд ярьж байгаа зүйлээ яримаар байгаа байхгүй юу. Одоо хэлэлцэх асуудалдаа ороод Ерөнхий сайдын мэдээллийн цаг Баасан гарагийн 14.00 цагаас эхлэх ёстой. Одоо ингээд 14 цаг 50 минут болж байна. Үүнийгээ эхлээд явмаар байна. Араас нь тэр 2, 3 дахь асуудал дээр байгаа Улсын Их Хурлын дэд даргыг томилох, чөлөөлөх дээр гишүүд маань тэр асуудал дээр санал бодлоо хэлээч ээ. Үүнийгээ хурдан шийдээд явъя.

Тэр үедээ Үндсэн хууль зөрчсөн, зөрчөөгүй, чөлөөлөх нь зөв буруу. Их Хурлын дэд дарга томилох нь зөв, буруу. Энэ асуудлаа ярья.

Тийм болохоор хуралдаанаа жоохон ажил хэрэгч болгоод цаашаагаа үргэлжлүүлээд яваач ээ.

Монгол Ардын намын бүлэг Үндсэн хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу дэд даргаа чөлөөлөх, томилох асуудлаа оруулаад ирсэн. Одоо үүнийг Байнгын хороон дээр биш чуулган дээр хэлэлцээд явна.

Одоо ингээд асуудлаа хаавал яасан юм бэ. Б.Пүрэвдорж дарга аа.

Б.Пүрэвдорж: Хэлэлцэх асуудалдаа орьё.

Улсын Их Хурлын асуулгын цаг. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Улсын Их Хурлын асуулгын цаг

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах Улсын Их Хурлын асуулгын цаг эхэллээ. /алх цохив/

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл болон Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нарыг тусгайлан бэлтгэсэн индэрт урьж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн асуултыг тавьж мэтгэлцэнэ.

Бүлгийн цуварсан асуултын тоог 9-өөс хэтрүүлэхгүй асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна. /алх цохив/

Асуултаа асууж мэтгэлцье.

О.Цогтгэрэл: Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын асуулгын цагийн хоёр дахь дугаар эхлэх гэж байна.

Тэгээд энэ удаа бид “Дундаж давхаргын тухай”, Монгол Улсын дундаж давхарга яагаад сүүлийн жилүүдэд хавчигдаад байна вэ. Энэ нь төрийн бодлогын алдаа хаанаа гараад байна вэ гэдэг сэдвийн хүрээнд явуулахыг хүссэн.

Ер нь төрийн бодлого гэдэг өөрөө, улс орны хөгжил дэвшил гэдэг өөрөө ядуу иргэдээ дундаж давхарга руугаа, дундаж давхаргад байгаа иргэдээ чинээлэг хэсэг рүүгээ оруулахад төрийн бодлого маань чиглэх ёстой гэж боддог.

Гэтэл сүүлийн жилүүдэд нөхцөл байдал юу болж байна вэ? Би хоёрхон зураг харуулъя. Уг нь зөв жишгээр улс орны хүн амын бүтэц, орлогын бүтцээр харахад ядуурлын түвшинд байгаа иргэд нь тодорхой түвшинд, дундаж давхарга нь үүнээсээ илүү их. Ингээд дээрээ чинээлэг, баян хэсэгтэй гээд байдаг ёстой юм байна. Энэ рүү төрийн бодлого чиглэх ёстой юм байна.

Гэтэл яг өнөөдөр байгаа манай Монгол Улсын хүн ам зүйн бүтэц, эдийн засгийн бүтэц яг ийм нэг хавчигдсан лонх шиг, элсэн цаг шиг юм болоод байгаа.

Доод суурь нь тэр чигээрээ гуравны нэг нь ядуурлын байдалтай. Дахиад гуравны нэг нь дундаж гэж байгаа хэсгийнх нь доод хэсэг нь гуравны нэг нь дахиад ядууралд маш ойрхон ийм түвшинтэй буюу энэ улаан нь нийлээд Монгол Улсын хүн амын гуравны хоёр нь.

Ийм байдлаар дундаж давхарга маань хавчигдаад ийм байдалтай байгаад байгаа юм.

Тэгэхээр эндээс асуух асуулт. Яагаад нөхцөл байдал ийм болов оо? Өнгөрсөн 30 жилд, тэгээд өнгөрсөн 9, 10 жилийн бодлогын алдаа яагаад дундаж давхаргыг ингэж хавчаад, дундаж давхаргыг тэлэх бодлогыг 9 жил эрх барьж байгаа Монгол Ардын нам дундаж давхаргыг хавчих бодлого руу бараг санаатай гэмээр бодлого явагдаад байна вэ? Энэ дээр тодорхой байр суурь хариулт өгөөч ээ.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дэд дарга, гишүүдийн өнөөдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Өнөөдөр их чухал асуудал хөндөж байна. Дундаж давхарга.

Дундаж давхарга бол дийлэнх монгол зон олон байх ёстой. Тэгэхдээ харамсалтай нь өмч хувьчлалаас эхлээд манай эдийн засгийн бодлогын тэнцвэр алдагдсан, эдийн засгийн бүтэц алдагдсан, үйлдвэрлэгч ажиллах хүчин, үйлдвэрлэх хүчин алдагдсанаас болсноос шалтгаалсан.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын эдийн засгийн бүтэц үндсэндээ уул уурхайгаас хэт хамааралтай, аж үйлдвэржилт багатай болсон. Дундаж давхарга бол ажилчин анги. Дээр нь хамгийн гол дундаж давхарга эмч, багш нар.

Тэгтэл үндсэн 1992 онд өмч хувьчлалын дараа 480 мянган хүн ажлын байргүй болж тухайн үеийн 4800 үйлдвэр, аж ахуйн газруудыг хувьчилж, үндсэндээ дампуурал руу шилжиж, ажилгүй болсноос өгсүүлээд манай хөнгөн үйлдвэр хөдөө аж ахуйн эдийн засаг байсан бол манай улс үндсэндээ уул уурхай эдийн засагтай улс болж энэ ажлын байр шингээдэг дундаж давхаргын хамгийн гол ажлыг тэтгэдэг тэр үйлдвэрлэлийн салбар унаснаас шалтгаалсан. Энэ бол үндсэндээ –

- манай гадаад худалдааны бодлого,
- дэлхийн худалдааны байгууллагад элссэн бодлого,
- импорт, татварын бодлого,
- мөнгө, зээлийн бодлогын

энэ цогц шийдлүүд үндсэндээ 30 жил буруу томъёоллоор, зохицуулалтгүйгээр явснаас болж Монгол Улсад дундаж давхарга үндсэндээ багассан.

Албан ёсны статистик тооцоогоор 48 хувийн дундаж давхаргатай гэж тооцож байгаа. 2022 оны статистикаар нийт иргэдийн 27 хувь нь буюу бараг гуравны нэг нь ядууралтай байна гэж тооцоо гарсан. 2024 оны статистик буурч гарч байгаа гэж сонссон. Тэгэхдээ аль зэрэг энэ маань бодитой гэдэг нь ердөө ядуурлыг 485 мянган төгрөгөөс доош орлогыг ядуу гэж тооцож байгаа.

Тэгэхээр энэ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмэлт 1 минут.

Г.Занданшатар: Дундаж давхарга тэгэхээр үндсэндээ их эмзэг байна. 60 орчим хувь нь дундаж давхаргад хамаарч байгаа гэсэн дүгнэлттэй боловч хамгийн ноцтой нь Дэлхийн банкны тооцооллоор инфляц 10.3 хувь болж 1 хувиар нэмэгдэхэд 350 мянган иргэн инфляц, зээлийн дарамтаас үүдэн ядууралд шилжинэ гэсэн эрсдэлтэй байгаа нь гол сорилт юм.

Ийм учраас л бид одоо энэ эдийн засгийн бүтцээ өөрчлөх, 20 жилийн 5 жилийн үндсэн чиглэлийг өнөөдөр өргөн барьж байгаа.

2026-2030 онд хөгжүүлэх эдийн засгийн бодлогоор “Шинэ итгэл, эрс шинэтгэл” гэж –

- ▶ эдийн засгийн бүтцээ өөрчилж,
- ▶ ажлын байрыг нэмэгдүүлж,
- ▶ дундаж давхаргаа өргөжүүлж,
- ➔ хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн, халамжаас хөдөлмөрт шилжсэн татварын реформ,
- ➔ зээлийн реформ,
- ➔ аж үйлдвэржилтийн реформ,
- ➔ эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, дижитал шилжилт гэсэн цогц реформ

хийж байж дундаж давхаргаа өргөжүүлэх цогц реформын бодлогыг бид Улсын Их Хуралд өргөн барьж байна.

Б.Пүрэвдорж: Микрофонуудыг шууд шууд явуулаарай.

О.Цогтгэрэл: Харин тийм ээ.

Тэгээд та дундаж давхаргыг дэмжих бодлого өнгөрсөн 30 жилд, сүүлийн 10 жилд байсангүй гэж байна. Яагаад бодлого маань энэ байдал дээр очов оо? Яг Монгол Улсын төрийн бодлогын шийдвэрүүд дээр дундаж давхаргыг тодорхойлсон, энэ рүү чиглэсэн, тэр тусмаа танай намын мөрийн хөтөлбөр болоод Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүдэд ямарваа нэгэн баримт бичиг байхгүй. Ямар ч зорилго, зорилт байхгүй. Үүнийг тэд байгааг тэд болгоно.

Бодлогын арга хэрэгслүүд ингэж чиглэнэ гэсэн ямарваа бодлого хэрэгсэл байхгүй ийм л байдалтай. Одоо буруутан нь хаана байна вэ гэвэл.

Тэгээд би ганц хоёрхон тоо хэлье. Өнгөрсөн 20 жилд уул уурхай болоод байгалийн баялгаас монголчууд 100 тэрбум долларын орлого олжээ. 100 тэрбум долларын орлого олсон байна.

Энэ мөнгө, эдийн засгийн өсөлт гэж байгаа энэ мөнгө хаачив аа? Яагаад иргэдэд хамааралгүй, хүртээмжгүй бодлогын арга хэрэгслийг өнгөрсөн хугацаанд зохиож явав?

Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын 5 жилийн төсвийг нийлүүлбэл 100 их наядын төсөв зарцуулсан. 100 их наяд төгрөгийн 5 жилийн дундаж төсөв. Өнгөрсөн жилийнх 35, 36 их наяд руу явсан. Зөвхөн 1 жил нь.

5 жилээр 100 их наядын төсөв зарцуулсан. Энэ төсвийн зарцуулалт 100 тэрбум долларын байгалийн баялгийн орлого саяын дундаж давхаргыг нэг хувиар ч нэмдэггүй.

- Танай Монгол Ардын намын 2016 оны мөрийн хөтөлбөр дээр байсан. Ядуурлыг бид 2016-2020 онд хоёр дахин бууруулна гэж байсан.

Тэр ядуурлын хоёр дахин буурч байгаа чинь уг нь дундаж давхарга руу шилжих ёстой байсан.

Гэтэл сүүлийн 10 жилд саяын тэр 100 тэрбум доллар, 100 их наяд төгрөг эцэст нь төрийг данхайлгаж, төрийн өмчит компанийг данхайлгаж, эцэст нь нүүрсний хулгайдаа идэгдсэн, баригдсан ийм улс орон, оффшор, байгалийн баялаг нь гадагшаагаа гардаг. Дундаж давхарга нь хавчигдсан.

Тэгэхээр энэ бодлогын хүртээмжгүй өсөлтийг яаж засах ёстой юм бэ?

Г.Занданшатар: Тэгээд энэ цөөхөн минутад яагаад гээд арагшаа яриад тоочих юм бол маш олон асуудал хөндөх учраас амжихгүй.

Уул уурхай эдийн засаг бол, уул уурхай бол капитал их шаарддаг, ажлын байр бага шаарддаг ийм салбар. Хөдөө аж ахуй бол ажлын байр илүү бий болгодог, хөрөнгө оруулалт харьцангуй бага шаардаж байгаа ийм салбар.

Гэтэл энэ бүх харьцаа маань өөрчлөгдсөн. Уул уурхайн салбарын ид өсөлтийн үед манайх үүнийгээ баян айлын эрх хүүхэд шиг үрэлгэн зарцуулснаас өнөөдрийн энэ данхайсан төсөв, өнөөдрийн энэ төсвийн алдагдал, инфляц, өр ханшийн алдагдал чинь бий болоод байна.

3 жилийн өмнө нүүрсний үнэ –

- 2024 онд эхэлж байх үед чинь 325 доллар байсан.
- Ноднин жил энэ өсөлтийн үед 150 доллар байсан.
- Одоо 70 доллар болоод хоёр дахин уналаа. Гурав дахин уналаа.

Ийм их эрсдэлтэй үед энэ Засгийн газар, 3, 4 сар ажиллаж байгаа манай Засгийн газар энэ 30 жилийн алдааг чинь, 3 жилийн алдааг чинь бүгдийг нь нэг өдөр өргөс авсан юм шиг засаж чадахгүй.

Гэхдээ бид өнөөдөр өргөн барьж байгаа 5 жилийн үндсэн чиглэлийн төсөлд дундаж давхаргын баталгаатай хангах системийг системтэй реформыг тусгасан.

Энэ эрс шинэчлэлийн реформын гол зорилт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажил хөдөлмөр эрхэлж байгаа бүх хүмүүсээ дэмжиж, зохистой хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг сайжруулснаар дундаж давхаргын эзлэх хувийн жинг 20 хувиар нэмэгдүүлнэ.

2026 онд дундаж давхаргын эзлэх хувийг тооцож, тэр түвшнөөс 20 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан. Цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулах бодлого хэрэгжүүлж багш, эмч нарынхаа цалинг бодитой нэмэгдүүлбэ.

Өнгөрсөн 3 жилд төсвийн орлого ийм их 100 тэрбум доллар таны хэлснээр зарцуулж орж байхад багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлээгүй юм билээ. Өнөөдөр 3 жилийн дараа гэнэт 30 хувь, 40 хувиар, 50 хувиар нэмэгдүүл гэж шаардаж байгаа юм. Ганцхан жилийн дотор. Өнөөдөр энэ эдийн засгийн өсөлтийн үед.

Орон сууц, амьдралын чанар, орон сууцжуулалтын банк байгуулах, хүртээмжтэй орон сууц, иргэддээ хүртээмжтэй эдийн засгийг бий болгоод өгнө. Уул уурхайн эдийн засаг маань цөөнхөд хүртээмжтэй, ард түмэндээ өгөөжгүй эдийн засаг байна. Яагаад гэвэл тэнд хулгай байна.

Ийм учраас баялгийн хулгайтай тэмцэж байж энэ уул уурхайн өгөөж... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Тийм. Тэр дундаж давхарга тэлэхгүй байгаагийн, улам ядуураад байгаагийн үндсэн шалтгаануудын нэг нь энэ үнийн өсөлт.

Эдийн засгийг нэмж байна гэдэг, цалин нэмж байна гэдэг. Үүнээс чинь илүү үнийн өсөлт үүний цаана л өнгөрсөн хугацаанд яваад байгаа.

Сүүлийн жилүүдийг харахад сүүлийн 4 жилд байна уу, 4, 5 жилд дунджаар үнийн өсөлт 70 гаруй хувьтай. Тооцооллын аргачлалаас үүнээс ч их байх боломжтой.

Тэгэхээр ийм үнийн өсөлт нөгөө талд нь. Үнийн өсөлт гэдэг чинь юунаас үүсэлтэй вэ Төрийн зардлаас л үүсэж байгаа. Бизнесүүдэд мөнгө очихгүй байгаа. Бизнесүүдэд эрх чөлөө байхгүй. Тэнд төрийн зохицуулалт их. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн зарцуулалт их байгаа учраас тэр ЖДҮ-нүүд нь босож чаддаггүй.

Уг нь эдийн засагт байгаа нийт ажлын байрны бараг тодорхой тоог хэлбэл 64 хувийг жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар нь уг нь бий болгодог юм гэнэ лээ. Болгож хамаардаг.

Гэтэл тэр салбараа хавчсаар байгаад тэр салбар нь ядуурлын ангид ороод тэнд байсан дундаж давхарга гэж байгаа нийгмийн бүлэг байхгүй болж хувирч байгаа. Нөгөө ажлын байр бий болгож байгаа жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа.

Тэгэхээр үүний цаана чинь л тэр дахиад үнийн өсөлт. Үнийн өсөлт гэхээр Засгийн газар энэ болбол Засгийн газарт хамаагүй. Монгол банкны асуудал гээд түлхдэг. Яг үнийн өсөлтийг өдөөгч нь Засгийн газар өөрөө. Төрийн зардал, төсвийн зардал, төрийн өмчит компаниуд үүний цаана л нөхцөл байдал дээр яг ийм л байгаа.

Тэгээд одоо ингээд ажил ярихаар танай Засгийн газар бид 4 сар болж байгаа гэдэг. Яг үнэндээ 2024 оны Монгол Ардын намын олонх болсон Засгийн газрын мөрийн хөтөлбөр хэрэгжиж байгаа гэж л бид бүгд үзэж, ард түмэн та нараас тэр зүйлийг чинь л хүлээж байгаа байх. Энэ нь тэрний үүний Засгийн газар биш. Танай намыг сонгосон хөтөлбөр үүний цаана чинь явж байгаа.

Тэгэхээр Засгийн газраас энэ үнийн өсөлтийг өдөөчхөөд, бий болгочоод үүнийг өөр бусад руу Монголбанк руу жихээд яг амьдралын чанар дундаж давхаргыг хавчиж байгаа, үнийн өсөлтөөр бодит орлогыг хавчиж байгаа энэ бодлогоосоо яаж татгалзах вэ?

Г.Занданшатар: Хэрвээ би андуураагүй бол өнгөрсөн нэг жил хамтарсан Засгийн газар ажиллаж байсан.

Манай Засгийн газар –

- Хэрвээ би андуураагүй бол ажил аваад 4 сар болж байна.
- Хэрвээ би андуураагүй бол сүүлийн 8 жилд Монголын төр 3.5 дахин данхайсны хоёр дахин нь өнгөрсөн нэг жил данхайсан.
- Хэрвээ би андуураагүй бол, статистик хэрвээ худлаа хэлээгүй бол дээд гурилын үнэ 3494 төгрөг болж, 2023 онд нэгхэн жилийн дотор 30 хувиар өссөн.

- Энэ бүх үнийн өсөлт, инфляц бодит байдал дээр –

- Иргэдийн орлогыг бууруулж байна.
- Уул уурхайгаас олсон орлого чинь цөөнхийг данхайлгаж байна.
- Нийгмийн орлогын зөрүүг бий болгож байна.
- Орлогын ялгаа буюу GINI coefficient нэмэгдэж байна.
- Энэ хоёр орон тоотой инфляцад сүүлийн нэг жил явж ирсний үр дүнд дундаж өрхийн бодит орлогыг бууруулж байна.
- Төр баяжиж, иргэн ядуурч байгаагийн тод жишээ нь энэ өнгөрсөн жилд.

Ийм учраас л бид төсвийн тодотгол хийж 2.2 их наядаар төсвийг танаж тодотгол хийсний үр дүнд өнөөдөр инфляц буурсан. 15 хувьд хүрэх байсан тооцооллыг бид барьж чадсан. Долларын ханш 4 мянган төгрөгт хүрч, иргэдийн амьжиргаа ядуурах байсныг бид энэ доллар, үнийн ханш өрсөлт, бүх юмаа импортлогч улс болсон учраас импортоос бүх үнэ хамаардаг болсон.

Импортын үнэ чинь валютын ханшаасаа 4 мянгад хүрэх байсныг бид сэргийлж чадсан.

Ганцхан бодит жишээ гэхэд өчигдөр “**Standard & Poor’s**” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг, Монгол Улсын эдийн засгийн нэр хүндийг 2В ангилал болгож 13 жилийн түүхэнд сайжрууллаа.

Энэ бүхэн инфляцаа бариад, валютын ханшаа бариад, өрийг бууруулаад, төсвийн алдагдлыг бууруулж байгаа өнөөдрийн манай Засгийн газрын бодит жишээ.

Тийм учраас бидний энэ хулгайтай хийж байгаа тэмцэл, авлигалтай хийж байгаа тэмцэл нь зөвхөн инфляцыг ч бууруулж байгаа юм биш, төсвийн алдагдлыг ч нэмэгдүүлж байгаа юм биш. Нийт утгаараа энэ таны хэлээд байгаа дундаж... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Асуултын эхэнд нэг тодруулга хэлэхэд өнгөрсөн нэг жилийн хугацаанд хамтарсан Засгийн газар ажилласан гэдэг.

Гэтэл яг үнэндээ Монгол Улсын Үндсэн хуульд олонх болсон нам засгийн газраа байгуулна гэж байгаа болохоос биш олонх нь цөөнхтэйгөө нийлээд хамтарсан Засгийн газар байгуулах тухай ойлголт бас байхгүй.

Тэгэхээр өнгөрсөн нэг жилийн хамтарсан Засгийн газар гэж байгаа ойлголт бол Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газарт Ардчилсан намын 8 сайд орж ажилласан, хөдөлмөрийн гэрээгээр орж ажилласан ойлголт гэж бид бүгд бас үздэг. Яг хамтарсан Засгийн газар гэдэг хууль эрх зүйн ойлголт байхгүй. Байхдаа хүрвэл аль нэг нам олонх болоогүй “Эвслийн Засгийн газар” гэдэг ойлголт байдаг гэдгийг бас хэлье.

Тэгээд яг одоо өнөөдөр гудамжинд эмч, багш нар нь гарсан байна. Уг нь бусад улс орны жишгээр эмч, багш нар гэдэг хүмүүс чинь өөрөө нийгмийнхээ, эдийн засгийнхаа дундаж давхаргад тооцогддог юм байна лээ.

Гэтэл манайд яг дундаж давхаргыг тоолж байгаа аргачлал ч байхгүй. Яг хэдээс хэдийн орлоготой айл өрхийг бид дундаж давхаргадаа тооцох юм бэ гэдэг өнөөдөр төрийн бодлогод суусан бүр нөгөө “хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй” гэдгээр бид өнөөдөр хэмжих ч үгүй байгаа. Янз бүрийн аргачлалаар хэмжлээ гээд бодоход нөгөө багш, эмч нар маань бүгдээрээ гудамжинд гараад суусан, ядуурлын байдал руу орсон. Багш, эмч нараа эрүүл мэнд боловсролын салбараа бид дунджаас доош түлхэж оруулчихаад үүний цаана бидэнд сайн сайхан зүйл ярихад үнэхээр хэцүү байна.

Нөгөө талдаа энэ багш, эмч нарын цалингийн хувьд дахиад бас эрүүлээр ярихад зүгээр шууд нэмнэ гэхээсээ урьдаар үүний цаана заавал гарц, гүйцэтгэл, бүтээмжийн тухай асуудлыг бид заавал онцгойлон ярихаас өөр аргагүй.

Тэгэхээр цалин хөлс нэмэх бодлогоо та нэг тодорхойлж хэлж өгөөч.

Г.Занданшатар: Баярлалаа. Тэгээд ер нь яах вэ, өнгөрсөн 3 жил багш нарын цалинг 3.5 сая, жил болгон 10 хувиар нэмэгдүүлж байгаад 30 хувьд хүрнэ гэсэн гурван талт хэлэлцээр байгуулсан юм билээ. Тэрийгээ өнгөрсөн 2 жил хэрэгжүүлээгүй юм билээ.

Өнөөдөр бүгдийг нь хуримтлаад 30 хувиар нэм гээд шаардаад байж байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг танай. Хэрвээ би андуураагүй бас дахиад эдийн засгийн асуудал хариуцсан Тэргүүн Шадар сайдаар Лу.Гантөмөр гээд танай намын дарга ажиллаж байсан. Тэр хүнээс өнгөрсөн энэ асуултуудыг та асууж, өнгөрсөн жил алт, зэс, нүүрсний үнэ өндөр байхад, төсөв тэлж данхайж байхад энэ асуултуудыг асууж шийдэж байсан бол арай нэг жилийн өмнө эхлэх байж. Арай өмнө эмч, багш нарынхаа цалинг нэмэх өгөх байж.

Өнөөдөр бид хуруу хумсаа хуйхалж байгаад багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Өнөөдөр хүртэл яриа хэлэлцээ хийгээд үндсэндээ зарчмын тохиролцоонууд дээр хүрч харилцан ойлголцож байна.

Жил болгон 10 хувиар нэмэгдэж байгаад 3 жилийн хугацаанд 30 хувь нэмэгдүүлсэн гэсэн юмыг өнгөрсөн 2 жил ганц ч төгрөгөөр энэ алт, зэс, нүүрсний үнэ өндөр байхад нэмэгдүүлэхгүй байж байгаад. Мэдээж боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд Л.Энх-Амгалан сайд бүтээмжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн цалингийн тогтолцоонд шилжүүлэх тогтолцооны шинэчлэл хийж байж энэ өөрчлөлтийг хийж чадсан.

Одоо бид цалингийн цогц реформ хийж бүтээмж дээр тулгуурласан, гүйцэтгэл дээр тулгуурласан оновчтой цалингийн системийг бий болгох замаар энэ доод цалин аваад байгаа, сая 484 мянган төгрөгийн цалин аваад байгаа дийлэнх их ачаалалтай багш нар, бусад багш нараасаа бараг хоёр дахин ачаалалтай ажиллаж байгаа нийслэлийн багш нарын цалинг нэмэгдүүлэх шийдэлд бид хүрч байгаа, гаргаж байгаа. Үүнийгээ шийднэ. Энэ бол мэдээж хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхийн тулд бүтээмж, гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцооны реформ хийхээр 5 жилийн төлөвлөгөөндөө тусгаад 3 жилийн хугацаанд зорилтот түвшинд хүрэхээр төлөвлөж байна.

Одоо 2026 оноос эхлэн бид багш, эмч нарын цалингаа доод цалингийн суурийг нь 50 хүртэл хувь нэмэгдүүлэх. Ингэж байж... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Цалин, тэтгэврийн нэмэгдлийг мэдээж харгалзаж үзэлгүй яах вэ. Тэгэхдээ үүний цаана бүтээмжийг, өсөлтийг, бүтцийн өөрчлөлтийг, олон зүйлүүдийг бас давхар авч явах ёстой шүү гэдгийг дэмжиж бараг хэлж байгаа утга учиртай шүү.

Дараагийн нэг асуулт нь эдийн засгийн болоод энэ бүх үзүүлэлтийн чинь нийгмийн үр нөлөө айхтар нөлөөнүүд гарч байна. Энэ дундаж давхаргыг дэмждэггүй, ажил хөдөлмөр хийж байгаа хүнээ дэмждэггүй 10 жилийн бодлогын чинь үр дүнгээр Монгол Улсад ажил хөдөлмөр хийдэг, арай жаахан сэхээтэнлэг хэсэг чинь тэр чигээрээ дайжаад Монгол Улсаас гараад. Одоо гадна бараг албан бус тоогоор 300-аад мянган иргэн гадна явж байна.

Яг одоо тэр янз бүрийн судалгаагаар санал асуухад нийт санал асуулгад оролцсон иргэдийн 60 гаруй хувь нь хэрвээ би чаддагсан бол, хэрвээ би асуудлаа шийдэж чадвал гадагшаа гармаар байна гэсэн. Үндсэндээ ийм оюуны дайжилт гэдгийг Та бүхэн бүгдээрээ л ярьж байгаа. **BRAND DRAIN** гээд.

Тэгэхээр нөхцөл байдал энэ улс орноос чинь яг энэ ажил хөдөлмөр хийдэг. Тэр тусмаа бид ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүсээ өнгөрсөн бодлого маань дэмждэггүй. Ажил хийнгээ ядуураад байдаг. Ажил хийгээд цалин авангаа ядуураад байдаг. Багш, эмч нараасаа аваад ийм л тогтолцоог бид өнгөрсөн хугацаанд бий болголоо.

Одоо оюуны дайжилт маань аягүй бол энэ чигээрээ ингэж үргэлжлэх юм бол бараг оюуны хоосрол гэдэг ийм зүйл рүү бид бараг нэг алхаад ороход бэлэн боллоо.

Тэгэхээр эндээс залуучуудад ажил хийж байгаа, ажил хөдөлмөр хийж байгаа иргэдэд энэ төрийн бодлого, төсвийн бодлого, бусад бодлогууд чинь төрийн өмчит компани. Бидний яриад байгаа, тунхаглаад байгаа олон зүйлүүд дээр ганц хоёр удаа ахиц гарах уу? Залуучуудыг, ажил хийж байгаа хүмүүсээ яаж урамшуулах юм бэ?

Г.Занданшатар: Энэ ер нь хөдөлмөрлөсөн хэрнээ ядуурдаг энэ байдал манай эдийн засгийн хамгийн эмзэг байдал бөгөөд тантай 100 хувь санал нэгдэх асуудал энэ байгаа. Үүнийг л засахын төлөө бид энэ 5 жилийн эрс шинэчлэл, эдийн засгийн бүтцийн эрс шинэчлэл хийе. Бүтээмжийн шинэчлэл хийе. Халамжаас хөдөлмөрт шилжье.

Эдийн засгийн бүтэц маань зөвхөн уул уурхайгаас хамааралтай биш, илүү нэмүү өртөг шингээсэн аж үйлдвэржилт, дижитал шилжилт, инновац, технологи шингээсэн шинэ эдийн засгийн салбаруудаа дэмжье, аялал жуулчлал, хөдөө аж ахуйгаа, инновац шингээж шинэчилье, хөгжүүлье гэсэн энэ цогц шинэчлэлийн бодлогыг бид Улсын Их Хуралд өргөн барьж байгаа.

Ер нь зөвхөн багш, эмч биш. Энэ **BRAND DRAIN** буюу “оюуны гадагшлах урсгал” Монгол Улсын хамгийн том эмгэнэл болоод байна гэхэд хилсдэхгүй. Яагаад гэвэл энэ бол баялгийн хулгайгаас. Яагаад гэвэл энэ улсад чинь хөдөлмөрлөсөн нь, шударгаар хөдөлмөрлөж байгаа нь тэр хэмжээндээ цалин авч орон сууцтай болж сайхан амьдардаг биш, уул уурхайг дагасан хэсэг нь л хөрөнгөждөг, баяждаг. Тэрний цаана авлига, хээл хахууль нуугдаад байгаа учраас энэ шинэчлэлийг хийж байж энэ реформ чинь бодитой хэрэгжинэ. Түүнээс энэ уриа лоозон болоод явах юм билээ.

Ийм учраас “цалингийн шинэчлэл”, “бүтээмжийн шинэчлэл” маань. Бүтээмжийн шинэчлэл гэж байгаа нь бүтцийн өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Зөвхөн боловсролын салбарт гэхэд багш нараасаа бараг олон ажилтан ажиллагсад ажиллаж байгаа.

Ер нь энэ салбар эдийн засагт маань ерөөсөө бүх салбарт бүтээмжид шингэсэн биш, хөдөлмөрлөсөн, ажиллаж байгаа нь илүү үр дүнтэй байдаг биш. Бизнесийн салбар ч гэсэн. Татварын бодлого нь ч гэсэн. Ийм учраас цогц эрс шинэчлэл хийе гэж бид эрс шинэчлэлийн 5 жилийн үндсэн чиглэлийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа.

Уг нь энэ бол төсвийнхөө өмнө өргөн баригдах ёстой хуультай байсан. Даанч энэ нь 9 сарын 01-нд төсөв өргөн барьдаг болоод цаглаврын өөрчлөлтийг Улсын Их Хурал дээр маань хийсэн учраас өнөөдөр төсвийнхөө дараа эдийн засгийн бодлогоор ярьж байгаа ийм ч өөрчлөлт гарч байна.

О.Цогтгэрэл: Тэгвэл ядуурлыг яаж бууруулаад, дундаж давхаргаа яаж тэлэх юм бэ гэдэг дээр яг бодлогыг нь үзэл баримтлалыг нь гэх үү дээ яг ямар бодлогууд бид барих ёстой вэ? Ямар ч л байсан ядуурлыг халамжаар бууруулаад, халамжаар дундаж давхаргыг бий болгож чадахгүй нь гэдэг нь танай намын өнгөрсөн, лав л энэ эдийн засгийн өсөлттэй, орлоготой 10 гаруй жилийн хугацаанд харагдлаа.

Тэр 100 тэрбум долларын орлого, 100 их наядын төсөв энэ бүгдийг чинь зарцуулаад зарцуулаад тэгээд дундаж давхарга чинь улам хавчигдлаа.

Тэгэхээр сая энэ 2025 оны Нобелийн шагнал авсан эдийн засгийн эрдэмтдийн бүтээлд ч гарсан байна лээ. Энэ инновац гэдэг зүйл, эрх чөлөө гэдэг зүйл. Эдийн засгийн эрх чөлөө чинь л тэр өсөлтийг, сайн сайхан амьдралыг авчирдаг гэдэг энэ зүйлүүд гарч байна.

Тэгэхээр танай Засгийн газрын зүгээс бодлогын өөрчлөлтөө яаж хийх юм бэ? Бодлогын өөрчлөлт. Бид жижиг уриа лоозонгуудаа, олон олон зүйлүүдээ больё. Эдийн засгийн бодлогын өөрчлөлт гэдэг зүйлийг та нэгдүгээрт нь хэлж өгөөч.

Хоёрдугаарт нь, минут байх шиг байна. Би энэ ядуурлыг нэмэгдүүлж байгаа, дундаж давхаргаас ядуурал руу залгаж оруулж байгаа нэг асуудал байна. Тэр нь өөрөө энэ эрүүл мэндтэй холбоотой ядуурал. Айл өрх, гэр бүлийн нэг гишүүн өвдөхөд үндсэндээ тэр гэр бүлийг шууд ядуурал руу чирч оруулж байгаа.

Яг үүн дээр судалгаагаар ядууралд орж байгаа 20 гэр бүлийн нэг нь яг энэ эрүүл мэндийн ядуурал. Үүний цаана бидний дахиад тогтолцооны, нөгөө Эрүүл мэндийн даатгалын систем, олон олон өөрчлөлт шинэчлэлтүүд чинь өнгөрсөн хугацаанд бүгдээрээ аргацаагдаж хийгдэхгүй байсны үр шалтгаанаар ерөөсөө дахиад нэг ядуурлын шалтгаан тэнд бий боллоо.

Айл гэрийн нэг гишүүн өвдөхөд... /минут дуусав/

Г.Занданшатар: Баярлалаа.

Ер нь энэ эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн реформ хийнэ гэдэг маань уул уурхай хэт хамаарлыг уул уурхайгаас төвлөрч байгаа өгөөжийг бид хөдөө аж ахуйгаа, боловсролоо, эрүүл мэндийн салбараа, аялал жуулчлалаа эдийн засгийн бусад салбараа дэмжих замаар ажлын байр бий болгодог, илүү чөлөөт зах зээлийг дэмжсэн бодлого.

Дандаа төрийн өмч хэт давамгайлсан энэ системийг илүү хувийн хэвшилд, чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж байж бид өрсөлдөөнийг бий болгосон шинэ эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж чадна. Үүнийгээ дэмжиж байж бид эдийн засгийн дундаж давхаргаа тэлж чадна.

Эрүүл мэндийн даатгалын хувьд Эрүүл мэндийн даатгалын сангийн үр нөлөөг нэмэгдүүлж цогц реформ хийхээр хөтөлбөрт тусгасан байгаа. Иргэдийг гэнэтийн санхүүгийн дарамтаас дундаж өрхөө хамгаалахад Эрүүл мэндийн даатгалын сангийн SOLIDARITY буюу эв санааны нэгдлийн зарчим оршдог.

Гэнэтийн өвчлөлийн буюу энэ catastrophic зардлууд дундаж өрхийн хамгийн том санхүүгийн дарамт байна гэдэг судалгаагаар тогтоогдсон. Энэ даатгалын систем бүрэн төгс ажиллаж чадахгүй байгаагийн яруу тод илрэл. Энд

захиргааны зардал санхүүжүүлээд байна. Энэ шинэчлэл Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрч байгаа нэг их наяд орчим төгрөгийн 60 хувь нь бас эмчилгээний бус захиргааны зардалд болон бусад зайлшгүй шаардлагатай биш өвчлөлийн зардал зарцуулагддаг гэх мэтчилэн санхүүгийн реформ хийх ёстой юм билээ.

Энэ зөвхөн эрүүл мэндийн салбарын зэрэгцээ санхүүгийн реформтойгоо уялдах ёстой. Бүтэц, зохион байгуулалтын хувьд ч гэсэн өөрчлөгдөх ёстой. Зөвхөн Эрүүл мэндийн даатгалын сан биш нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, цахим үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх замаар захиргааны зардлуудыг бууруулах ёстой.

Ингэж нөгөө catastrophic үйл явдлын өрхийн амьжиргаанд үзүүлж байгаа санхүүгийн дарамтыг бууруулах нь гол зорилт байх ёстой.

О.Цогтгэрэл: Харин тийм. Ингээд л яг үнэндээ өнгөрсөн засгийн газрууд гоё тунхагласан зүйлүүд л. Ийм байх ёстой, тийм байх ёстой гэдэг зүйлүүдийг л бид маш их сонслоо л доо.

Нөгөө эрүүл мэндийн салбар, Эрүүл мэндийн даатгал нийгмийн даатгалын тогтолцоонд лав л миний мэдэхээр сүүлийн 6 жилд бид өөрчлөлтийн цэг хатгасангүй.

Үүний үр дагавар ингэж л гарч байна. Нөгөө боловсролын салбар, нөгөө оюуны дайжилт, олон олон зүйл, ажлын байр, чадварлаг ажилтан, мэргэжилтэн олон олон зүйл энэ чигээрээ байхгүй. Ингээд л бид 100 их наядаар нь, 100 тэрбумаар нь мөнгөний том том тоо яриад их наядаараа асуудлуудыг яриад байдаг. Цэг хатгасан нь өөрчлөлт шинэчлэлийн хөтөлбөр өнгөрсөн хугацаанд байдаггүй.

Тэр эрчим хүч яривал олон олон зүйлүүд. Ер нь тэгээд явсаар явсаар байгаад манай улс чинь өөрөө эдийн засаг маань, улс орон маань зах зээлд уг нь шилжсэн орон биш яг л социализмаараа шахуу л байж байна шүү дээ. Эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, эрчим хүчний салбар, төмөр зам бүгд дээр нь үнэ барьсан. Нэг ийм л нөхцөл байдалтай улс орон өнөөдөр ингээд зогсож байна.

Тэгээд уг нь дундаж давхарга гэдэг чинь өөрөө саяын бидний яриад байгаа зөвхөн нэг ийм эдийн засгийн ойлголт бас биш юм байна лээ. Уг нь энэ дундаж давхарга гэдэг чинь улс орныхоо хөгжил дэвшлийг, ирээдүйг чирч явж байдаг, үр хүүхдүүдийнхээ боловсролд хамгийн их мөнгө төгрөгөө, санхүүгээ зарцуулж байдаг ийм л. Тухайн улс орныхоо нийгэм, соёлын түүх бахархлаа бүх зүйлээ тээж явж байдаг. Улс орныхоо улс төрийн нийгмийн тогтвортой байдлыг хангаж байдаг. Зөвхөн саяын эдийн засгийн ойлголтын цаана ийм асар чухал нийгмийн бүлэг энд байгаад байдаг.

Уг нь энэ ардчилалтай, ардчилсан тогтолцоо, ардчилсан сонгуультай, шударга сонгуультай хүртэл дундаж давхарга очиж холбогдож байдаг ийм л утга учиртай ийм ойлголтыг бид зүгээр юу ч биш болгож хувиргаж, үүнийг ярьдаг, хэлдэг, хэмждэг, зорьдог ямар ч ойлголтгүй лав л одоо үндсэндээ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ер нь бид бас зөвхөн ёстой гэж яриад байгаа юм биш ээ. Энэ бол дандаа хэрэгжүүлээд эхэлсэн реформуудын талаар ярьж байгаа юм.

Бид ирээдүй цаг дээр биш дандаа одоо цаг дээр ярьж байгаа. Бид хийх гэж байгаа ажлынхаа тухай биш, хийж байгаа ажлынхаа үргэлжлэлийн талаар ярьж байгаа.

Бид Эрүүл мэндийн даатгалын сангийн удирдлагыг нь өөрчлөөд Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны үр ашиг, хяналтын тогтолцоог шинээр нэвтрүүлж, өөрчлөлтийн одоо Их Хуралд оруулж ирэх гээд хуулийн төсөл дээр ажиллаж байна.

Боловсролын салбарын цогц реформ дээр ажиллаж байна. Одоо Ц.Мөнхтуяа гишүүний санаачилсан хуулиас авхуулаад бид хамтарч ажиллаж байна.

Тэгэхээр бид хамтарч энэ реформуудыг хийх ёстой. Ингэж байж энэ хамтарч тарьсан 30 жилийнхээ алдаа завхралыг хамтдаа засах ёстой. Өнөөдрийн энэ эдийн засаг, ядуурал, дундаж давхарга бид бүгдийн алдаа. Энэ чинь зөвхөн улс орны төдийгүй дундаж давхарга гэдэг бол ардчиллын тогтвортой байдлын гол баталгаа нь дундаж давхаргын бэхжилт байдаг. Ингэж байж санал хураалт, сонгууль шударга явагддаг. Нийгэмд ядуурал их байвал.

Одоо өнөөдрийн байдлаар 27 хувь нь ядуурал байвал зөв сонголт хийх чадавх ардчиллын баталгаа алдагдаж байдаг. Дундаж давхаргын эдийн засгийн доройтол цаад утгаараа ардчиллын доройтол байгаа юм.

Ийм учраас ардчилсан нийгмийнхээ төлөвшлийн хувьд ч гэсэн тэр, эдийн засгийнхаа хөгжил төлөвшлийн хувьд ч гэсэн тэр хүртээмжтэй эдийн засаг гэдэг таны дурдаж байгаа тэр Нобелийн шагналт эрдэмтдийн чиглэл чинь тийм болсон. Эдийн засгийн өсөлт 10, 20 байх нь хамаа байхгүй. Энэ дундаж давхаргатаа, нийт иргэддээ үр өгөөжтэй байх ёстой. Үүний тулд л хамгийн тулгуур асуудал нь баялгийн хулгайтай тэмцэж, шударга ёсны сууриа сайжруулж байж төсөв, эдийн засаг бүх суурь чинь сайжрах гээд байна. Үүний төлөө л бүгдээрээ нэгдэж тэмцэхгүй бол энэ чинь зүгээр нэг ганц хоёр хүний ч хий ажил биш.

Ийм учраас энэ нүүрсний хулгай, үндэсний баялгийн хулгайн эсрэг тэмцэл ядууралтай, тэгш бус байдалтай хийж байгаа дундаж давхаргаа өргөжүүлэх гэсэн тэмцэл юм шүү.

Ер нь энэ 4 тулгуурт бодлогыг бид... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Тийм. Одоо энэ төгсгөлийн минут юм байна. Би бас өнөөдрийн сэдэвтэй холбоотой би дүгнэлтээ хэлье.

Бараг бодлогоор гэмээр, санаатайгаар гэмээр ард түмнээ ядууралд байлгаж, тэр их олон тэрбум, олон их наядын мөнгөний цаана ядууралд байлгаж дундаж давхарга руу чирэх бодлогыг өнөөдөр хүртэл гаргаж ирдэггүй. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, боловсролын салбараасаа эхлээд яг хувь хүн рүүгээ чиглэсэн хүний хөгжил, амьдралын чанартай холбоотой бодлогыг бид томъёолж гаргаж зорьдоггүй энэ байдлыг харвал нөгөө XIV зууны үед Английн IV Хенри хаан гэдэг хаан Ромын Пап тухайн үед хэлж байсан гэж хэлэгддэг. Хэлсэн эсэхийг нь би мэдэхгүй. Нэг үгийг л би яг энэ хэлэлцүүлгийн дүгнэлт болгож хэлмээр байна.

Тэр IV Хенри хаан Ромын папд хэлж байсан юм гэнэ лээ. Та ард түмнээ мунхаг байлгахад зорь оо. Би ард түмнээ ядуу байлгая. Энэ хоёр нийлэхээр та бид хоёр мөнхөд засаглаж чадна. Ард түмэн ядуу, ард түмэн мунхаг байвал та бид хоёр нийлээд мөнхөд засаглаж чадна. Яг л энэ бодлого. Санаатай гэмээр бараг ийм бодлого өнгөрсөн хугацаанд үргэлжилжээ.

Тэгээд энэ бодлого дээрээ та бид тийм ийм гэсэн тунхагийн зүйлүүд биш, бодлогын эрс өөрчлөлт гаргахгүй болбол, зорихгүй болбол, хийхгүй болбол энэ нийгэм чинь буруу тийш явж байна шүү гэдгийг л төгсгөлд нь дүгнэж хэлье.

Г.Занданшатар. Баярлалаа. О.Цогтгэрэл даргадаа.

Тийм учраас тунхаг биш. Хэлсэн ярьсандаа байж. Хэлсэн үгэндээ эзэн сууж байж бид энэ бодлогоо хэрэгжүүлэх ёстой.

Бид энэ баялгийн хулгайтай тэмцэх, үнэн зөв нийгэм байгуулах. Үгэндээ сууж байж, үгэндээ эзэн болж байж бидний үйлдэл, үйл хэрэг зөв байж ялна.

Тийм учраас бид энэ зарчмыг баримталж байгаа. Хийх ажилдаа бид тууштай байна. Яагаад гэхээр энэ ажлыг чинь хүүхдийн мөнгөнөөс авхуулаад л бид хамтарч Ардчилсан нам санаачлаад л, бид санаачлаад, бидний үйлийн үр хийсэн ажил, өнөөдрийн үр дүн бол хэн нэгэн рүүгээ түлхээд байхаар биш, халамжийг шүтсэн бодлого, үндэсний аж үйлдвэрээ унагаасан бодлого санаатай юм шиг явуулж ирсэн хараат байдал руу чиглэж байгаа бодлого чинь манай эдийн засгийн аюулгүй байдлыг тун эмзэг болгосон.

Гадаад худалдаа 70 хувь гадаад улсаас хамааралтай. Экспорт 95 хувь уул уурхайгаас хамааралтай. Нэг улсаас хамааралтай.

Өр, импорт, шатахуун, эрчим хүч ямар байдалтай болгосон эдийн засаг маань санаатай гэмээр энэ үйлдлүүд чинь бид хэлсэн үгэндээ эзэн сууж чаддаггүйгээс л болсон. Гоё гоё юм ярьдаг. Эцсийн үр дүн үйлдэл маань өөр байдаг.

Тийм учраас бид та бүхнийгээ бас үгэндээ үнэн байж, үйлдэл үйл хэрэг эх орныхоо төлөө хамт зүтгэж, энэ өөрчлөлт реформуудыг хамтарч хэрэгжүүлье ээ гэж эцэст нь уриалмаар байна.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна.

Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секунд байна. Би нэг хүн 2 минутаас хэтрэхгүй асуулт асууж, үг хэлэх хугацаатай. Нэг удаа 1 минутаас хэтрэхгүйгээр нэмж өгөх юм байна шүү.

Одоо ингээд Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн 2 минут асуулт асууж 1 минут тодруулна.

С.Эрдэнэболд: Ерөнхий сайдаас.

Сая 10 дугаар сарын 19-ний өдөр Төв аймгийн Жаргалант суманд аймгийн иргэдийн Хурлын дарга н.Энхболдын хамт, мөн Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумдуудад ажиллалаа.

Энэ дээр Монгол Улсын Хөдөлмөрийн баатар н.Нэргүй гэж хүн, гавьяат агрономич н.Болдбаатар, мөн тариалан эрхлэгч н.Болормаа, н.Батнасан, н.Эрдэнэ-Од нарын иргэдтэй уулзсан.

Эдгээр уулзалтаас үүдэж танаас асуулт асуух гэж байгаа юм. Ер нь дундаж орлоготой татвар төлөгч өрхүүд нийгмийн халамжид хамрагддаггүй хэрнээ хөнгөлөлттэй болох ипотекийн зээл ч гэдэг юм уу, боловсрол, эрүүл мэнд, орон сууцын зардлын дарамтад давхар өртөөд байдаг. Энэ дотроос нэг төлөөллийг бас онцолж ярих гэж байгаа нь энэ газар тариалангийн салбар. Жишээлбэл, Жаргалант сум гэхэд Монгол Улсын төмсний 60-аас доошгүй хувийг хангадаг хэрнээ энэ ган гачиг, дээрээс нь менежментийн алдаа, төрийн буруу бодлогоос болоод маш хүнд байдалтай байна.

Томоохон аж ахуйн нэгжүүдэд зээл чөлөөтэй олдоод байдаг хэрнээ дундаж буюу бага га талбайд тариалан эрхэлж байгаа хүмүүст зээл ерөөсөө олдохгүй байгаад байна гэж байгаа юм.

Тэгээд энэ нь эргээд дундаж давхарга болсон одоо яг энэ тариалан эрхлэгч дээр төлөөлүүлж хэлэхэд дундаж давхарга болсон тэдгээр хүмүүстээ төрийн бодлого очихгүй байна гэдэг асуудал байгаа. Нэг.

Хоёрдугаарт, иргэдийн хооронд нэг том асуудал нь энэ тариалан эрхэлдэг газруудад малчид хоорондын газрын маргааны асуудал их болдог. Нэг нэгнийхээ амь насанд заналхийлдэг, адуу малыг нь бууддаг эхнээсээ шорон оронд явдаг гээд асуудлууд байгаад байгаагийн цаад зангилаа нь өөрөө төрийн бодлогын алдаа байгаад байгаа.

Өөрөөр хэлбэл шударгаар бизнес хийх гээд, аж төрөх гээд, амьдрах гээд явж байгаа хүмүүс дээр хуулийн хийдэл ч юм уу энэ гарц нь тодорхойгүй байдлаас иргэд өөрсдөө хохирогч болоод эдийн засгаараа ч тэр, юм юмаараа хохироод байгаа. Энэ дээр таны байр суурийг сонсмоор байна.

Ер нь сүүлийн 10 жилийн турш. Үүнийг нэг Засгийн газар луу онцолж хэлнэ гэхээсээ илүүтэйгээр Монгол төрийн сүүлийн 10 жилийн бодлогод... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минутаа өгөөрэй.

С.Эрдэнэболд: Хэрэглээний үнийн өсөлт нь дундаж орлоготой өрхийн бодит орлого хоёр гүйцэтгэж чадахгүй байгаад байгаа.

Тэгэхээр таны тэргүүлж байгаа Засгийн газар бага, дунд орлоготой өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх, инфляцын дарамтаас хамгаалах талаар яг ямар бодлого баримтлах юм бэ? Энэ талаар тодорхой хариулт өгөөч ээ гэж.

Ингээд төгсгөлд нь хэлэхэд ерөөсөө энэ **FOSS** буюу **The Forum of Small States**-ээс гаргасан судалгаагаар 10-аас доош сая хүн амтай улсууд хөгжихийн тулд номер нэг боловсролын салбараа л үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшил, өрсөлдөх чадварын түвшинд авч үзэх ёстой гэсэн байгаа.

Багш нарын ажил хаяад байгаа, эмч нарын ажил хийх гээд байгаа энэ асуудал бол салбарын зовлон биш Монгол Улсын ирээдүй хөгжил дэвшлийн зовлон гэдэг талаас нь дундаж давхаргаа дэмжинэ гэдэг талаас нь та нэг хариулмаар байна.

Дээрээс нь өрсөлдөх чадварын судалгааны олон улсын тайлан гаргадаг төвөөс Монголд байгаа 5 хямралын номер нэгд нь засаглалын хямрал байгаа бөгөөд засаглалын хямрал нь өөрөө дундаж давхаргын бодлогоо дэмжиж чадахгүй байна гэсэн зүйл хэлж байгаа. Энэ дээр таны байр сууриудыг сонсьё.

Г.Занданшатар: С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуулт. Төлөвлөгдөж байгаагүй асуулт ч гэсэн. Ер нь газар тариалангийн салбарыг санаатайгаар юм шиг ерэн хэдэн оны дараа ч бүх сангийн аж ахуйнуудыг хувьчлал нэртэй хувьчлалаар биш дампууруулаад Монгол Улс ер нь импортоор гурил, будаагаа, төмсөө авах ёстой гэсэн бодлого хэрэгжиж, үүний үр дүнд газар тариалан үндсэндээ унасан байсан.

Ингээд Хөдөө аж ахуйн яам 2022 оноос бид энэ бодлогыг өөрчилж, одоо хөдөө аж ахуй сэргэж байгаа юм.

Тийм учраас энэ “Атрын IV” аян, “Хүнсний хувьсгал”-уудын үр дүнд хөдөө аж ахуйн салбарт нэлээн сэргэлт бий болж байгаа.

Энэ дотроо таны хэлж байгаа тэр малчид тариаланчдын хоорондын зөрчлийг зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас тариалангийн бүс нутгийг тогтоосон. Тариалангийн бүс нутагт мал аж ахуй эрхлэхгүй ээ. Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж болно.

Эрчимжсэн мал аж ахуй болон газар тариалан уялдаатай хөгжүүлж болох ийм бодлогын шийдэл, чиглэлийг гаргаад хэрэгжүүлж байгаа. Үүнийгээ орон нутагтаа хэрэгжүүлэх ёстой.

Дээр нь хашаажуулах ажил байна. Тариалангийн талбайгаа хашаажуулах ажил. Моджуулах, мод тарих ажил гэх мэтчилэн ийм цогц ажил арга хэмжээнүүдийг нэн ялангуяа таны сонгогдсон төвийн бүс нутаг, Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт, Төв аймагт тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байгаа.

Энэ дотор тариалангийн бүс газраа нэмэгдүүлэх бас шаардлагатай байгаа. Тариалалтаа нэмэгдүүлэхийн тулд. Үүний тулд яах вэ, малчдад бид сая намар явахдаа өгсөн сануулгыг нийт малчдад юм шиг буруу хөрвүүлээд байгаа.

Тийм учраас малчид, тариаланчдын оронд хариуцлагын гэрээ байгуулдаг, тэжээл болон өвс тэжээлийн тусламж харилцан сумын Засаг дарга нарын зохицуулах асуудал. Хууль тогтоомж нь хангалттай байгаа.

Тийм учраас орон нутгийн удирдлагуудтайгаа яриад малчид тариаланчдын хоорондын харилцаагаар зохицуулах эрх зүйн үндэс бүрэн бүрдсэн байгаа. Шаардлагатай бол та бас тариаланчдаа төлөөлөөд хууль санаачилж зохицуулалтыг улам чангатгаж болно.

Б.Пүрэвдорж: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн. 1 минут нэмж Г.Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Тийм. Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийн 70 хувь нь нийлүүлэлтийн шалтгаантай.

Монгол Улс үйлдвэрлэгч улс биш болсон учраас үндсэндээ импортоос хамааралтай болсон. 70 хувь худалдаа гадаад улсаас хамааралтай болсон гэж хэлсэн шүү дээ.

Тэгэхдээ энэ дээр гол нөлөөлдөг хэрэглээний сагсны гол өсөлтүүд нь –

- ▶ мах,
- ▶ гурил,
- ▶ цахилгааны төлбөр бас нэмэгдүүлсэн.

- Дулааны төлбөр,
- цахилгааны төлбөр,
- сургалтын төлбөр

гэдэг хүчин зүйлсүүд инфляцын үндсэн гол шалтгаан болж байгаа.

Ийм учраас энэ хэдэн бүтээгдэхүүнүүдийг бид онилсон бодлого явуулж байна. Энэ чиглэлээр одоо ер нь өрхийн орлого 8 хувиар дундаж өсөж байгаа ч гэсэн инфляц нь түүнээс өндөр түвшинд байгаад байхаар иргэд ядуурч байна. Одоо жишээлбэл 2021 онд би хоёрдугаар гурил 942 төгрөг байсан чинь одоо 1500 төгрөг болсон ч байдаг юм уу. Нэгдүгээр гурил 1900 төгрөг байсан чинь 3400 төгрөг болсон гэх мэтчилэн зөвхөн гурил дээр нөгөө тариаланчидтай холбож байгаа дотацийн бодлогууд байгаа боловч гурилын үнийн өсөлт чинь жишээлбэл энэ инфляцын үнийн өсөлтийн нэг шалтгаан болж байгаа.

Б.Пүрэвдорж: Одоо Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Мөнхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Яг сарын өмнө 9 сарын 26-ны өдөр би бас Ерөнхий сайдтай Ардчилсан намын бүлгээс мэтгэлцээнд орж байсан. Бас л энэ боловсролын салбарынхаа багш, ажилтны цалин хөлсний асуудлаар ярьж байсан. Ерөнхий сайд санаж байгаа бол би энэ хуулийн төслөө өргөн барьсан гээд өргөөд ярьж байсан. Тийм ээ.

Сая Г.Занданшатар сайд энэ хуулийг бас дэмжих ёстой, явах ёстой гэж байна. Энэ дээр нь би талархал илэрхийлмээр байна.

Тэгээд та бид хоёрын мэтгэлцээнийг Монголын мянга мянган багш нар харж байгаа. Хүлээлттэй байгаа. Одоо нөгөө өмнөх сүүлийн 30 жил, өмнөх 9 жил танай нам манай нам засагласан гэдгээсээ илүү цаашдаа бид яах вэ гэдгээ яримаар байна.

Тэгээд ер нь бид хэдхэн хувиар аргацааж эмч, багш нарын цалинг нэмж ингэж явж ирсний харгайгаар өнөөдөр ахмадууд чинь жагссан, эмч, багш нар

чинь жагссан. Бодлогын алдааны золиос болоод сууж байгаа. Одоо хүүхдүүд золиосонд нь явж байна. Сургууль, цэцэрлэг байхгүй. Тийм ээ. Одоо эцэг, эхчүүд над руу дайрч байна. Та байнга ингэж багшийн цалин гэж нийгмийг турхирдаг. Тэр хүүхэд сургуульгүй, цэцэрлэггүй байна. Танаас болж байна гэж над руу бас дайралтууд маш их ирж байна.

Тэгээд Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Засгийн газартайгаа нийлээд ханцуй дотроо наймаалцаж тохироо хийж 5, 6 хувь нэмж ирсний чинь харгайг ард иргэд үүрч байгаа гэдгийг би дахин давтан хэлмээр байна.

Тэгээд одоо ингэж бид хоёрын хооронд 5, 10 хувь дээр наймаа тохироо хийхээ больё. Хуулиараа багш нарынхаа нийгмийн асуудлыг эрх зүйн хүрээнд хамгаалъя. Хуулийн хамгаалалтуудыг би энд нэлээн сайн оруулж өгсөн. Та бас миний энэ хуультай танилцсан байх гэж би найдаж байна. Таныг.

Тэгээд ер нь Боловсролын ерөнхий хуульд багш нарын ярьж байгаа, хэлж байгаа нийгмийн асуудлууд бүгдээрээ орсон байгаа. Багш нарын цалин хөлс дотоодын нийт бүтээгдэхүүний 7 хувь, төсвийн зардлын... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут.

Ц.Мөнхтуяа: Боловсролын салбарт дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 20 хувь, төсвийн зардлынхаа 7 хувь. Ингээд оруулж өгөөч ээ гэдгийг хууль дээрээ оруулсан байгаа.

Тэгээд тэтгэврийн насыг 50, 55, эрэлттэй тэргүүлэх мэргэжлээр сургана. Тасралтгүй 15 жил ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг гэсэн ийм заалтууд нь өөрөө амьгүй байгаа юм. Үүнийг амилуулж өгөөч ээ.

Орон сууцад хамруулна л гэж байгаа юм. Яаж хамруулах нь ямар ч тодорхойгүй ийм нэг амьгүй үлбэгэр сулбагар баахан хууль хийсэн. Тэр нь өнөөдөр үнэхээр хэрэгжихгүй байна.

Тэгээд энэ хуулийг амилуулахын тулд би ямар ч байсан 7, 8 жил гудамжинд тэмцэж багш нарынхаа дуу хоолой болж явсан хүний хувьд яг бодит хөрсөн дээр багш нарын саналуудыг энд шигтгэж оруулсан байгаа.

Тэгэхээр энэ хуулийг Г.Занданшатар та сайн танилцаад, багш нарын нийгмийн асуудлыг даруйхан шийдэхгүй бол 5, 10 хувиар танай үйлдвэрчин, танай Засгийн газрын хийж байгаа ажил... /минут дуусав/

Г.Занданшатар: Ер нь тэгээд дэлхийн аль ч улс оронд чинээлэг дундаж давхаргын гол төлөөлөл нь багш, эмч нар байдаг. Багш, эмч нараас нийгмийн хөгжил, соён гэгээрэл шалтгаалдаг.

Ер нь үндэсний статистикийн газрын гаргасан мэдээгээр улсын хэмжээнд 2025 оны хоёрдугаар улирлын байдлаар улсын дундаж цалин 2 сая 728 мянган төгрөг байна.

Гэтэл шинээр төгсөөд ажилд орж байгаа багшийн цалин сая 484 мянган төгрөг байгаа. Гар дээрээ сая га гаруйхан төгрөг авч байгаа залуу багш яаж ажиллах вэ. Улсын хэмжээнд ажиллаж байгаа нийт багш нарын гуравны нэг нь суманд, гуравны нэг нь аймгийн төвд, гуравны нэг нь Улаанбаатар хотод ажиллаж байна. Тэгтэл нийт суралцагч сурагчдын 60 гаруй хувь нь Улаанбаатар хотод байна.

Тэгэхээр багшийн ачаалал Улаанбаатар хотод их бөгөөд залуу багш нарын ачаалал их. Түүнтэйгээ дүйцсэн цалин бага байгаа учраас багш нарын бухимдал аргагүй байгаа юм.

Энэ нэг өдөр бий болоогүй. Өнгөрсөн 3 жилд ерөөсөө цалинг нь таны хэлдгээр хуурмаг аргаар 5, 6 хувь нэмсэн төдий болоод сая гаруйхан төгрөгийн цалинтай байгаа багш нарын тавьж байгаа шаардлага зүй ёсны гэж бид хүлээж авч байгаа.

Ийм учраас багш нарын амьдрал чинь өөрөө ядуурал руу түлхээд байна гэж байгаа гомдлыг бид хүлээж авч байгаа. Зөв зүйтэй.

Ийм учраас бид юуны түрүүнд бага цалин авч байгаа, доод түвшнээр цалин авч байгаа багш нарын цалингаа 1-ээс 4 жил ажиллаж байгаа багш нар Улаанбаатар хотод нэмэгдэлгүй цалин авч байгаа. Сумд яах вэ 40 хувийн нэмэгдэл авч байгаа. Тэнд. Энэ багш нарынхаа цалинг түлхүү нэмэх бодлогыг баримтална. Энэ талаар зарчмын тохиролцоонд үйлдвэрчний эвлэлтэйгээ урьсан.

Мөн таны санаачлан боловсруулсан багшийн боловсролын ерөнхий хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн ерөнхий үзэл баримт төсөлтэй танилцсан. Энэ дээр боловсролын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, төсвийн зардлын 20 хувь гэх мэтчилэн тодорхой хувиудыг төсвийнхөө рамтай харж үзээд зарчмын хуваарилалтыг нь зарчмын хувьд дэмжиж байгаа.

Гүйцээх юм бол ингэж таны ярьж байгаа нөгөө багшийн цалинг мянган долларт хүргэе. Түрүүн О.Цогтгэрэл даргын хэлээд байгаа нөгөө BRAIN DRAIN руу багш нар чинь гадагшлаад, эмч нар чинь гадагшлаад байгаа урсгалыг зогсоохын тулд багшийн цалинг, эмч нарынхаа цалинг мянган долларт доор хаяад хүрэх тэр бодлого бодитой хэрэгжинэ. Энэ хуультай чинь уялдуулаад бид Үйлдвэрчний эвлэлүүдтэйгээ хамтраад энэ ажлыг хэрэгжүүлбэ.

Багшийн хүүхдийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийн тэтгэлгийг тусгасан байна лээ. Таны хуулийг анхааралтай судалсан. Багш ажилтнууд хүсвэл 50, 55

настай тэтгэвэрт гардаг бол багш дутагдалтай үед жоохон эргэлзээтэй таныг бодож үзээсэй. Харин нэмэгдлийг нь олгодог зарчимд шилжье гэж бодож байна.

Орон сууцын дэмжлэг үзүүлэх асуудал орон сууцын хөтөлбөр олгоё гээд заасан.

Хөдөө орон нутагт тогтвортой ажилтны тэтгэмж олгох асуудал энэ 40 хувьтайгаа уялдаж байгаа. Үүнтэйгээ уялдуулаад угаасаа байгаа. Үүнийг хуультайгаа уялдуулаад шийдэж болох байх.

Багшаар суралцах оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт, амьжиргааны тэтгэмж зэрэг нийгмийн баталгааны асуудлыг нөгөө оноотойгоо сайн хүн багш болдог тогтолцоо... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Доржзодовын Энхтуяа асуулт асууж, үг хэлнэ.

Д.Энхтуяа: Сайн байна уу? Дэлхийн олон улсын жишгээр эмч, багш, тэтгэвэр авч байгаа иргэд маань яг тухайн нийгмийнхээ дундаж давхаргыг бүрдүүлдэг.

Өнөөдөр манай Монгол Улсад эмч, багш, тэтгэвэр авч байгаа иргэд маань цалингаараа, тэтгэврээрээ дундаж орлогыг бүрдүүлээд явах бүрэн боломжтой байсан. Одоо Монгол Улсад яг энэ том давхаргыг бүтээж байгаа иргэд 700 мянга гаруй байна.

Тэгэхээр Монгол Улсын хүн амын нэлээн том бүлэг гэж авч үзэж байна л даа.

Тэгэхээр энэ бүлгийн асуудал 9 сарын 15-наас төсөв хэлэлцэж эхэлснээс хойш асуудал үүсгээд байна. Тийм ээ. Тэгэхээр 9 сарын 15-наас бас 2 сар төрийн хямрал болж, энэ нэг хэрүүлийн байдалтай байснаас болоод өнөөдөр 2026 оны төсөв дээр яг ямар шийдэл гарсан нь одоогоор тодорхой бус байна.

Тэгэхээр энэ дээр зориулж төсөвтэй холбогдуулаад цаг үеийн асуудал асууя гэж бэлдсэн.

Өнөөдөр татвар төлөгчдийн цугларсан мөнгөнөөс 2026 оны төсөв дээр цалин, тэтгэврийг нэмнэ гэж ингэж ярьж байна. Нөгөө талаасаа салбар салбараас 10 хувийг танана гэж байна.

Тэгэхээр ирэх жил хавар дахиад нөгөө салбарынхан жагсахад бэлэн болно.

Тэгэхээр төсвийн бүрдүүлэлт дээр анхаарах ёстой. Бид өнөөдөр бодлогоор төсвөө яаж баяжуулах вэ, яаж бүрдүүлэх вэ гэдэг дээр миний асуулт чиглэж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр Засгийн газар өчигдрөөс эхлээд Оюу Толгой компанитай хэлэлцээрийн ширээнд суусан байна. 2009 онд би бас хэв хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байсан. Бас нэлээн том дуулиан шуугиантай Оюу Толгойн гэрээг үзэглэж байсан.

Ингээд Засгийн газар Оюу Толгой компанитай хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахдаа тухайн үеийн Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар татварыг тогтворжуулах ёстой байтал дэлхийд хаана ч байхгүй төлбөрийг тогтворжуулж гэрээ хийсэн.

Тэгэхээр энэ бол бас яах аргагүй нөгөө Оюу Толгойн талаас хийсэн... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минутаа нэмж авъя. Ерөөсөө 3 минутаар явуулчих.

Д.Энхтуяа: Ойлгосон. Тэгэхээр рояалти гэдэг АМНАТ. Дэлхий нийтэд байгаа энэ ойлголт эзний төлбөр юм.

Тэгэхээр манайх энэ АМНАТ-аа татвар гэж авч үзсэн. АМНАТ хэзээ ч татвар биш.

Тийм учраас шууд асуултаа асууя. Оюу Толгой компанитай хэлэлцээрийн гэрээнд суусан энэ цаг үед өнөөдөр хүчин төгөлдөр үүсэж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн 47.5-д заасан хэмжээгээр буюу Оюу Толгойн ордоос олборлож байгаа зэсийн баяжмал дахь эдийн засгийн үр ашигтай үндсэн болон дагалдах эрдсүүдийг бүрэн гүйцэд тодорхойлж өсөн нэмэгдэх АМНАТ-ыг тооцож авах талаар Ерөнхий сайд та яг энэ цаг үед Засгийн газар Оюу Толгой компанитай гэрээ хэлцэлд байж байхад, ширээнд сууж байхад үүнийг шийдвэрлэж чадах уу? Та энэ дээр ямар шийдлийн гарц гаргалгаа олж авсан бэ?

Мэдээж хэрэг хоёр талын гэрээ шийдэж болдог, баяжуулж болдог, өөрчилж болдог. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болдог ийм л эрх зүйн үндэс шүү дээ.

Г.Занданшатар: Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээг Улсын Их Хурлаар хэлэлцэж батлаад энэ төслийн бүх хэрэгжилтийн хугацаанд татваруудыг тогтворжуулсан Улсын Их Хурлын гаргасан шийдвэр.

Үүнийг Засгийн газар нэгдүгээрт өөрчлөх боломжгүй. Тогтворжуулсан. Улсын Их Хурлаар энэ хөрөнгө оруулалтын гэрээг баталсан.

Тухайн үед би хөрөнгө оруулалтын энэ гэрээг дэмжээгүй учраас санал хураалтад оролцоогүй, дэмжээгүй санал хураалтууд өгснийг та харж байж болно.

Тийм учраас миний байр суурь тодорхой. Эхнээсээ Оюу Толгойн гэрээг үр ашигтай байх ёстой. Монголын ард түмэнд үр өгөөжтэй байх ёстой. Ийм зарчмаар энэ гэрээнүүдийг дэмжиж оролцоогүй санал хураалт энэ бүх архивт байж байгаа.

Тийм учраас Засгийн газрын байр суурь бол Оюу Толгойн төслийн өгөөжийг Монголын талдаа Үндсэн хуулийн зарчимд нийцүүлж, дийлэнх өгөөж нь Монголын ард түмэнд оногдож байхаар ийм зарчмыг баримталж яриа хэлэлцээг эхлүүлж байна.

Мэдээж яах вэ өнөөдөр Оюу Толгойтой зээлийн хүүгийн хэлэлцээр хийж байгаа. Зээлийн хүүгийн хэлэлцээрийг хийж болохоор тусгасан болохоос биш хөрөнгө оруулалтын гэрээг нэг тал дангаараа өөрчлөх эрх зүйн үндэсгүйгээр тухайн үед хуульчилсан байгаа.

- ▶ Зарчмын хувьд зээлийн хүүг бууруулахаар би тохиролцлоо. Үүний үр дүнд үр ашиг сайжирна.
- ▶ Зарчмын хувьд менежментийн төлбөрийг бууруулахаар тохиролцлоо.

Энэ хоёрыг өндөр байлгах замаар компанийн ашгийг бага гаргаад, ашиг бага болохоор чинь зээлээ төлдөггүй. Монгол энэ талд оногдох үр өгөөж бага гараад байдаг ийм эрсдэлтэй. Зарим талаар миний үзэж байгаагаар зальтай ийм санхүүгийн асуудлуудыг зогсоох яриа хэлэлцээ одоо явж байна.

Энэ бүхний үр дүнд Монгол Улсын үр өгөөж 53 хувь болж нэмэгдүүлэх, цаашдаа бид эдийн засагт Оюу Толгой төдийгүй, бүх төслүүд үр ашигтай байх, гадаад улстай байгуулж байгаа гэрээнүүд ил тод бөгөөд Монгол Улсын талдаа үр ашигтай байх зарчмыг тууштай баримталж, ард түмнээрээ хэлэлцүүлдэг, ард түмэндээ нээлттэй, ил тод хэлэлцдэг зарчмыг тунхаглан зарлаад байгаа.

Ерөөсөө энэ асуудлууд ард иргэдээ өгөөжтэй, нээлттэй байж, зөвлөлдөж, хэлэлцэж байж л үр өгөөжтэй шийдэхгүй бол дандаа хөшигний ард шийдэгдэж байгаа шийдлүүд ард түмэндээ үр өгөөж муутай байна гэж шүүмжилж байгаатай санал нэг байна.

Ингэж бид баялгийнхаа эзэн байж, баялагтаа хийж байгаа янз бүрийн хулгай луйвруудыг таслан зогсоож байж бид ахмад настнуудынхаа тэтгэврийг багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлж, нийгмээ эрүүл, шударга, орлогын ялгаа хэт ихэссэн, баян хоосны ялгаа хэт гүнзгийрсэн нийгмийг л өөрчлөх гэж, дундаж давхаргаа өргөжүүлэх гэж бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж Үндэсний баялгийн сангийн үзэл санааг бид өөрсдөө санаачилж, Үндсэн хуулийн 6.2-т Норвегийн хуулиас эш татаж байгаад оруулж ирж хийж байсан юм.

Ийм ч учраас бидний зорилго бол зөвхөн баялгийн хулгайтай хийх гээд байгаа хоосон лоозон тэмцэл биш. Үндэсний баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлж, Үндсэн хуулийн үзэл санаагаа хэрэгжүүлж, ард иргэдээ илүү үр өгөөжтэй... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Баясгалан: Өдрийн мэнд хүргэе. Танд.

Үндэсний статистикийн хорооны гаргасан мэдээнээс үзэхэд 2022 оны байдлаар насанд хүрсэн хүний дундаж хэрэглээ сард 657 мянган төгрөг гэж гарсан. 418 мянга 900 төгрөг бол ядуурлын шугам гэж тооцсон байгаа.

Өнөөдөр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд 397 мянган төгрөгийн, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асран халамжилж байгаа асран халамжлагч 302 мянга 500 төгрөгийн тэтгэмж авч байгаа юм.

Тэгэхээр энэ хүмүүс маань бүгдээрээ нийлээд 147 мянга орчим мөнгө гэсэн үг. Энэ хүмүүс маань шууд ядуурлын түвшнээс доор очиж байна. Амьжиргааны түвшнээс даруй 180 мянган төгрөгөөр доор очиж байгаа юм.

Бид хавчигдсан дундаж давхаргынхныгаа ярьж байгаа нь хамгийн зөв. Дээр нь нэмээд хаягдсан энэ доод давхаргынхныгаа яах вэ? Энэ дээр ямар бодлого барьж байгаа вэ?

6 хувь нэмлээ гэхэд ерөөсөө 17 мянган төгрөг нэмэгдэж байгаа. 17 мянга гэдэг бол өнөөдөр 7 ширхэг талхны мөнгө хүрэхгүй байгаа.

Тэгэхээр үүнийг 30 хувь нэмж өгөөч ээ гэж би танд 47 гишүүний гарын үсэг зурсан шаардлага хүргүүлсэн. Улсын Их Хурлын дарга, Байнгын хороодын дарга нарт бүгдэд нь хүргүүлсэн байгаа.

Тэгээд энэ асуудал ерөөсөө орж ирэхгүй байгаа болохоор энэ дээр та яг тодорхой Засгийн газар ямар бодлоготой байгаа вэ гэдэг шийдээ хэлж өгөөч.

Манай улс “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогынхоо 3 дугаар зүйлийн 1 дүгээр үе шатад 2021-2030 онд нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна. Зорилтот эмзэг бүлгийн өрх иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно гэж заасан байгаа.

Тэгэхээр энэ дээр яг тодорхой хариулт авъя.

Г.Занданшатар: Ер нь Монгол Улсын хэмжээнд ядуурал 27 хувьтай байгаа. Тэр дотроо хөдөө орон нутагт 36 хувьтай. Зарим бүс нутагт ийм өндөр байгаа.

Ядуурлын гол шалтгаан бол хавтгайрссан халамжаас татгалзаж байна гэдэг боловч үндсэн хэрэг дээр яг халамж хүртэх ёстой, шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд нөгөө зорилтот бүлэгтэй халамжийг түлхүү боломжит түвшинд хүртэл нэмэгдүүлэх. Жишээлбэл, хоолны талон энэ тэрээс авхуулаад үр ашиггүй багийн дарга нар хуваарилдаг нэртэй. Мянгат мялчин авдаг халамжийн бодлогыг эрс шинэчлэл хийж, хавтгайрсан халамжийг оновчит зорилт бүлэгтээ шилжүүлж, хөдөлмөр эрхлэлт болон зорилтот халамжийн бодлого руу шилжих бодлогын эрс шинэтгэлийг хийж байж энэ урт хугацаанд ядуурлыг тогтвортой бууруулж, хүний хөгжлийн үндэс суурийг дэмжих суурь болох юм билээ.

Ер нь ядуурлын түвшин, тэгш бус байдал маш их байна. Монгол Улсад.

Ийм учраас энэ бүхний үр дүнд халамжийн сангийн зарцуулалтын өгөөжийг нэмэгдэж зорилтот хэсэгтээ хүргэхийн тулд юуны өмнө Засгийн газраас хөдөлмөр эрхлэлт, чадавхжуулалтыг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг урамшуулсан бодлого хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхэлсний дараах боломжуудыг нэмэгдүүлэх, хүний хөгжил, салбар дундын уялдаа холбоог хангах зэрэг цогц бодлогуудыг хэрэгжүүлж байгаа.

Өнөөдөр улсын хэмжээнд 100 хүн тутмын 27 нь ядуу, хөдөө орон нутагт 36 хувь байгаа бол ер нь энэ халамжийн нөлөөг бас хүүхдийн мөнгөн тэтгэмж мэдээж халамжийн бодлого биш. Харин яг халамжийн бодлогоо оновчтой болгох, нийт тэтгэвэр, тэтгэмжийн бодлогоо оновчтой болгох бодлого хэрэгжүүлж байна.

Ийм учраас сүүлд ярьж байгаа бид. Т.Аубакир сайд бид энэ төсөвт оруулж байгаа өөрчлөлт бол хувьчилж нэмэхээр бага тэтгэмжтэй улсууд. Одоо жишээлбэл нийгмийн даатгалын шимтгэл төлдөг байсан улсууд 380 мянган төгрөгөөсөө хувиар нэмэгдэхээр бага нэмэгдээд байгаа юм.

Б.Пүрэвдорж: Ж.Баясгалан гишүүн 1 минут.

Ж.Баясгалан: Та 302 мянган төгрөгөөр амьдарч чадах уу? Энэ хамгийн чухал асуулт.

Яагаад гэвэл үнэхээр яг ингэж амиа зогоож байгаа 100 гаруй мянган иргэн байгаа учраас, өрх байгаа учраас би энэ асуултыг асуугаад байгаа юм.

Тэгэхээр энэ хүмүүсийг би даблдаад нэмж өг гээгүй ээ. 3 сая болго гээгүй ээ. Эд нарыг ядаж амьжиргааны доод түвшинд хүртэл нэмээд өгөөч ээ гэдэг үүднээс 30 хувь нэмж өгөөч ээ гэдэг л хүсэлтийг тавьсан.

Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад байгаа хүмүүс маань амьд явах эрхээ эдлэх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэдэг бол хэт холыг харж биш өнөө маргаашийнхаа төлөө амьдарч байгаа хүмүүс. 10 жилийн дараа гарах үр ашиг биш 10 өдрийн дараа гарах тэр үр ашиг л тэд нарт хэрэгтэй.

Тийм болохлоор энэ дээр та тэр 30 хувь нэмнэ гэдэг энэ бодлыг дэмжиж байгаа юу гэдгээ хэлээд өгөөч ээ. Маш бага шүү. Энэ тэтгэмж маш бага.

Г.Занданшатар: Ж.Баясгалан гишүүнд хэлэхэд байна шүү дээ. Яг ингээд төсвийн бодлого хэлэлцэж байхад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ төсвийг анх нийт иргэдээр чөлөөтэй хэлэлцүүлсэн.

Төрийн ордонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төсвийн хэлэлцүүлэг болоод Та бүхэн дээр би орж уулзсан. Тэр үед та ерөөсөө 30 хувь яриагүй. Энэ асуудлууд чинь 10, 10 хувиар 3 жилд нэмээд явж байсан бол жигд нэмэгддэг. Одоо гэнэт бүгдээрээ 30 хувь нэмэгдэхээр энэ инфляц чинь, талхны үнэ чинь, энэ долларын ханш чинь 4 мянгад аваад нэмсэн биш тэр иргэддээ илүү дарамт болохоор ийм гэнэтийн өсөлтийг шахаад байгаа нь өөрөө харин эрсдэлтэй болж байгаа юм.

Ийм учраас үүнийг анх төсөв өргөн барьж байх үед танай хэлэлцүүлэгт орж байхад би хоёр удаа оролцсон. Энэ 30 хувиа яриад. Зүнийгээ яаж шийдэх бололцоог нь бид илүү ярих ёстой байсан болов уу гэж бодож байна.

Тухайн үед бид бас танд энэ асуудлыг хандаж хэлж байсан. Одоо 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 107.9 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дараагийн хүмүүс асуултынх нь хугацаа шахагдаад байгаа учраас боломжгүй.

Одоо Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

О.Алтангэрэл: Манай Ерөнхий сайд баялгийн хулгайн талаар нэлээн ярьж байгаа.

Ер нь энэ баялгийн хулгайтай тэмцэх, хууль бусаар хулгайлагдсан хөрөнгийг эргүүлж авчрах нь өнөөдөр гадаа жагсаж байгаа багш нар, эмч нарын цалинг дэмжих суурь нөхцөл болох байх.

Та 8 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын хуралдааны дараа санаж байна. Хууль бус хөрөнгийг хураана гэсэн. Энэ үед бас би гайхаж байсан. Энэ одоо ямарваа нэг хууль эрх зүйн орчин, боломжгүйгээр яах юм бол. Анх томилогдож байхад нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах,

нөхөн төлүүлэх тухай хуулийн талаар танаас асууж байсан. Монголд ийм хууль эрх зүйн орчин байгаа гэж хариулж байсан.

Харамсалтай нь өнөөдөр олон удаагийн өршөөлийн хууль болоод, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд өмнөх 30 жилийн гэж ярьж байгаа. Бидний энэ хулгай, баялгийн хулгай, олон төрлийн төрд ойрхон байсан хүмүүсийн хийсэн хулгай, хууль бусаар хөрөнгөжсөн хүмүүсийн хөрөнгийг хураах орчин нөхцөл хязгаарлагдмал байгаа. Зөвхөн шүүхийн шийдвэр гарч явдаг, гэмт хэрэг яривал хөөн хэлэлцэх хугацаа явдаг, иргэний журмаар болон бусад арга хэрэгслээр хөрөнгө хураадаг энэ механизм байхгүй байгаа юм.

Тэгэхээр хамтарсан Засгийн газрын үед Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах тухай, Иргэний журмаар нөхөн төлүүлэх тухай гэсэн хуулийн төслийг өргөн барьсан. Засгийн газраас. Өнөөдөр Улсын Их Хурал дээр байгаа. Өнгөрсөн долоо хоногт Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад Та бас хариулж байна лээ. Энэ Их Хурал дээр байгаа гээд.

Тэгэхээр яг энэ хууль эрх зүйн орчныг ер нь боловсронгуй болгох чиглэлээр танай Засгийн газар ямар арга хэмжээ авах юм бэ?

Ер нь энэ Авлигын эсрэг багц хууль буюу энэ ганцхан хууль бус хөрөнгө хураах тухай хууль биш шүү дээ. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй учраас энэ дотор дагалдуулаад маш олон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл явж байгаа. Та энэ хуулийг дэмжих үү? Баялгийн хулгайтай тэмцэнэ гэж байгаа Таны энэ хүсэл зориг, тэмцэл чинь хууль эрх зүйн хувьд яаж биежих вэ?

Г.Занданшатар: О.Алтангэрэл гишүүний асуултад хариулъя.

8 дугаар сарын 17-нд болон би анх томилогдож байх үедээ хэлсэн зарчим. Засгийн газар хууль тогтоох эрх мэдэл эдэлдэггүй. Тийм ээ. Таны өргөн барьсан хууль Улсын Их Хурал дээр байгаа. Засгийн газар дээр биш, Улсын Их Хурал дээр байгаа.

Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрх мэдлийнхээ хүрээнд хууль хэлэлцэх, тогтоох явцад бид дарамт шахалт үзүүлэх юм уу, нөлөөлөх хуулиар хориотой. Бид байр сууриа илэрхийлээд өргөн барьсан. Үүнийг хэлэлцэн батлах асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Нэгдүгээрт, тэгж би хариулсан юм.

Хоёрдугаарт, би 2025 оны 7 дугаар сарын 03-ны өдөр энэ албан даалгаврын хувийг танд өгч болно.

Тухайн үеийн Хууль зүй, дотоод хэргийн сайдад авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, авлига, албан тушаалын

гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах талаар авах арга хэмжээний төсөл, төлөвлөгөө боловсруулж 7 дугаар сарын 23-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх даалгавар өгсөн.

2 дугаар заалтаар авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, үндэслэлгүй хөрөнгөжсөн, нийтийн өмчийг шамшигдуулсан, ашигласан нийтийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хууль бусаар олсон орлогыг хураах эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, саналыг 7 сарын 23-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг үүрэг болгосон.

Хууль бусаар олсон яг энэ гэмт хэрэг үйлдээд тогтоогдсон хөрөнгүүдийг хураах ажлыг зохион байгуулахыг бас үүрэг болгосон. Энэ ажил маань албан даалгавар хэрэгжилтийг 7 дугаар сарын 03-ны өдөр гаргасан байгаа. Энэ зохион байгуулалтын ажлууд. Ингэж байгаа хууль, эрх зүйн орчны хүрээнд.

Байгаа хууль, эрх зүйн орчны хүрээнд жишээлбэл 328 нүүрсний хулгайтай холбоотой холбогдогч нарын хэрэг шийдвэрлэгдээгүй байж байна. Шийдвэрлэгдээгүй.

Энэ асуудлуудыг хянан шалгаа... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж Засгийн газрын гишүүн хариулах бас дэгтэй. Индээс гарч хариулна. 1 минутыг. Индрийн 3 номер.

Засгийн газрын гишүүд хариулахаар бол 3 номерын индэр дээр байж байх ёстой шүү.

Б.Энхбаяр: Авлигачдын хөрөнгийг хураасаар ирсэн байдаг.

Энэ эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох асуудлыг манай О.Алтангэрэл сайд маань санаачлаад Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар огцордгийнхоо өмнөх өдөр Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцэхийг нь шийдсэн байгаа.

Үүнийг би зүгээр улс төр болгож ярих асуудал бас биш ээ гэж үзэж байгаа. Зарчмыг нь дэмжиж байгаа. О.Алтангэрэл сайдтай энэ хууль тогтоомжийг Улсын Их Хурал дээр Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлж батлуулахын төлөө байгаа.

Үндсэн хуулиас хальсан асуудлыг Улсын Их Хурал хууль тогтоогч би дэмжих ёсгүй гэж үзэж байгаа.

Монгол Улсын Дээд шүүх болон хууль хяналтын байгууллагууд зарим асуудлаар... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: О.Алтангэрэл гишүүн нэмж нэг тодруулъя. Минут.

О.Алтангэрэл: Ер нь хууль, эрх зүйн орчин ийм бүрхэг байгаа учраас эрэл хайгуулын үр дүнд л дэлхийн бусад орнуудын жишгийг хараад. Жишээлбэл, Бүгд Найрамдах Солонгос Улсад яг ийм хууль байгаа байхгүй юу.

Тэгээд Америкийн Нэгдсэн Улс байдаг ч юм уу, энэ хууль бус хөрөнгөтэй тэмцсэн улс орнуудын жишгийг хараад боловсруулсан ийм л хуулийн төсөл, ийм л багц хуулийн төсөл байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ямар ч байсан буцаад татаж авахгүйгээр үүнийг хэлэлцүүлээд, Үндсэн хуулийн хүрээнд энэ хэлэлцүүлэх юм байна гэж ойлголоо.

Тэгвэл бас нэг асуулт. Авлигын төсөөллийн индекс байгаа.

Монгол Улс 121 дүгээр байранд явж байгаад хамтарсан засгийн үед 114 дүгээр байранд орсон. Яг энэ 114-д орсон 7 байр урагшилсан. Оноо хэвээрээ байна гэж байгаа боловч дэлхийн бусад улс орнууд ковидын дараах нөхцөл байдалд авлигын нөхцөл байдал хүндэрч байхад 7 байр урагшилсан юм. Яг энэ урагшилсан жилийн 6 сард нь Б.Энхбаяр сайд, 6 сард нь миний бие ажиллаж байсан юм.

Тэгэхээр цаашид авлигын төсөөллийн индексийг бууруулна гэдэг бол зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх асуудал байдаггүй юм л даа. Энэ чиглэлээр ямар ажил хийж бодит үр дүн гаргах вэ гэсэн ийм асуулт байна.

Г.Занданшатар: Маш сайхан асуулт байна. Яг энэ чиглэлээр бид энэ 7 сарын 03-ны болон 7 сарын 17-ны захирамжуудаар ер нь авлигатай тэмцэх цогц бодлого хэрэгжүүлэх, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, улмаар үүний бодит үзүүлэлт нь авлигын индексийг бууруулах төсөл, хөтөлбөр гаргасан юм.

Авлигалын индекс бууруулахад 3 цогц өөрчлөлт хэрэгтэй юм билээ.

► **Нэгдүгээрт,** бодлогын өөрчлөлт. Улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, дээд шатын авлигалтайгаа тэмцэж байгаагаа нотолж, Улсын Их Хурал нь, Засгийн газар нь хүсэл зоригоо илэрхийлж тэмцэж байх ёстой.

Энэ бол авлигын индексүүд буурах нэг дэх гол үзүүлэлтүүдийг нийтээс авсан судалгаагаар тодорхойлдог. Иргэний нийгмийн байгууллагуудаас асуудаг.

Энэ бодлогын өөрчлөлтийн хүрээнд бид төрийн өмчийн ил тод байдлыг явуулах, хувьчлах, төрийн оролцоог багасгах, шилэн болгох цогц бодлогын өөрчлөлтийг энд тусгасан. Энэ бодлогын өөрчлөлтийн асуудал.

► **Хоёрдугаарт**, авлига, нүүрсний хулгайтай тэмцэх, шилэн болох цогц хүрээнд олон нийтэд ил тод болгох. Албан тушаалтны хяналтаас ард түмний хяналт илүү сайн учраас энэ бүх гэрээ, энэ бүх юмыг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 3 номер.

Б.Энхбаяр: Авлигатай бүх түвшинд тэмцэх ёстой. Тэр дотроо хууль тогтоох байгууллага манлайлж энэ дээр үлгэрлэх ёстой.

С.Ганбаатар гишүүний санаачилсан хулгай хийчхээд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын ард нуугдаж, хуулийн хариуцлагаас бултах санаачилгыг дэмжихгүй байх ёстой. Эндээс эхлэх ёстой шүү.

Дарга, цэрэг хамаагүй баригдах ёстой. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх ёстой. Бид Үндсэн хуульдаа тангараг өргөсөн.

Авлигачдын хөрөнгийг хураахад 2015 онд баталсан Эдийн засгийн ил тод байдлын хууль гэх нэртэй нийтдээ 3 тэрбум долларын хууль бус хөрөнгийг өршөөсөн хууль садаа болж байгаа.

Тэр хуульд энэ өршөөгдсөн хөрөнгүүдийг эргэж эрүүгийн хэрэг үүсгэх, гүйцэтгэх ажил хийх... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Хосбаяр: Монгол төгрөгийн ханшийн талаар асуух гэж байгаа. Бид хамгийн дээд тал нь 20 мянгатын дэвсгэр дээр монгол төгрөг хэрэглэдэг.

Тэгээд сүүлийн жилүүдэд монгол төгрөгийн ханш доллартой харьцахдаа ч унаж байна, нийгэмд ч бодит үнэ цэн нь унаж байна. Монголчууд өөрсдөө бид төгрөгтөө итгэхгүй, төгрөгт итгэх итгэл нь суларч байна гэж харж байгаа.

Тийм учраас дундаж давхарга орлогоо төгрөгөөр олдог.

Тийм учраас төгрөгийн ханш тогтвортой байж, төгрөгийн ханш үнэгүйдэх нь багасаж байж дундаж давхаргын орлого баталгаатай болж, нийгмийн баталгаа нь хангагдана гэж харж байгаа. Жишээ хэлэхэд 2016 онд тэтгэвэр 208 мянган төгрөг байсан. Одоо 600 мянга болсон байгаа. 2016 онд ноолуур 100 мянга байсан. Одоо 130 мянга байгаа.

Тэгтэл бидний олж байгаа орлого өдийд дайтайгаар ингэж жишиж гэж өсөж байхад нөгөө талд нь бараа, бүтээгдэхүүний үнэ, бидний хэрэглээний зардал 3, 4, 5 дахин өссөн байна.

Тийм учраас энэ дээр ер нь бодлогын ямар арга хэмжээ авах вэ? Төгрөгийн ханшийг унагахгүй байх, харьцангуй тогтвортой байлгахад ямар арга хэрэгсэл, ямар бодлогын арга хэмжээ авах вэ гэсэн ийм асуулт байна.

Г.Занданшатар: Мөнгөний ханшийн уналт бол зөвхөн дундаж давхаргын биш нийт ард иргэдэд нөлөөлж байгаа халаасыг нь хоосолж байгаа, үнэгүйдүүлж байгаа гол хүчин зүйл.

Төгрөгийн ханш уналт үндсэн 3 шалтгаантай.

Нэгдүгээрт, нийлүүлэлтийн шалтгаантай. Нийлүүлэлтийн шалтгаан бол Монгол Улс үйлдвэрлэгч улс биш. Дотооддоо үйлдвэрлэдэг биш дандаа импортоор авдаг болсон. Ийм чөтгөрийн тойрогт орсон.

Ийм учраас экспортоосоо импорт нь их болохоор гадагшаа валютаа зараад байгаа учраас валютын ханш тогтмол өсөж байдаг. Валютын ханш тогтмол өсөхөөр валютын ханш нь өсөж байгаа юм чинь цаанаас авч байгаа барааных нь үнэ өсөж байдаг.

Өөрөөр хэлбэл ийм нийлүүлэлтийн буюу импортын... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үргэлжлүүлээд 2 минутын, 3 минутыг нь тус тус. Дуусгачих. Энэ нөгөө орж гарч байгаатай, сэлгэж байгаатай холбоотойгоор хүмүүсийн минут нь яваад байна.

Г.Занданшатар: Тийм учраас манай эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж, хүнсний үйлдвэрлэлүүдээ дэмжээгүй бодлогын үр дүнд л ерөөсөө үндсэндээ манайх импортоос хамааралтай болоод байгаа нь валютын ханш өсөхөөр бүтээгдэхүүний үнэ өсдөг, бүтээгдэхүүний үнэ өсөхөөр дагаад валютын ханш нь өсдөг, импортоос авдаг.

Ингээд л үндсэндээ нэг нүүрс, салтаа зарж олсон валютаа гадагшаа хүнс, худалдаа, бүх зүйлдээ зарцуулаад дотооддоо үйлдвэрлэгч улс биш болсон нь төгрөгийн ханш унаж байгаа гол үндсэн шалтгаан болж байгаа юм.

Үүнээс болж үндсэндээ инфляц тогтмол өсөж, 1992 оноос хойш монгол төгрөг 44 дахин үнэгүйдэж байгаа гол шалтгаан бол ерөөсөө л дотоодын үйлдвэрлэл, бизнес, аж үйлдвэржилтээ дэмжээгүй, дампууруулаад, хувьчлаад, унагаад, устгаад, ёстой нөгөө санаатайгаар ч юм шиг, гаднын ч юм шиг бодлогын үр дүнгүүдэд чинь дотооддоо юмаа хийж чаддаг биш бүх юмаа импортоор авдаг болсоноос импортоосоо, долларын ханшаасаа хамааралтай болсон энэ эдийн засаг маань жоохон нүүрс, алт, зэсээ экспортлоод... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Д.Жаргалсайхан гишүүн. Цаг дууссан учраас 2 минутаар асуугаад, 2 минутаар хариулна.

Д.Жаргалсайхан: Дундаж давхаргаа хэрхэн аврах вэ гэсэн өнөөдрийн мэтгэлцээн үргэлжилж байна.

Тэгээд дундаж давхарга гэдэг маань Монгол Улсын хувьд хүнд байдалд орсон. Хөгжиж байгаа улс орнуудад 50 хувиас дээш байж ажиллавал бололцооны гэж үздэг бол Монгол Улсын хувьд 25 хувьтай байгаа.

Тийм учраас дунд давхрыг аврах дээр, үүнийг хамгаалах дээр үндэсний үйлдвэрлэл, мөн дээрээс нь багш, ажилчид, ингээд төрийн албан хаагчдын амьжиргааг сайжруулах, мөн өөрийнхөө хэрэглээ, мөн дээрээс нь боловсрол, эрүүл мэнддээ тэр олж байгаа орлогоороо бүрэн хангаж чаддаг байж дундах давхарга руу ордог болбол өнөөдөр бидний хувьд хүнд байдалд орсон.

Тийм учраас гаднын компаниудыг шүтэх, гаднаас орж ирж байгаа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, импортолдог орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр та ямар бодлого барьж байна вэ? Жишээ нь, Монгол Улсад өнөөдөр хэрэгжиж байгаа томоохон төслүүд дээр ерөөсөө гаднынхан л ажилладаг болсон.

Монголчууд барилгаа барьж чадаж байна, замаа барьж чадаж байна. Гэтэл гаднын компаниуд ажиллаж байдаг болсон. Үүнийг яаж зогсоох вэ? Нэг дэх асуулт.

Ер нь бид үндэсний үйлдвэрлэлээ дэмжих нь л нэг номерын асуудал. Үндэсний бүтээгдэхүүнийг худалдаж авах, үүнийг энэ ард иргэддээ эх оронч худалдан авалт хийх үзэл санааг суулгах дээр та ямар ажил хийх вэ? Энэ тал дээр хариулаач.

Г.Занданшатар: Маш чухал асуулт асуулаа. Д.Жаргалсайхан гишүүнтэй санал нэг байна.

Үндсэндээ үндэсний үйлдвэрлэлээ дэмжихгүй, үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнээ худалдаж авдаггүй, импортыг шүтдэг энэ хэрэглээний байдал бол манай энэ дундаж давхаргаа ч дэмжихгүй байх, бүрдэхгүй байх, цаашлаад үнэ ханш өндөр байх ийм гол үндэслэл болж байгаа юм.

Ийм учраас бид Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барихаар боловсруулж үндсэндээ бэлэн болгож байна. Энэ хуулийн үр дүнгээр эх оронч худалдан авалтыг дэмжих, дотоодын үйлдвэрлэл 10 хувь өндөр байсан ч гэсэн дэмждэг, илүү чанартай бүтээгдэхүүнийг худалдан авдаг ийм систем рүү шилжүүлэх нь үндэсний үйлдвэрлэгч ажлын байраа дэмжиж байгаа бодлого.

Монголд ажлын байр бий болгоод үйлдвэрлэл эрхэлж байгаа компаниудаа дэмждэг зээл хүү, худалдан авах ажиллагааны бодлого байж байж улс орон хөгжинө.

Одоо энэ хөгжсөн Азийн бар улсууд Хятад, Япон, Солонгос бүх улсуудын бодлого тийм. Импортын татвараа өндөр тавьж, дотоодын үйлдвэрлэгчдээ хамгаалдаг. Манайх өврөө дэлгэсэн юм шиг үндэсний үйлдвэрлэгчдээ дэмждэггүй бодлоготой. Жишээлбэл, ургамлын тос үйлдвэрлээд Японд чанартай тос гээд авч байхад манайх НӨАТ, гаалийн татварынхаа үнэ цэнээс болоод унагааж байдаг.

Ер нь тэгээд дотооддоо үйлдвэрлэж байгаа бүх бүтээгдэхүүнийг ерөөсөө үндсэндээ унагаах гэж байгаа юм шиг татварын, зээлийн бодлого явж байгаа нь таны хэлж байгаа үндэсний үйлдвэрлэлийг унагааж байгаа нэг шалтгаан болж байгаа.

Одоо энэ санаатай юм шиг энэ бодлогыг л бид өөрчлөхийн тулд 5 жилийн үндсэн чиглэлдээ эдийн засгийн бүтцийн реформ хийх цогц бодлогыг оруулж ирсэн байгаа. Энэ бол нөгөө эрс шинэчлэлийн бодлогын нэг хэсэг нь. Ингэж байж ер нь ерөөсөө л дэлхийн бүх улс төр дотоод үйлдвэрлэлээ дэмжиж байж дотооддоо махаа, арьс ширээ, ноос ноолуураа боловсруулдаг болж байж улс орон хөгжинө. Энэ зорилгоор бид эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулсан. Ирэх оноос хэрэгжүүлэхийг хүсэж байна.

Улсын Их Хурал дэмжиж өгөхийг хүсье. Тэндээ 340, 350 бүтээгдэхүүн экспортолно.

Зөвхөн ноолуур гэхэд чинь бид түүхийгээр нь 327.0 сая доллароор экспортолж байна. Үүнийг зөвхөн утас болгоод гаргахад тэрбум доллар... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 15 минутаас хэтрэхгүй. Гишүүдэд ирцэд бүрдүүлсэн дарааллын дагуу асуулт авах асуух зөвшөөрөл өгье.

Отгоншарын Батнайрамдал гишүүнийг урьж байна. 2 минутаар асуулт асууж, 1 минутаар тодруулна.

О.Батнайрамдал: Өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайд.

Яг энэ цаг мөчид Оюу Толгойн хэлэлцээр явж байгаа учраас хэлэлцээртэй холбоотой асуулт асуухгүй.

Улсын Их Хурал дээр Оюу Толгойн асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулагдаад яг 4 сарын хугацаа өнгөрч байна. 4 сарын хугацааны хүрээнд бид нотлох баримт цуглуулах хүрээнд нийтдээ 60 мянга давсан хуудас нотлох баримт цуглуулсан байгаа юм.

Үүний дийлэнх нь буюу 50 хувиас дээш нь дандаа ямар нэгэн байдлаар –

- байгууллагын нууц,
- төрийн нууц,
- албаны нууц,
- маш нууц гэсэн тамгатай байна гэсэн үг.

Тэр дундаа Оюу Толгойгоос ирүүлсэн 30 гаруй мянган хуудас нэг бүрчлэн байгууллагын нууцад гэсэн тамгатай ирсэн байгаа.

Тэгэхээр бид олон нийтийн сонсгол хийхэд тэр мэдээллийг ашиглах боломж нөхцөл байхгүй болоод байна.

Тэгэхдээ Монгол Улсын Засгийн газраас гаргасан ажлын тайлангууд, албан тоот, бичиг баримтууд. Тэр дундаа шууд хэлье. Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхайн яамнаас хоорондоо солилцсон 10, 20 гаруй мянган хуудас нотлох баримтын хүрээнд –

- төрийн болон албаны нууц,
- тэр битгий хэл маш нууц гэсэн тамга бас дарсан байна.

Тэгэхээр бид Засгийн газар дээр байгаа Оюу Толгойн асуудалтай холбоотой нотлох баримтыг бид Хянан шалгах түр хорооны сонсголоороо ард түмэнд мэдэх эрхээр нь хангахад зөрчигдөх гээд байна.

Тэгэхээр танаас би асуух гээд байгаа нь энэ Засгийн газрын бүрэн эрх бол энэ төрийн болон албаны нууцаар авсан бичиг баримтууд ил тод болгож нууцаас гаргах нь Танд бүрэн эрх нь байгаа.

Тэгэхээр тэр үе үеийн гаргасан, сүүлийн зарим нь хугацаа нь дууссан энэ олон бичиг баримтуудыг Засгийн газраас гаргасан энэ нууцад авсан бичгүүдийг Оюу Толгой дээр ил болгох уу? Ил болгож байж буцаад бид ард түмний мэдэх эрхийг хангасан сонсгол зохион байгуулах нөхцөл боломж нь нээгдэх гээд байгаа юм л даа.

Г.Занданшатар: Отгоншарын Батнайрамдал гишүүн таны хэлснээр одоо яриа хэлэлцээд явж байна.

Яриа хэлэлцээ амжилттай явж байгаа. Юуны өмнө Оюу Толгойн төслийг Монголын ард түмэнд үр ашиггүй болгоод байсан өндөр зээлийн хүүг бууруулах тохиролцоонд хүрч чадлаа. Зарчмын хувьд бууруулах шийдэл гаргана. Хэдэн хувиар яаж бууруулах вэ гэдэг талаар бид яриа хэлэлцээд явж байна. Яриа хэлэлцээний тактик нарийн ширийн задалж болохгүй.

Хоёрдугаарт, үүнтэй холбоотойгоор бас Оюу Толгойн зардлыг өндөрсгөж Монголын талд оногдох ашгийг бууруулдаг, ард түмэнд өгөх үр өгөөжийг бууруулдаг асуудал бол “менежментийн төлбөр” байгаа. Менежментийн төлбөрийг бууруулахаар зарчмын тохиролцоонд хүрээд бас ажиллаж байна. Бодит үр дүнгүүд гарч байна.

- Гэтэл энэ яриа хэлэлцээний тактикт нөлөөлж болохуйц бүх материалуудыг ил тод болгох гээд байгаа нь харин хэний эрх ашигт үүсээд байгаа юм бэ гэсэн асуултууд тавьж байгаа юм.
- Яагаад та дэд сайдаараар ажиллаж байхдаа энэ Оюу Толгойн асуудлаар энэ зоригтой дорвитой шийдвэр гаргаж ажиллаж байгаагүй юм.
- Бид Хэрэг эрхлэх газар, Засгийн газарт ажиллаж байхдаа энэ зээлийн хүүг бууруулах шаардлага тавьж байсныг яагаад хэрэгжүүлээгүй юм.
- Яагаад энэ Оюу Толгойн менежментийн төлбөр, энэ үр ашгийг сайжруулж байгаагүй юм.
- Тэр үед тэр нууц байсан материалуудтайгаа бүгдтэй нь танилцаад ил болгоод ажиллуулж байгаа юм.

Яг одоо арбитрын маргаан дөнгөж эхэлж байх үед бас эхлээд. Тэгээд одоо яг энэ яриа хэлэлцээ явж байх үед бүх мэдээллийг ил тод болгох асуудал чинь Монголын эрх ашигт нийцэх юм уу.

Харин яриа хэлэлцээний дараа үүнийгээ хэлэлцэж болно. Харин яриа хэлэлцээнд тусалж Монголын талдаа үр ашигтайгаар шийдэхэд Та бүхэн туслах хэрэгтэй байна.

Тэр дээр хамтарч ажиллаач ээ гээд бид тантай уулзахдаа зээлийн хүүгийн учир шалтгаан, гадаад нөхцөл байдлууд, өөр оролцооны талаар бид танд тодорхой мэдээлэл өгч байсан. Тийм ээ.

Өмнөх яриа хэлэлцээнүүдийн талаар тодорхой мэдээллүүд өгч байсан. Энэ бол нийтийн эрх ашгийн төлөө хийгдэх асуудлууд байгаа.

Тэгээд нэмэлт хариултыг манай сайд өгнө.

Б.Пүрэвдорж: Б.Энхбаяр сайд 2 минутаар хариулах боломжтой. 1 минутаар.

Б.Энхбаяр: Оюу Толгойтой холбоотой төрийн нууцын тамгатай асуудлууд нэмж тодорч байгаа.

Тэр дотроо манай яаман дээр миний нууцын асуудлаар шийдвэрлэсэн тоон дүнг Засгийн газрын түвшинд өөрчилж мөнгө угаасан байж болзошгүй асуудал бас гарч ирж байгаа.

О.Батнайрамдал гишүүний их сайн мэддэг, таньдаг хүмүүс энэ асуудлыг үйлдсэн байх боломжтой байгаа. Гарын үсэг нь байгаа.

Тэгээд энэ асуудлыг тагнуулын байгууллагаар нууцаас гаргуулахаар би материалыг нь бэлдэж дууссан байгаа. Нууцаас гаргуулсны дараа хууль хяналтын байгууллагад илээр шалгуулна.

Б.Пүрэвдорж: О.Батнайрамдал гишүүн тодруулъя. 1 минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр тухайлан нууцаас гаргамааргүй байна. Ерөнхий сайд аа.

Тэр 20 сая доллартой холбоотой. Тэр бүгдийг нь нууцаас гаргах хэрэгтэй. Тэрний ард Оюу Толгойн 20 тэрбум долларын асуудалтай баримтууд бас нууцаас гарах ёстой.

Та баялгийн хулгайтай тэмцэж байна гээд маш том ажлын хэсэг байгуулсан. Тэр дотор нүүрснээс гадна Оюу Толгой багтаж байгаа юу? Өнөөдөр Тагнуулын ерөнхий газар түрүүчийн долоо хоногт 4 хүний баривчилгаа хийсэн байна. Асуудалтай гэдэг нь бүгдээрээ ард түмнээрээ ойлголоо.

Яагаад тэрийг нууцаас гаргаж болохгүй юм бэ? Хэрвээ нууцаас гаргахгүй бол бидний сонсгол, одоо сар хүрэхгүйн дараа явах гэж байгаа Оюу Толгой дээрх сонсгол ерөөсөө чөдөртэй, тушаатай ард түмэнд мэдэх эрхийг хангаж чадахгүй ноцтой зөрчсөн ийм л асуудал болох гээд байгаа юм.

Тэгэхээр арбитртай холбоотой асуудлыг бид огт хөндөхгүй байгаа. Манай хүрээ хязгаарт байхгүй.

Тэгэхээр танд түрүүчийн долоо хоног олгосон, бидний Хянан шалгах түр хорооноос олгосон захиа бол арбитртай холбоогүй Хянан шалгах түр хорооны хүрээ хязгаарт багтсан Засгийн газарт авсан нууцтай материал... /минут дуусав/

Г.Занданшатар: Засгийн газар авлига хулгайтай холбоотой байж болзошгүй, нэн ялангуяа арилжааны шинж чанартай гэрээ, хэлэлцээр, контрактуудыг бүгдийг нь ил тод болгосон.

Гагцхүү хоёр улсын гэрээгээр болон олон улсын гэрээгээр нууцлах хуулийн шаардлагатай гэрээнүүд нууцад байгаа. Тухайлбал, та 4 хүнийг гэмт хэргийн тухай асуудал ярьж байна.

Гэмт хэрэг мөрдөн байцаалтын нууцад хамаардаг асуудлуудыг бид нууцаас ил гаргаж чадахгүй. Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл иргэдийн мөрдөн байцаалтын асуудал мөрдөн байцаалтын нууцад хамаардаг. Тэнд хэнтэй холбоотой нь байна уу, тантай холбоотой нь уу. Хэнтэй холбоотой нь хамаагүйгээр тэнд мөрдөн шалгах ажиллагаа тусдаа. Биднээс хамааралгүйгээр явдаг. Засгийн газар, Ерөнхий сайд ч оролцох эрх байхгүй. Ил тод болгох ч эрх байхгүй. Мэдээ ч байхгүй. Мэдээлэл ч байхгүй.

Харин бид гагцхүү Монголын баялгийг, түүн дотроо Тавантолгой, Оюу Толгой. Ийм учраас Оюу Толгой дээр энэ ажиллагаа явагдаж байна шүү дээ.

Ийм учраас татвар... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Өнөөдөр Ерөнхий сайдын асуулгын цаг дээр 3 асуулт асууя гэж бодсон.

▷ **Нэгдүгээрт нь,** бид дундаж бүлэг буюу багш, эмч, нийгмийн дундаж бүлгийн хүмүүсийн цалин хөлсийг ирэх 3 жил, ер нь түүнээс цааш жил дунджаар ийм хэмжээнд хүргэнэ гэдэг тодорхой бодлогууд хэрэгтэй байна.

Тэгээд энэ жил яах аргагүй ирэх жил “БОЛОВСРОЛЫН ЖИЛ” учраас цалин хөлсийг өндөр нэм гэдэг ачаалал таны Засгийн газрын хувьд ирж байгаа нь үнэн.

Тийм учраас ирэх 3 жил ер нь цалин хөлсийг нэмэх тал дээр ямар бодлого баримталъя гэж бодож байна вэ гэдгийг нэгдүгээрт асууя.

▷ **Хоёрдугаарт нь,** Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал гээд үүнийг тэр болгон хүмүүс анзаардаггүй. Нийт төсвийн 0.5 хувь нь байх ёстой хуулиараа.

Тэгэхээр ийм зүйлийг бид хаяснаасаа болоод. Тухайлбал, би түрүү жилийн төсөв дээр маш олон удаа хэлж байсан. Ийм зардал урьдчилан сэргийлэх, хамгаалах зардал тавиач ээ гэж.

Тэгээд ёртой юм шиг III станцад осол гараад 400.0 сая төгрөгийг хэмнэж байна гэдэг аюулгүй байдалд зарцуулахгүйгээсээ болоод 100.0 тэрбумын алдагдалд бид ордог.

Тийм учраас энэ тал дээр та хөдөлмөрийн аюулгүй байдал, энэ эрүүл ахуйн асуудал дээр онцгой анхаарахгүй бол энэ өөрөө эвгүй. Бас олон хүний амь нас, осол аваартай холбоотойгоор хэт их улс төржүүлэх гээд байдаг.

Тэгээд энэ тал дээр Та хэрхэн анхаарах вэ гэдэг.

➤ **Гуравдугаарт нь**, ахмадуудын тэтгэврийн асуудал гээд бас нэг асуудал байгаа.

Тэгээд энэ тэтгэврийн нэмэлтийн асуудал яг энэ яригдаж байгаа үед нь та өөрөө байр сууриа илэрхийлж байсан. Тодорхой ахмадуудын тэтгэврийн зөрүү их байгаа үед тодорхой мөнгөн дүн, хувь гэдэг юм уу, хосолмол хэлбэрээр тавьж өгөөч ээ гэдэг энэ асуултыг маш олон ахмадууд надад тавиад байгаа. Танд ч гэсэн хүрч байгаа байх.

Тэгээд энэ тал дээр та яг ямар бодлого, шийдвэр гаргах байр суурьтай байгаа вэ гэдэг ийм гурван асуулт асууя.

Г.Занданшатар: Ер нь ирэх 3 жилд 2027 он гэхэд

- багш нарын цалин 3.5 сая төгрөг хүргэх,
- багшийн хөгжлийн хөтөлбөр,
- орон сууцжуулалтын,
- нийгмийн хамгааллын цогц төлөвлөгөө боловсруулах.

Энэ утгаараа боловсролын салбарын цогц реформ хийх, боловсролын салбарт инновац, цахим технологи, шинэ дэвшлийг ашиглах замаар боловсролын зардлыг бууруулах, үйл ажиллагааны зардлыг бууруулах замаар багш нарынхаа цалин урамшууллыг нэмэх цогц төлөвлөгөө боловсруулах даалгавар өгөөд ажиллаж байна.

MEDLE.MN-ээс авхуулаад цогц реформ хэрэгжиж байгаа. Энэ чинь 12 цаг гээд хичээлийн 30 хувийг норматив цаг, цахим, онлайн хичээлийн цаг, улсын дэлхийн хэмжээний боловсрол эзэмшүүлдэг багш нар хичээл заалгах гээд цогц реформ хэрэгжинэ.

Үүний үр дүнд багшийн ачааллыг ч бууруулна. Багшийн цалинг нэмэгдүүлэх цогц бодлого хэрэгжиж байгаа.

Ингээд ирэх 3 жилийн бодлого бол тодорхой. Энэ 5 жилийн үндсэн чиглэлдээ өгч байгаа.

Харин өнгөрсөн 3 жил та бүхэн бас яг ингэж адилхан тэмцээд ноднин жил нүүрсний үнэ өндөр байхад, уржнан жил нүүрсний үнэ 325.0 доллар байхад 10, 10 хувиар нэмээд явж байсан бол өнөөдөр 30 хувь гэж энэ төсөв, эдийн засаг хүндэрсэн, улстөр, гадаад нөхцөл байдал, шатахуун тос бүх юм хүндэрсэн

сорилт бэрхшээлийн дунд гэнэт инфляцад нөлөөлөхөөр шаардлага тавихгүйгээр урьд өмнө Та хэд маань бас жоохон тэмцэж байхгүй яав гэж би бас зарим хүмүүс хэлээд байгааг уламжилмаар байна.

Тэгэхдээ бид багш нарынхаа хүндрэлтэй нөхцөл байдлыг, нэн ялангуяа шинэ залуу багш нарын, Улаанбаатар хотын багш нарын сая 484 мянган төгрөгөөр инфляц, зардал өндөр болсон байгааг үүнийг тодорхой түвшинд хүргэж нэмэгдүүлэх бодит шийдэлд хүрээд ажиллаж байгаа. Энэ дээр Та бүхэн хамтарч ажиллаж байгаад талархал илэрхийлье.

Ирэх 3 жилд эдийн засгийн өсөлтийг бид энэ авлига хулгайтай тэмцэх, шинэ эдийн засаг бий болгох, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, засаглалын реформын 5 цогц реформыг хэрэгжүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлт... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмэлт 1 минут. С.Эрдэнэбат гишүүнд хариулт. Хариулт.

Г.Занданшатар: Өнөөдөр өргөн барьж байгаа энэ 2026-2030 онд Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтын хүрээнд цалин хөлсний тогтолцооны шинэчлэл хийе гэж байгаа юм.

Гүйцэтгэл, бүтээмжид суурилсан цогц шинэчлэл хийе. Жишээлбэл, 47 мянган хүн боловсролын салбарт 954 мянган төгрөгийн цалинтай ажиллаж байна. 58 мянган багш яг үнэн хэрэг дээрээ 52 мянган багш ажиллаж байгаагийн суурь доод цалин залуу багш нар дээр 1-ээс 4 жил ажилласан нь сая 484 мянган төгрөг байна.

Тэгэхээр ийм учраас эхний боловсролын салбарыг гүйцэтгэлээр санхүүжилт, Эрүүл мэндийн салбартаа Эрүүл мэндийн даатгалын сангийн шинэчлэл, шинжлэх ухааны байгууллагын цалинг цогцоор нь 3 жилийн хугацаанд нэмэгдүүлж, доор хаяад мянган доллар буюу 3 сая 500 мянган төгрөгт хүргэх. Тэр хэмжээгээр бүтээмжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоонд шилжих цогц шинэчлэлийг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Болдын Уянга гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Уянга: Минут яваад эхэлсэн байх шиг байна.

Ерөнхий сайдад энэ өдрийн мэндийг хүргэе.

Сүүлийн хэдэн өдрүүдэд бид Монгол Улсын Үндсэн хуулийн хэрэгжилт ер нь яг хөрсөн дээрээ хэр сайн зөв хэрэгжиж байгаа юм, бууж байгаа юм бэ гэдэг талаар тал талаас нь сайхан ярилцлаа. Бас харлаа.

Тийм ч учраас танаас энэ асуултыг заавал асуух хэрэгтэй байгаа. Монгол хүний нэр төр бол Үндсэн хуулиараа хамгаалагдсан байгаа. Бид яг Үндсэн хуулийнхаа зүйл, заалтыг харах юм бол 17 дугаар зүйлээ харж болно.

Тэгэхээр Монгол Улсын иргэн шударга хүнлэг, ёсыг эрхэмлэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн ёсчлон биелүүлнэ. Энэ үүргээ ёсчлон биелүүлнэ гэж заасан байгаа юм.

Гэтэл хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаад бидний үр хүүхдийг, хань ижлийг, садан төрлийг, энэ танхимд сууж байгаа улс төрч болгоныг янз бүрийн нэрээр нэрлээд, хочийг нь өгөөд зөвхөн шүүх тогтоох ёстой асуудлыг нэрлэн зааж нэр хүндэд нь маш бүдүүлгээр ханддаг байдал нэгэнт тогтжээ.

Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайдын хуваарь тань, мөн улс төрчийн хувиар энэ шударга явдал уу гэдгийг хамгийн түрүүнд асуухыг хүслээ.

Тэгэхээр хамгийн эхний асуулт маань энэ шударга явдал уу? Ерөнхий сайд аа.

Хоёрдугаарт, Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор Засгийн газрын 2024-2028 он үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.

Энэ төлөвлөгөөний 4.1.2.1-д хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт, хараат бус, бие даасан байдлыг хангах, тэдгээрийн редакцыг эздийн нөлөөллөөс гаргах, сэтгүүлчийн хэвлэн нийтлэх эрх чөлөө болон мэргэжлийн ёс зүйг баримтлан хариуцлагатай ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гээд Засгийн газар маань ажиллаж байх ёстой.

Тэгэхээр энэ хүрээнд Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хоёрдугаар хөтөлбөрийг боловсруулж энэ онд оруулж ирэх ёстой байгаа. Энэ ажил хэр явцтай байгаа юм оо?

Б.Пүрэвдорж: Хариулъя. Б.Энхбаяр гишүүн хариулах юм байна.

Б.Энхбаяр: Баярлалаа. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн яам боловсруулаад, Хүний эрхийн Үндэсний Комиссоос хамтарч боловсруулаад, үүнийг Засгийн газраас санаачлах уу, Улсын Их Хурлын гишүүдээс санаачлах уу гэдэг хоёр хувилбараар ярилцаад Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг боловсронгуй болгох ажлын хэсгээс санаачилж байгаа.

Үүнийг Х.Баасанжаргал гишүүн маань манлайлаад lead хийгээд Улсын Их Хуралд ойрын үед өргөн баригдах байх гэж бодож байна.

Тийм учраас Хүний эрхийн Үндэсний Комисс маань өөрөө Засгийн газраас хараат бусаар, Улсын Их Хурлаас хараат бусаар байгуулагддаг байгууллага учраас энэ бол бас Засгийн газар дангаараа мэдээж хариулах хариулт биш.

Засгийн газрын бүх асуудал хүний эрхийн асуудал байдаг. Бүх оруулж байгаа хууль тогтоомжууд хүний эрхийг бас хөндөж байгуулагддаг.

Нэр төрд халдсан гэж ярих юм бол хүний нэр төрд хамгийн их халдаж байгаа хүмүүс маань улс төрийн нам, улс төрчид байдаг. Үүнийг би олонтоо хэлж байгаа. Хэвлэлийн салбарт захиалгаар улс төрийн өрсөлдөгчөө намнадаг зах зээлийн ханш 10 дахин нэмэгдсэн байна лээ шүү. Энэ ханш яагаад нэмэгдсэн бэ гэхээр нүүрсний хулгайчид асар их мөнгөтэй болсон байна. Зөвхөн би яг өөр дээрээ тулгарсан жишээг хэлж байгаа шүү. Зөвхөн өөр дээрээ. Над дээр зүгээр нэг удаагийн сарын акц хийхэд тэрбум төгрөгийн зардал гаргаж санхүүжүүлсэн байгаа. Үүнийг Монгол Ардын намын... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут. Г.Занданшатар дарга хариулъя.

Г.Занданшатар: 1 минутад товч хариулъя.

Тэгэхээр Үндсэн хуулийн зохицуулалт бол иргэд, монгол хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг баталгаажуулсан.

Гэсэн хэдий ч энэхүү эрхийг хэрэгжүүлэхдээ бусдын нэр хүнд, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй.

Тийм ч учраас О.Алтангэрэл сайд байхдаа ч шиг санаж байна. Хүн гүтгэхийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох хууль өргөн барьж байсан. Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа байх.

Гэхдээ ерөөсөө –

- ▶ үг хэлэх эрх чөлөө,
- ▶ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ардчилсан нийгмийн гол үндэс.

Улс төрчид түмний хараанд байдаг учраас мэдээж дандаа шүүмжлэлд өртөж байдаг. Би есөн шидээр гүтгэж, доромжлуулж, зөндөө л хэлүүлж байсан боловч нэг ч удаа цагдаад шүүхэд хандаж байсангүй.

Яагаад гэвэл хууль эрх зүйн орчин нь ийм учраас. Тэгэхдээ ер нь ил тод байдал, иргэн нь илүү мэдээлэлтэй байх нь эрүүл нийгмийн эх үндэс гэж үзнэ. Харин үнэхээр хүнийг гүтгэж доромжилж байгаа бол хууль шүүхийн байгууллагадаа хандаад шийдвэрлэх эрх нь одоо нээлттэй байгаа.

Б.Пүрэвдорж: 1 минутаа аваагүй юу? Б.Уянга гишүүн 1 минут нэмж авъя.

Б.Уянга: Тэгэхээр шударга биш гэж үзэж байна гэж ойлголоо.

Тэгвэл яг энэ сая миний дурдсан Засгийн газрын 2024-2028 он үйл ажиллагааны хөтөлбөрт дараах хуулиудыг 2025 онд Монгол Улсын Засгийн газар Их Хуралд өргөн барих ёстой байгаа.

- ➔ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- ➔ Хууль сахиулах ажиллагааны тухай,
- ➔ Таслан сэргийлэх ажиллагааны тухай,
- ➔ Шүүхийн шинжилгээний тухай.

Энэ хуулиудыг яагаад 2025 онд өргөн барих ёстой вэ гэж үзсэн гэхээр хүний эрх, хүний нэр төрд бүдүүлгээр хандаж байгаа явдал газар авсан байна гэсэн байгаа юм. Энэ хариултыг Монгол Улсын Ерөнхий сайд өөрөө хариулаасай гэж хүсэж байна.

Тэгээд энэ асуултад хариулж өгнө үү.

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултад хариулъя.

Б.Энхбаяр: Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлах нь буруу юм байна гээд Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатараар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаад нэг жил болсон байгаа.

Миний ойлголтоор энэ хуулийн төсөл боловсрогдож дууссан гэж ойлгосон.

Тэгэхээр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан энэ ажлын хэсэг хийсэн юм байна.

Ер нь Их Хурлын даргаас ийм тавин хэдэн ажлын хэсэг байгуулдаг чинь Засгийн газрыг бас ажиллах бололцоогүй болгоод байгаа шүү дээ. Хэвлэл мэдээллийн хуулийг Засгийн газар санаачил гээд ажиллаж байдаг. Энд Их Хурлын гишүүдээр мөн бас нэг ажлын хэсэг ажиллуулдаг. Хэн нь өргөн барих юм. Бие бие рүүгээ жихдэг, эзэнгүйдүүлдэг ийм асуудал үүсгэсэн байгаа шүү.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 30 минутаас хэтрэхгүй.

Одоо Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна. Асуултын хугацаа 2 минут. 1 минутаар нэмж асуулт асууж, үг хэлж болно.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу? Сайн байна.

Эрхэм Ерөнхий сайдын энэ өдрийн амрыг айлтгая. Тэгээд өөрийнхөө асуултыг асууя.

Тэгэхээр гурван асуулт бэлдсэн ч гэсэн бусад гишүүдтэй санал маань давхцаж байгаа учраас нэг л асуултыг онцлон асууя гэж бодлоо. Энэ хуулийг иргэний нийгмийн байгууллагууд, иргэд нэлээн хүсэж, эрэлхийлж байгаа учраас тэдний хүслийг дэмжиж үүнийг асууж байгаа юм.

Тэгэхээр Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн тухай нэмэлт мэдээлэл авах зорилготой асуулт.

Дэлхий дээр НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нэгдсэн 140 гаруй улс байдаг. Та сайн мэдэж байгаа байх. Үүнээс 59 нь Шүгэл үлээгчийн тухай хуулийг хэрэгжүүлдэг.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцод 2005 онд нэгдэн ороод Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Тус конвенцын 33 дугаар зүйлд оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоогдсон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн орчинд, тогтолцоонд нэвтрүүлэх, мөн заан оруулах асуудлыг авч үзнэ гэж тунхагласан.

2021 оны 11 дүгээр сарын 11-нд Засгийн газрын хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурал нэг жилийн дараа буюу 2022 оны 10 дугаар сард хэлэлцээд энэ бол чухал ач холбогдолтой хууль мөн гэж үзээд хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт шилжүүлсэн байдаг. Энэ үед бас Г.Занданшатар Ерөнхий сайд та даргалж байсан юм байна лээ.

Тэгэхээр энэ хууль одоо хүртэл батлагдаагүй байна. Та энэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг батлуулах чиглэлээр ямар ахиц гаргах амлалт өгч чадах вэ гэсэн тодорхой асуултыг асууя.

Г.Занданшатар: Баярлалаа. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг анх бид Авлигатай тэмцэх газарт санал болгож, тэндээс төслийн анхны

хувилбарыг боловсруулж, өргөн бариулах ажлыг зохион байгуулж, энэ чухал хуулиа гэж үзэж ажиллаж байсан юм.

Тэгээд харамсалтай нь энэ хууль бүлгүүдийн түвшинд дэмжигдэж чадаагүй, хэлэлцэгдэж батлагдаагүй.

2025 онд энэ хуулийг бид дахин өргөн барьж хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Ер нь Монгол Улсад авлига, хулгай, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлсэн иргэдийг хамгаалах, дэмжих эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль тогтоомж одоогоор байхгүй байна.

Энэ дээр томоохон хэрэг явдлууд дээр, нүүрсний хулгай ч гэдэг юм уу жагсаал цуглаан болоод л байдаг. Томоохон хэргүүд дээр шүгэл үлээх зориг гаргасан иргэдийг дарамт, өш хонзон, гэмт хэргийн хохирогч болох эрсдэлд оруулж байна гэж олон улсын байгууллагууд үзсэн байдаг.

Ийм учраас шүгэл хүлээгчийн эрх зүйн байдлын анхдагч хуулийн төслийг боловсруулах үйл явц хэд хэдэн үе шаттай өрнөж байгаа. Энэ бол Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй хамт явж байгаа бөгөөд авлигын талаар мэдээлсэн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлох, хамгаалах, урамшуулах, зохицуулах тогтолцоог бүрдүүлэх чиглэлтэй хамт явж байгаа.

Энэ төслийн гол агуулга бол аюулгүй байдлыг нь хамгаалах, эрсдэлд учрахаас хамгаалах, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх зүйн баталгааг бий болгоно.

Хамгаалалт дэмжлэг үзүүлнэ. Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлага татах, дарамтлахаас хариуцагчийг хамгаалах, мэдээлэгчийг хамгаалах.

Урамшууллын тогтолцоо. Их хэмжээний авлигалын ч юм уу, мөнгө тарааж байгаа асуудлуудыг мэдээлээд, түүнд нь төлбөрийг нь тодорхой хувиар урамшуулдаг байх гэсэн зохицуулалтыг хийж байна.

Энэ хуулийг 2025 онд өргөн барихаар Засгийн газрын саяын 7 сарын 03-ны 02 дугаар тогтоолоор үүрэг болгосон байгаа. Авлигатай тэмцэх багц хуулиудын хүрээнд. Энэ бол бодитой шинэчлэл болно. Иргэдийнхээ эрх, аюулгүй байдлыг хамгаална.

Одоо энэ Хууль зүй, дотоод хэргийн сайд... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут.

Г.Занданшатар: Одоо манай Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилогдсон Б.Энхбаяр гишүүн ч гэсэн шүгэл үлээгч.

Монгол Улсын Засгийн газар ч гэсэн өөрөө бас шүгэл үлээж байгаа. Ингэж байж бид нийтийн дунд бий болсон ард иргэдийнхээ хүсэл эрмэлзлийг илэрхийлж байж шүгэл үлээж байгаа Засгийн газар ч гэсэн шүгэл үлээгчээ хамгаалах болно. Шүгэл үлээгчдээ хамгаалах болно. Гагцхүү энэ нь бодитой, хэн нэгний эрх, иргэний эрхийг гутаах доромжлоход чиглэгдсэн биш бодитой байх ёстой. Нийтийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн байх ёстой.

Ийм учраас эрх зүйн зохицуулалт, нарийн зохицуулалт, хамгаалалт шаардсан хуулийн төсөл байх ёстой гэж үзэж байгаа.

Б.Пүрэвдорж: 1 минут тодруулъя.

Б.Мөнхсоёл: Товчхон базаад хэлэхэд ер нь энэ хууль эрх зүйн орчин бүрдсэнээр хамгийн гол нь хүний эрхийн хуулийн хэрэгжилт биелэх нөхцөлийг илүү бүрдүүлэхээс гадна ямар ч иргэн төрийн үйлчилгээг бидний хэлж заншсанаар арын хаалгагүйгээр тэгш хүртээмжтэй авах бололцоо нэмэгдэнэ.

Улмаар аль аль тал нь хариуцлагатай байснаар төрд итгэх итгэл хамгийн гол нь нэмэгдэх юм. Хамгийн макро түвшиндээ товчлоод хэлэхэд Монгол Улсын хөгжлийг л дагуулна. Нийгмийн эрүүл амьс уур амьсгалыг бий болгоно. Бие биеэ хардах.

Түрүүний Б.Уянга гишүүний хэлсэнчлэн онлайнаар бие биеэ bullying-дэж элдэв нэр төрд нь халдах гэх мэт бүх асуудлуудад дорвитой нэмэр болохуйц хууль учраас энэ асуудлыг шийдэхэд гар бие оролцон энэ санаачилгыг хэрэгжүүлэх байх гэж найдаж байна. Итгэж байна. Баярлалаа. Хариулсанд.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ.

Миний урилгаар Ховд аймгийн Цэцэг сумын эрх чөлөөний төлөө цогтой тэмцэгч Ард Аюушийн нэрэмжит 12 дугаар сургуулийн сурагчид ирсэн байна.

Тэгээд Та бүхэндээ сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж, ирэх жилийнхээ элсэлтийн ерөнхий шалгалтад сумаа төлөөлж Ховд аймагт хамгийн өндөр оноо авч тэргүүлээрэй гэж хүсэн ерөөе. /алга ташив/

Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Уянгахишиг: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр миний хувьд нэг асуулт тавьсан байгаа. Хоёр хуваагаад асууж болно шүү дээ. Тийм ээ. Б.Пүрэвдорж дарга аа.

Одоо бид нүүрсний хулгай гээд яриад байгаа. Өмнө нь чуулган дээр ч гэсэн би дурдаад өнгөрсөн. Энэ бүх нүүрсний хулгайтай холбоотой асуудал цэвэр “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компанийг тойрч байгаа асуудал.

Өөрөөр хэлэх юм бол “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компани дээр санхүүгийн удирдлага, хяналт муу. Нөгөө талаасаа тухайн компанийн ашигт ажиллагааг үл хамааран бусад ямар ч төслүүд рүү нүүрсээр төлбөр хийх, бартер хийх энэ боломжуудыг бий болгодог. Offtake гэрээнүүд байгуулдаг.

Энэ шийдвэрүүд нь Их Хурлаар дамждаггүй, Засгийн газраас томилогдсон төлөөлөн удирдах зөвлөл, мөн тэндээс томилогдсон улс төрийн томилгоогоор очсон гүйцэтгэх удирдлагын түвшинд хийгддэгтэй шууд холбоотой гэж харагдаж байгаа.

Энэ тухайд жишээлбэл “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2025 оны бизнес төлөвлөгөө дээр свот шинжилгээ дээрээ сул талаа яг тэгж дурдсан байгаа. Юу гэхээр улс төрийн шийдвэрээр нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний өр тавьж, байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн дарамт учруулсан, хүний нөөцийн шууд томилгоо их байдаг. Олборлолтын 100 хувийн гэрээт операторуудаар хийлгэж байгаа буюу өөрсдөө оператороо хийх боломж байдаггүй.

Нүүрс олборлолтыг нэмэгдүүлэх, борлуулалтыг өсгөх боломжтой ч Хятад талын хилийн нэвтрүүлэх хүчин чадлаас хамааран энэ нь өөрөө хязгаарлагддаг.

Тэгэхээр миний асуулт юу вэ гэхээр Улсын Их Хурлын тогтоолын 2010 оны 39 дүгээр тогтоол байгаа. Энэ тогтоолоор Эрдэнэс Тавантолгойг байгуулсан байдаг. Тэгвэл “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр юу гэж яригдаж байсан бэ гэхээр 50 хувийг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжид дараах хуваарийн дагуу. Энэ нь 10 хувийн нийт иргэнд үнэ төлбөргүйгээр хувьцааг нь шилжүүлнэ. 10 хувийг нь аж ахуйн нэгжүүдэд үнэ төлбөргүй шилжүүлнэ. 30 хүртэл хувийг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж өгье.

Г.Уянгахишиг: Гуравдугаарт, 30 хүртэл хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж хөрөнгө босгох гэдэг ийм гурван шийдвэрийг гаргасан байдаг.

Гэтэл эхний хоёр нь биелсэн боловчиг одоо 15 жилийн дараа гэхэд 3 дахь заалт огт хэрэгжээгүй.

Тэгэхээр огт хэрэгжээгүй шалтгаан нь “нээлттэй компани” болоход гадаад, дотоодын аль ч хөрөнгийн бирж дээр гарсан төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд засаглалын болоод бүх шаардлагуудыг нь хангаж чаддаггүй.

Тэгэхээр энэ тал дээр –

- Засгийн газар ямар бодлого авч хэрэгжүүлэх вэ?
- Энэ сул талуудыг байхгүй болгох дээр яаж хэрэгжүүлэх вэ буюу хэрхэн нээлттэй компани болгох вэ?
- Хэрхэн гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг оруулж ирэх вэ?
- Хувьчлалыг хэрхэн зөв явуулна гэж харж байна вэ?

Г.Занданшатар: Засгийн газраас авлига, хээл хахуультай тэмцэх, нүүрсний хулгайтай тэмцэхийн тулд цогц бодлого хэрэгжүүлж байгаа гэсэн.

Бодлогын орчинд нээлттэй, ил тод байдлыг бий болгож, компаниудыг хувьчлах, олон нийтийн хяналтад оруулах, олон нийтийн компани буюу PUBLIC COMPANY болгох ийм зорилтыг хэрэгжүүлж байгаа. Ийм зорилт тавьж ажиллаж байгаа.

Энэ хүрээнд нүүрсний хулгайтай холбоотойгоор төрийн өмчийн компаниудын үйл ажиллагааны ил тод бус байдал, менежмент, хариуцлагагүй байдлаас үүдэлтэй governance проблем бий болсон юм билээ.

Ийм учраас “Эрдэнэс Тавантолгой” дээр бид эхний ээлжид нээлттэй хувьцаат компани болгох цогц төлөвлөгөөг боловсруулж байна.

Цагаан сараар энэ төлөвлөгөөгөө зарлаж боловсруулж, хэрэгжүүлэх даалгавар өгсөн. Үүний тулд Та бүхнийг төсөвтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолыг баталж өгөхийг хүсэж байна.

Энэ тогтоолын дагуу бид нээлттэй хувьцаат компани болохын тулд олон улсын эрх бүхий компаниар аудит хийлгэсэн байх ёстой болж байгаа юм. Аудиталж байж. Тэгээд олон улсын стандартад нийцүүлэх ёстой. ISO стандартаар паблик компанийн бүх стандартыг нийцсэн засаглалын шинэ стандартыг бүрэн нэвтрүүлж дуусах ёстой.

Энэ тохиолдолд “Эрдэнэс Тавантолгой” маань олон нийтийн хувьцаат компани болох нөхцөл боломж бүрдэнэ. Үүний тулд дотоодын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа бүртгүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн орчинтой нийцүүлсэн үе шаттай төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Улсын Их Хурлаар ч гэсэн бас өөрчлөлт оруулах, батлуулах асуудал гарч байна.

Саяын дурдаж байгаа тогтоолууд чинь гарсан Тавантолгойн 10, 20 тогтоолын зөвхөн нэг нь.

Тэгээд хамгийн сүүлд 2024, 2025 онд дахиад өөрчлөөд тогтоол батлаад хувь хувьцааг нь өөрчлөөд дахиад. Тэгэхдээ л нээлттэй компани биш.

1072 гэж үнэн хэрэг дээрээ бодитой оролцдоггүй. Ард иргэд хяналт тавьж чаддаггүй тийм хиймэл хувьцаа болоод байна.

Жинхэнэ PUBLIC COMPANY үнэхээр 1072 хувьцааг нь эзэмшиж байгаа юм бол –

- Монгол Улсын иргэн бүх 3 сая 500 мянган иргэний хяналтад орох ёстой. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй болох ёстой.
- Үйл ажиллагаа нь шилэн болох ёстой.
- Ард иргэдийн хяналт, төлөөлөн удирдах зөвлөлд нь орж ирэх ёстой.

Ингэж байж төлөөлөн удирдах зөвлөл ард түмний компани гэсэн паблик нээлтэд орох ёстой. Ийм цогц... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут сунгая.

Г.Занданшатар: Тийм учраас цогц шинэчлэлийг хийж байна.

Энэ дотор тэгэхдээ олон асуудлууд деталиуд дээр байна. Жишээлбэл, шинээр төрсөн болон харьяат болсон иргэдэд хувьцаа эзэмшүүлэх эсэх асуудал. Тэр чинь тэр өдрөө тасалбар болгоод хойш төрсөн иргэд нь эзэмшихгүй байгаа байхгүй юу.

Бас нэг хэсэг иргэд нь ахмад настны болон сургалтын төлбөр төлсөн гээд хувьцаанаас хассан. Ийм зөрүүтэй асуудлууд үүсээд, иргэдийн өмчлөлтэй холбоотой суурь асуудлуудыг Улсын Их Хурлын түвшинд шийдвэрлэхгүй бол Засгийн газрын түвшинд шийдвэрлэх боломжгүй болоод хоёр дахь зах зээлд хувьцааг нь гаргах боломж хязгаарлагдаад байгаа юм.

Энэ компанийн засаглалыг ч гэсэн олон улсын түвшинд засаглах боловсрол чадвартай төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагыг энэ зорилгоор бүрдүүлэхийн тулд Засгийн газраас одоо бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөл томилж байгаад одоо яг энэ ажлыг хийх чадвартай менежментийн баг шалгаруулах сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Улс төрчид томилдог биш нээлттэй сонгон шалгаруулалтаар энэ үүргийг хэрэгжүүлж чадах удирдлагын баг CEO[Chief Executive Officer-Гүйцэтгэх захирал]-Г ТОМИЛОХ ийм ажлыг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Болсон. Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Би танаас багш нарын цалинтай холбоотой асуулт асуух гэж байна.

Гэхдээ яг одоо хэдээр нэмэх юм, ямар боломжтой. Тэр тухай биш. Ер нь иймэрхүү асуудлыг яаж шийдэж байх вэ гэдэг дээр зарчмын байр суурь, ер нь бодлогын шийдлийг яаж хийх талаар асуух гэж байгаа юм.

Зүгээр яах вэ манай үе үеийн Засгийн газрууд нам харгалзахгүйгээр дандаа алдаа хийж ирсэн нь бодлого гээд бүх хүслийнхээ жагсаалтыг баталчхаад асуудлаа эрэмбэлэхгүйгээр төсвөө тухайн үеийнхээ байдлаас хараад зоодог.

Эцсийн дүндээ яг эрэмбийн дээгүүр гэгдэж байгаа ажлууд хоцорсон байдаг. Энэ бол яг багш, эмчийн цалинтай холбоотой асуудал байна. Үүний цаана жагсахгүй байгаа ч гэсэн бас дараагийн ээлжид цалин нэмүүлэхийг хүлээж байгаа тийм олонлогууд байгаа.

Тэгээд яг жагссан нь нэмүүлдэг, эсвэл тухайн үедээ чанга дуугарсан нь нэмүүлдэг. Энэ бол бодлого биш тухайн үеийнхээ асуудалд чирэгдэж байгаа гал унтрааж байгаа явдал болоод байгаа юм.

Тийм болохоор цаашдаа яг үүнийг жагссан үед нь биш, дуулиан болгож биш, нэлээн урт хугацаагаар зөвхөн ирэх жилийн асуудал биш, ирэх 3-аас 5 жилийн хугацаанд асуудлаа эрэмбэлж байгаад үнэхээр чухал гэж үзэж байгаа бол багшийн ч юм уу, эмчийн ч юм уу, төрийн албан хаагчийн ч юм уу, хэнийх нь ч байна цалинг нэмэх бодлогыг тууштайгаар баталчхаад түүнийхээ дагуу гишүүд нь болон иргэд, багш, эмч нар нь эсвэл цалин авах гэж байгаа иргэд нь хяналтаа тавиад явдаг энэ бодлогыг Та яаж хийх вэ? Энэ бол хийнэ гээд хэлэхэд амархан боловч яг үнэндээ Монголын улс төрд, бидний шийдвэр гаргаж байгаа түвшинд жишиг болоогүй асуудал байгаа.

Тэгээд энэ дээр яах аргагүй Засгийн газрын зүгээс дорвитойхон шиг урт хугацааны, дунд хугацааны тоотой, дүнтэй тийм бодлогын шийдвэр гаргах юм бол Их Хурлын зүгээс ч гэсэн хянаад явах боломж байна. Энэ дээр та ямар өөрчлөлт хийх гэж байна вэ?

Г.Занданшатар: Бид Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиа уншиж сайн ойлгомоор юм билээ.

Нэн ялангуяа төсөв, эдийн засгийн чиглэлээр ажиллаж байгаа гишүүн Та үүнийг барьдаг, хэрэгжүүлдэг байхгүй бол нэг ийм бодлогын зөрүү гараад Их Хурал дээр ч гэсэн хэлэлцүүлгийн дараа алдагдаад байна.

Бид Үндсэн хуульд хөгжлийн бодлого тогтвортой байна гэж 2019 онд өөрчлөлт оруулаад, үүний дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг баталсан юм. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар 5 жилийн үндсэн чиглэлээ батална.

Одоо манай Засгийн газар 2026-2030 онд хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл орж байна. Энд үр дүнд чиглэсэн цалингийн бодлого, шинэчлэлээ цогцоор нь оруулаад явж байгаа.

Энэ дээр үндэслээд жилийн төлөвлөгөө баталдаг, Улсын Их Хурал. Жилийн төлөвлөгөөн дээр эрэмбээ тогтоодог байхгүй юу.

Наад яриад байгаа хөрөнгө оруулалт, урсгал зардал, багш, эмч нарын. Үүнийг Их Хурлаар тогтоож байгаа.

Гэтэл 4, 5 сард баталсан байгаа жилийн төлөвлөгөөнд чинь энэ асуудлууд тусаагүй байхгүй юу. Харин гишүүд нэмээд нэмээд баахан хөрөнгө оруулалтууд тойрог тойргийн шинж чанартай орж ирээд энэ эрэмбээ алдаад байгаа юм.

Энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиа хаана хаанаа зөв хэрэгжүүлбэл жилийн төлөвлөгөөнд туссан багш, эмч нарын цалингаа нэмэгдүүлье, энэ төлөвлөгөө тусгаж явах ёстой.

Тэгтэл харамсалтай нь –

- Засгийн газар 3 жилийн 3 талт хамтарсан хэлэлцээр үйлдвэрчний эвлэлтэй байгуулчхаад,
- 30 хувиар нэмнэ гэж тохирчхоод –
- сүүлийн 3 жил жилийн төлөвлөгөөндөө ч оруулаагүй,
- 5 жилийн төлөвлөгөөндөө ч оруулаагүй,
- төсөвтөө ч оруулаагүй

явж ирсэн. Мэдээж жил болгон нэмэгдүүлж байсан. Энэ бол Боловсролын хуулиар тусдаа хэрэгжүүлсэн. Боловсролын салбарт бол хуваарь бий.

Ийм учраас жилийн төлөвлөгөө дээр үүнийгээ тусгаад, жилийн төлөвлөгөөний дагуу төсөв өргөн барьж эрэмбэлж орж ирж байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө бүх зүйлийг нь хашсан шүү дээ. Жилийн төлөвлөгөөгөөр чинь 24 хувь байна. Урсгал зардал. Тийм тийм багш, эмч нарын цалин нэмж болохгүй гэсэн агуулгатай 24 хувьд барьсан байхгүй юу. Яагаад... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Б.Найдалаа гишүүн 1 минут тодруулъя.

Б.Найдалаа: Тантай санал нэг байна. Гол нь яг үүнийг л асуугаад байгаа юм.

Асуудлаа эрэмбэлээгүй байж байгаад засаг нь өөрөө төсвөө өргөн барьж байгаа бодлогоо дэвшүүлж байгаа газар нь тэрийгээ хаячхаад, эргээд сүүлд нь жагсахаараа асуудлаа тулдаг ерөөсөө болохгүй болоод байгаа юм байна.

Тийм болохоор Их Хурал гэхээсээ илүү Засгийн газрын зүгээс энэ дээр яг тэр төлөвлөгөөгөө гаргахдаа, төсвөө зоохдоо дуулиан болгохгүйгээр нэмээд байх юм бол үнийн өсөлт, инфляц нь ч илүү зөв байгаа юм.

Тэгэхээр энэ дээр л яг үнэндээ нэгэнт боосон, зангидсан төсөв дээр одоо ярихаар түр хугацааны гал унтраах болж байгаа. Тэрийг та сайн мэдэж байгаа. Зүгээр таны бие юу хүсэж байна гэхээр Засгийн газар таны саяын хэлснээр төлөвлөгөөндөө оруулж байгаад тодорхой дүнтэй, дуулиан болохгүйгээр энүүхэндээ батлаад, тэрийгээ хянаад явах юм бол үр дүнтэй юм билээ.

Тэгээд зөвхөн эмч, багш нарынх биш, цаашдаа бусад салбарын цалингууд асуудал байгаа юм.

Дараагийн асуултыг дарга аа, яах билээ? Дахиад нэг асуулт байгаа юм. Тусад нь авна. Тийм ээ.

Б.Пүрэвдорж: 1 минут хариулъя.

Г.Занданшатар: Ер нь төсвийн цаглавруудаа зөв болгохгүй бол төсвийг 9 сарын 01-нд өргөн барьдаг болсон.

Тэгтэл бидний хийж байгаа ажлын гүйцэтгэл 9 сарын эцсийн дүнгээр түүхэндээ байхгүй өндөр рекордын хэмжээ нүүрс экспортоллоо. Биет хэмжээгээрээ. Манай улсын зээлжих зэрэглэл Standard & Poor's, BB болгож 13 жилийн түүхэнд анх дээд хэмжээндээ хүрлээ.

Мөн Fitch агентлаг зээлжих зэрэглэл өслөө. Ингээд үр дүнгүүд гараад, төсвийн орлого нэмэгдээд цалин нэмэх боломж жоохон ч гэсэн бий болж байна.

Гэтэл 9 сарын 01-нд өргөн барихад бид дөнгөж 3 сар ажиллаж байхад шал ондоо байсан. Тэгтэл бас төлөвлөлт нэг талаасаа зөв боловч манайх шиг уул уурхайгаас хамааралтай, гадаад зах зээлээс хамааралтай цөөхөн хэдхэн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнээс хамааралтай.

Экспортын бүтээгдэхүүн чинь үндсэндээ нүүрс, зэс хоёрын үнээс хамааралтай эдийн засагт чинь энэ хоёр нь өөрчлөгдөхөд л бүх төсвүүд савлаад байгаа байхгүй юу.

Бүх орлого унаад л, бүх эдийн засаг өөрчлөгдөөд л төсвийн төлөвлөлтийг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын асуулгын цаг дууслаа.

Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Ерөнхий сайдад талархал илэрхийлье.

Хэлэлцэх асуудлын хоёр буюу Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудал, Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал.

Энэ хоёр асуудал нь би Их Хурлын гишүүдэд тодорхой мэдээллийг хүргэх ёстой. Даргын зөвлөлийн хурал дээр болсон үйл явдлыг.

Тэгэхээр өнөөдөр энэ хэлэлцэх тухай асуудлыг 13 цаг 34 минут буюу чуулган эхлэхээс 26 минутын өмнө Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очироос Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах, сонгох, мөн даргын үүрэг хариуцуулах тухай тогтоолын төсөл хэлэлцэх саналыг даргын дэргэдэх зөвлөлд оруулсан.

13 цаг 45 минутад чуулган эхлэхээс 15 минутын өмнө 16 гишүүнээс 9 гишүүд дэмжиж, энэ асуудал хэлэлцэх асуудлын дараалалд орсон байгаа.

Мөн 15 цаг 35 минутад Үндсэн хууль зөрчсөн асуудал дэгийн тухай хуулийн 85 дугаарт заасны дагуу долоо хоногт хэлэлцэх ёстой. Өнөөдөртэй хэлэлцье гэж манай Ц.Сандаг-Очир дарга бичсэн байгаа.

Тэгэхээр Байнгын хороогоор цэцийн дүгнэлтийг хэлэлцэх ийм агуулга харагдаж байна гэж үзэж байгаа.

Тэгэхээр дэгийн тухай хуулийн 35.1-д тогтоолын төсөл, түүнд хавсаргасан бичиг баримтыг Байнгын хороонд хүргүүлснээс 3 хоногийн дотор бүх материалыг өгөх ёстой. Гэвч өнөөдөр энд сууж байгаа бүх Их Хурлын гишүүд өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх тогтоолын төсөл, түүний саналын томъёолол. Үүнийг бүгд мэдэхгүй байна. Бичиг баримтыг нь мэдэхгүй байна.

Хоёрдугаарт нь, Их Хурлын гишүүд Байнгын хороон дээр санал гаргахдаа заавал урьд өдрийн 17.00 цагаас өмнө Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гаргах тэр эрхийг нь нээж өгөх ёстой. Гэвч энэ бүх зүйл өнөөдөр асуудал нь орж ирсэн учраас гишүүдийн эрхийг хааж байна гэж үзэж байна.

Нэгэнт Төрийн байгуулалтын байнгын хороо энэ цэцийн дүгнэлтийг хэлэлцэж байгаа юм бол дэгийн тухай хуулийн 85.1.1-д Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хороо цэцийн дүгнэлтийг

хэлэлцэж санал, дүгнэлт гаргаж, тэрнийг нь чуулганы хуралдаанаар хэлэлцэх ёстой.

Гэтэл одоо хүртэл Хууль зүйн байнгын хорооны чинь хуралдах тов гараагүй байна.

Тийм учраас энэ олон олон асуудлаар индэр дээрээс намайг бас энэ дэгийн тухай хууль зөрчүүлэх ийм юмыг.

Тийм учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлаас энэ дэгийн тухай хууль дээр даргын дэргэдэх зөвлөлийн гишүүдийн саналыг харгалзан дарга буюу хуралдаан даргалагч хэлэлцэх асуудлыг батална гэж заасан байгаа. Энэ “харгалзан” гэж заасныг үндэслээд өнөөдрийн хоёр асуудлыг Байнгын хороо хэлэлцээгүй. Бичиг баримтаа ирүүлээгүй. Гишүүдэд тогтоолын төсөл болон бусад холбоотой бичиг баримтыг өгүүлээгүй. Мөн түүнчлэн тухайн асуудалтай холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргах тэр боломжийг нээж өгөөгүй гэдэг ийм олон шалтгаанаар дэгийн хуулийг зөрчих учраас хэлэлцэх асуудлын хоёр, гурав дахь асуудлыг хаслаа. /алх цохив/

Одоо намайг энэ П.Сайнзориг гишүүн, А.Ариунзаяа гишүүн хоёр цэцэд дэг зөрчсөн гээд өгсөн байгаа. Дахиад юм нэмж өгүүлэх гээд Та бүхэн чинь бүгдээрээ ингээд яваад байгаа юм.

Би одоо энэ хурлыг жоохон чөлөөтэй, маш хурдан энэ Их Хурлыг явуулаад гацаанаас гаргах тийм л үүрэгтэй байгаа.

Тийм учраас Байнгын хорооны тогтоолын төсөл, тэр бүх зүйлийг хоёр дахь өдөр хэлэлцүүлээд, гурав дахь өдөр чуулганы хуралдааныг ээлжит бусаар хуралдуулаад хурдан хурдан шийдээд танай тэр дэд даргад чинь энэ эрхийг чинь өгөөд ингээд би ийшээ суумаар байна. Тэгэхдээ үүнийгээ дэгийн дагуу хийе ээ л гэж байна шүү дээ.

Тэгэхдээ нэг зүйлийг. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлын даргыг огцруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Тэгээд үүнийг хэлэлцэхдээ заавал цэцийн дүгнэлттэй байна. Цэцийн дүгнэлт бол Үндсэн хууль зөрчсөн байна л гэсэн ийм зүйл гаргасан.

Тийм учраас үүний дагуу тодорхой хэмжээгээр хариуцлага тооцох тухай асуудлыг Улсын Их Хурал заавал хэлэлцэх ёстой.

Тийм учраас одоо ингээд дэг зөрчсөн асуудлаар П.Сайнзориг гишүүн намайг цэцэд өгсөн байгаа. А.Ариунзаяа гишүүн өгсөн байгаа.

Тийм учраас би гав ганцаархнаа очно. Та нар бүгдээрээ очоорой. За.

Хэлэлцэх асуудлын дөрөв. С.Ганбаатар гишүүнийг дуудаарай. С.Ганбаатар гишүүн.

Өчигдөр Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг санал хураалтыг нь хойшлуулсан байгаа.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах санал. Үргэлжлүүлэн хэлэлцье.

Хоёр. Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай
/үргэлжилнэ/

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

1. Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. /алх цохив/

Санал хураалтад 101 гишүүн оролцож, 3 гишүүн дэмжиж, 3 хувьтай гарлаа. Хүсэлт дэмжигдсэнгүй.

2. Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. /алх цохив/

101 гишүүн оролцож, 1 гишүүн дэмжиж, 1 хувьтай. Ц.Даваасүрэн гишүүн дэмжсэн байна. Протоколд тэмдэглүүлж байна.

3. Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн

хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. /алх цохив/

101 гишүүн оролцож, 98 гишүүн татгалзаж, 3 гишүүн дэмжиж, 3 хувиар санал дэмжигдсэнгүй.

4.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасныг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. /алх цохив/

101 гишүүн оролцож, 3 гишүүн дэмжиж, 98 гишүүн татгалзаж, 3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн асуудал. Чуулганы нэгдсэн хуралдаан дээр олонхын дэмжлэг авсан асуудлаар Үндсэн хуулийн цэцэд гаргах хүсэлт байхгүй. Албан бичгээр очихооргүй болж байна.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Даргын зөвлөл асуудлаа тавиад саяын цэцийн дүгнэлтийн асуудлыг яг хугацаанд нь чанартай хэлэлцэх, ялангуяа хоёр дахь өдөр хуульд тааруулаад хэлэлцэх асуудлыг шийдээрэй. Ингэсний үр дүнд бүлгээс сонгогдох дэд даргыг яаралтай сонгох ажил байна.

Хуралдаан 2 цаг 57 минут үргэлжилж, 16 цаг 57 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД